



ГОЛОМТ БАНК



ЖИЛИЙН ТАЙЛАН 2007

АГУУЛГА

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргын мэндчилгээ	2
Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	4
Эдийн засгийн тойм	8
Банкны системд эзлэх Голомт банкны байр суурь	12
Байгууллагын хөгжил	14
Хэтийн Зорилго, Эрхэм Зорилго	14
Бүтэц зохион байгуулалт	15
Компанийн засаглал	16
Хүний нөөц	21
Дэд бүтэц	24
Үйл ажиллагааны тойм	25
Иргэдэд чиглэсэн бизнесийн үйл ажиллагаа	25
Байгууллагуудад чиглэсэн бизнесийн үйл ажиллагаа	29
Гадаад төлбөр тооцоо	30
Нөөцийн болон арилжааны үйл ажиллагаа	31
Санхүүгийн үр дүн	32
Эрсдэлийн удирдлага ба хяналт	38
Нийгэмд чиглэсэн арга хэмжээ	45
Бүтээгдэхүүн, үйлчилгээ	46
Салбарын сүлжээ	48
Хараат бус аудиторын дүгнэлт	51
Санхүүгийн тайлангууд	53

Голомт банк улс орныхоо эдийн засгийн өсөлтөд өөрийн хувь нэмрийг оруулж, арван гурав дахь жилийнхээ ойг амжилтын арвин ургацтай угтлаа.

Д.Баясгалан, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Дарга

Эрхэм хүндэт хувь нийлүүлэгчид, харилцагчид, харилцагч банкууд, бизнесийн түншүүд, үнэт ажиллагсад танаа

Банкныхаа Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргын албыг авснаас хойших анхны жилийн тайланг толилуулж байгаадаа туйлын баяртай байна.

2007 он Монгол орны минь хувьд эрчимтэй өсөлтийн жил болж, улсын төсөв 3 дахь жилдээ ашигтай гарсны зэрэгцээ гадаад валютын нөөц нэмэгдэж, Дотоодын Нийт Бүтээгдэхүүн 9.9 хувиар буюу гурав дахь жилдээ ойролцоогоор хоёр оронтой тоогоор өслөө.

Улс орны эдийн засгийн энэхүү өсөлтөд Голомт банк ч гэсэн хувь нэмрээ оруулж, үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойших 13 жилийнхээ ойгоо амжилтын арвин ургацтайгаар угтлаа.

Банкны нийт актив 85 хувиар өсч 652 тэрбум төгрөгт (557 сая ам.доллар) хүрч манай банк энэ үзүүлэлтээрээ хамгийн том банк болсон төдийгүй мөн шилдэг банкныхаа байр суурийг улам бэхжүүлэв.

Түүнчлэн, татан төвлөрүүлсэн хөрөнгө болон зээл 80 гаруй хувиар өссөний зэрэгцээ зээлийн стандартуудыг чанга баримтлан ажилласан. Эдгээр өсөлтийн ачаар, оны

эцсийн байдлаар банкны татварын дараах ашиг 3 дахин өсч, 7.4 тэрбум төгрөгт хүрч (6.3 сая ам.доллар), нийт өөрийн хөрөнгө 53 хувиар өсч, 54.9 тэрбум төгрөгт (46.9 сая ам.доллар) хүртэл нэмэгдлээ.

Банк санхүүгийн болон үйл ажиллагааны төлөвлөгөө, зорилтуудаа амжилттай хэрэгжүүлсний зэрэгцээ, банкны зохистой удирдлагыг бэхжүүлэх, гүйцэтгэх удирдлага болон өмчлөгчдийн оролцоог зохистой хуваарилахад томоохон дэвшил гаргалаа.

Миний бие банкны Гүйцэтгэх захирлын албыг 11 жил хашсаны эцэст 10 дугаар сарын эхээр Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргаар сонгогдон ажиллаж эхэлсэн. 2004 оноос эхлэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргаар ажиллан, үйл ажиллагааг үр дүнтэй удирдан чиглүүлж ирсэн Л.Болдхуягт чин сэтгэлийн гүн талархлыг илэрхийлж байна.

Энэхүү албыг хаших хугацаанд нь манай банк хөгжлийн чухал үе, мөчлөгүүдийг амжилттай даван туулж ирсэн бөгөөд түүний оруулсан хувь нэмэр үнэлэшгүй юм. Цаашдаа ч Л.Болдхуяг банкны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнээр үргэлжлүүлэн ажиллаж, бидэнд өөрийн мэдлэг, чадвар, арвин туршлагаасаа хуваалцаж, зөвлөгөө өгсөөр байх болно.



Мөн энэ жил бид банкны бүтцийн өөрчлөлтийг амжилттай хэрэгжүүлж, шинэ бүтэц, зарчмуудыг нэвтрүүлэн ажиллаж эхлээд байна. Энэ хүрээнд олон улсын банк санхүүгийн нэр хүндтэй хэвлэлүүдээр дамжуулан сонгон шалгаруулалт явуулсны эцэст, Гүйцэтгэх захирлын албанд Их Британийн иргэн Жон П.Финиганыг томилон ажиллуулж байна. Тэрбээр шинээр төлөвшиж буй зах зээлийн эдийн засагтай орнуудын банкны салбарт олон жил ажиллаж байсан, банк санхүү, хууль эрх зүйн чиглэлээр гүнзгий мэдлэг, арвин туршлага хуримтлуулсан хүн юм. Түүнийг томилогдсоноос хойш богино хугацаанд манай банк үйл ажиллагааны бүхий л хүрээнд олон улсын хамгийн шилдэг стандартуудыг нэвтрүүлэх талаар томоохон ахиц дэвшил гаргаад байгаа юм.

Олон улсын тавцанд нэр хүнд бүхий, Швейцарийн тэргүүлэгч банк болох Кредит Свисстэй Хоёрдогч өглөгийн хөрвөх зээллэгийн гэрээг амжилттай байгуулж, урт хугацааны түншлэлийг эхлүүлээд байгааг дурьдахад таатай байна. Энэ хүрээнд манай банкны хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгө нийт өөрийн хөрөнгийн 20 хувь хүртэл нэмэгдэх боломжтой юм. Ийнхүү дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, нэр хүндтэй банк Голомт банкыг сонгон, түүгээр дамжуулан Монголын банк санхүүгийн зах зээлд орж ирж байгаа нь том ололт юм.

Эцэст нь хэлэхэд, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нийт гишүүдийн өмнөөс бидэнд итгэл хүлээлгэн, бизнес эрхэлж, хамтран ажилладаг манай хүндэт үйлчлүүлэгчид, харилцагч банк, аж ахуйн нэгж байгууллагууд, Монголын ард иргэд, болон бидний амжилттай ажиллах нөхцлийг бүрдүүлж, хичээл зүтгэл гаргадаг банкны удирдлага, нийт ажиллагсад, мөн хувь нийлүүлэгч Бодь-Интернэшнл ХХК-ныханд чин сэтгэлийн талархал илэрхийлж байгааг минь хүлээн авна уу.

Ирж буй 2008 он, сарны шинэ тоолол эхлэх хулгана жилд болон цаашдаа бид илүү ихийг хийж бүтээх эрмэлзэл дүүрэн, ололт амжилтаа байнга зузаатган бэхжүүлэхийн төлөө чармайн ажиллах болно.

Д.БАЯСГАЛАН
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Дарга

Манай банк нэг талаас дотоодын болон бүс нутгийн эдийн засгийн тогтвортой өсөлт, нөгөө талаас чадварлаг боловсон хүчин, олон улсын түвшин дэх өргөн хүрээний түншилэл дээрээ тулгуурлан Монгол Улсын банк санхүүгийн салбарт тэргүүлэгч байр сууриа 2008 онд ч, цаашид ч хадгалан, зогсолтгүй хөгжин дэвжих болно.

Жон П.Финиган, Гүйцэтгэх захирал

Эрхэм хувь нийлүүлэгч нартаа

Хэдийгээр 2007 он олон улсын зах зээлийн хувьд ихээхэн чичиргээн, донсолгоотой жил болж дэлхийн тэргүүлэгч олон банкууд томоохон сорилтуудтай тулгарсан хэдий ч, тус банкны хувьд бахдам ололт амжилтаар дүүрэн жил болж өмнөө тавьсан ашгийн ба ашгийн бус зорилтуудаа ханган, давуулан биелүүлснээр бизнесийнхээ болон үйл ажиллагааныхаа бүхий л гол чиглэлүүдэд огцом өсөлтийг бид бүрдүүлж чадлаа. Өнгөрсөн жилийн турш бид салбар нэгжийн сүлжээгээ өргөжүүлж 8 шинэ салбарыг Улаанбаатар хотноо, орон нутагт 4 шинэ салбарыг Хөвсгөл, Орхон, Өмнөговь аймгуудад нээлээ. Мөн Монголд анх удаа Өөртөө үйлчлэх банк буюу “Self banking” үйлчилгээг нэвтрүүлж эхлээд байгаа бөгөөд харилцагчиддаа ойртон гэр ахуйн бараа, цахилгаан хэрэгслийг зээлээр худалдан авах боломжийг бүрдүүлж, манай мэргэшсэн, дадлага туршлагатай зээлийн ажилтнууд томоохон худалдаа, үйлчилгээний төвүүд дээр хэрэглээний зээлийг олгож байна. Эдгээрийн үр дүнд манай банк оны эцэст нийт 44 үйлчилгээний салбартай болж банкны төв оффис улсын нийслэл Улаанбаатар хотын төвд Сүхбаатарын талбайн хаяанд сүндэрлэж байгаа бөгөөд нийт 20 ATM бэлэн мөнгөний машинтай боллоо.

Эдгээр 64 нэгжүүдээр дамжуулан өдөр ирэх тусам өсөн нэмэгдэж буй харилцагчдынхаа эрэлт хэрэгцээ, шаардлагад тохирсон банк санхүүгийн иж бүрэн

үйлчилгээг үзүүлж байна. Өөрсдийн үйлчилгээ, хэрэглэгчдийг дэмжих үйл ажиллагаандаа байнгын дэвшил, шинэлэг санаануудыг нэвтрүүлэхэд бид үргэлж анхаарлаа чиглүүлдэг бөгөөд мэдээллийн технологийн давуу талыг ашиглан сүлжээ, салбаруудаараа дамжуулан үйлчилгээ хүргэх олон төрлийн сувгуудыг санал болгогдгийн тод жишээ бол манай төвлөрсөн лавлах төв, электрон банкны үйлчилгээ, телефон банкны үйлчилгээ юм.

Цахим банкны үйлчилгээ нь уламжлалт хадгаламж, төлбөр тооцоо, валютын арилжаа зэргээс хальж www.golomtbank.com хаягаар зээлийн хүсэлтийг шууд тавих боломжтой боллоо.

Үүнтэй нэгэн адилаар манай бүтээгдэхүүний нэр төрөл тасралтгүйгээр, улам олширч байгаа бөгөөд өргөн хүрээт төлбөрийн картын үйлчилгээгээ өргөжүүлэн нэр хүнд бүхий “Платинум Мастеркарт”-ыг нэвтрүүлж, Чингис Хаан олон улсын нисэх онгоцны буудалд “Голомт Банкны Платинум Зорчигчдын Танхим”-ыг нээлээ.

Түүнчлэн бид КоБрэнд алтан Виза картыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимтай хамтран гаргалаа.

Банкны зээлийн үйлчилгээг лизингийн үйлчилгээгээр өргөжүүлэн эдийн засгийн гол салбарууд болох уул



уурхай, барилга, дэд бүтэц болон хөдөө аж ахуйн салбар дахь томоохон харилцагч нартаа орчин үеийн тоног төхөөрөмжүүд худалдан авахад нь дэмжих зорилгоор дунд хугацааны хэсэгчилсэн төлбөрт зээлийн бүтээгдэхүүнийг гаргаж барилгын хөгжилд санхүүгийн үе шаттай дэмжлэг үзүүлэх шинэлэг хөтөлбөрүүдийг мөн нэвтрүүлж эхлээд байна.

Бид гадаад харилцаа холбоогоо улам өргөжүүлж гадаадын нэр хүнд бүхий Bank of China, Citicorp, CIBC, ING зэрэг банкуудтай шинээр харилцаа холбоо тогтоолоо. Түүнчлэн Дэлхийн Банк, Олон улсын хөгжлийн агентлаг болон Азийн Хөгжлийн Банк зэрэг томоохон санхүүгийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлж, хамтарсан санхүүжилтийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

Манай банк бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийг амжилттай хэрэгжүүлж, байгууллагын зохистой засаглалыг улам бүр бэхжүүлж, ил тод байдал, үйл ажиллагаа, түүний хяналтын уялдаа холбоог сайжруулсан.

Мөнгө угаахтай тэмцэх хууль, бодлого, дүрэм журмын хэрэгжилтийг хангах зэрэг шинэ үүрэгт ажлуудад туршлагатай ажилтнуудыг томилж, аюулгүй байдал хариуцсан шинэ менежертэй болсноос гадна Хяналтын зөвлөл, Зээлийн хороо, Актив Пассивын хороо,

Удирдлагын хороонуудыг шинэчлэн тодорхойлж чадавхийг нь бэхжүүллээ. Манай эрсдэлийн удирдлагын гол стратеги бол банкны үйл ажиллагаатай холбоотой гарч болзошгүй бүхий л эрсдэлүүдийг тодорхойлон, хянаж удирдахад чиглэгддэг.

Балансын бүх үзүүлэлтүүд өсөлттэй гарч, харилцагчдын харилцах хадгаламж 80 хувиар буюу 228 тэрбум төгрөгөөр өсч, 284 тэрбум төгрөгөөс 512 тэрбум төгрөгт, зээлийн багц 85 хувиар буюу 148 тэрбум төгрөгөөр өсч, 174 тэрбум төгрөгөөс 323 тэрбум төгрөгт тус тус хүрсэн байна.

Зээлийн багцын хэмжээ бараг хоёр дахин өссөн ч зээлийн үйл ажиллагааны хяналт, шаардлагыг өндөр түвшинд хэрэгжүүлсний үр дүнд чанаргүй зээлийн хувь хэмжээ 2006 оны эцэст 6.7 хувь байсныг тайлант жилийн эцэст 4.2 хувь болгон буурууллаа.

Зээлийн багцын хэмжээ нэмэгдсэн ч зээл, харилцах хадгаламжийн харьцаа бараг өөрчлөлтгүй 2006 онд 62 хувь, 2007 онд 63 хувь байна гэдгийг дурдах нь зүйтэй.

Нийт актив 85 хувиар буюу 299 тэрбум төгрөгөөр өсч 353 тэрбум төгрөг байснаас 652 тэрбум төгрөг болон өслөө.

Активын болон харилцах хадгаламжийн хэмжээгээр Голомт банк нь Монгол Улсын хамгийн том арилжааны

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ (үрээлжлэл)

банк болж чадлаа. Энэ амжилт маань бахархуштай амжилтуудын нэг хэдий ч Монгол Улсад бизнес хийж байгаа бүх хүмүүс, аж ахуйн нэгж компаниуд, банк санхүүгийн байгууллагууд болон хөгжлийн бусад агентлагуудын хувьд тэдний сонгох дуртай Монголын хамгийн шилдэг банк болох бидний эрхэм зорилготой харьцуулахад хоёрдугаар зэргийн амжилт юм.

Өнгөрсөн жил үйл ажиллагааны бүхий л хүрээнд ашигт ажиллагаа сайжирсан жил байсан бөгөөд хүүгийн орлого 66 хувиар буюу 2006 онд 26.9 тэрбум төгрөг байснаас 44.6 тэрбум төгрөг боллоо өсч, хүүгийн цэвэр орлого 8.7 тэрбум төгрөг байснаас 14.3 тэрбум төгрөг болж өссөн байна.

Хүүгийн бус орлогын үзүүлэлт мөн таатай өсөлттэй байгаа бөгөөд 80 хувиар буюу 4.7 тэрбум төгрөгөөр өсч 8.5 тэрбум төгрөг болсон байна.

Үйл ажиллагааны зардал 63 хувиар өсч өмнөх жил 6.2 тэрбум төгрөг байсан бол 10.1 тэрбум төгрөг болж өсчээ. Энэхүү 3.9 тэрбум төгрөгийн өсөлтийн 20 гаруй хувь нь боловсон хүчний зардлын өсөлттэй холбоотой байна.

Зээлийн болзошгүй алдагдлын сангийн зардлын хэмжээ 10 хувиар буурч 2.3 тэрбум төгрөг, нийт зээлийн болзошгүй алдагдлын сангийн үлдэгдэл 14.3 тэрбум төгрөг болсон нь нийт чанаргүй зээлийн 102 хувьтай тэнцүү байна.

Банк нь 13 дахь жилийнхээ босгон дээр татварын өмнөх байдлаар 9.2 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан нь 2006 оны 3.6 тэрбум төгрөгийн ашгаас даруй 5.6 тэрбум төгрөгөөр давсан байна.

2006 онд татварт 1.11 тэрбум төгрөг төлсөн бол 2007 оны санхүүгийн жилд 1.8 тэрбум төгрөг төлсөн нь 63 хувийн өсөлттэй байгаа бөгөөд татварын дараах ашиг 7.4 тэрбум төгрөг, 2006 оноос 193 хувиар өссөн.

Оны сүүлээр Кредит Свисс банктай хоёрдогч өглөгийн 20 сая ам.долларын зээлийн гэрээ байгуулсан бөгөөд эхний ээлжинд 10 сая ам.долларын зээлийг авснаар манай банкны хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгө нэмэгдлээ. Кредит Свисс банк нь энэ зээлийг Голомт банкны нийт өөрийн хөрөнгийн 20 хувь хүртэлх хэмжээнд хувьцаанд хөрвүүлэх эрхтэй бөгөөд тооцоолохдоо банкыг 100 сая ам.доллараар (117 тэрбум төгрөг) үнэлсэн байна.

Дээрх үйл ажиллагаануудын үр дүнд өөрийн хөрөнгийн хэмжээ 19 тэрбум төгрөгөөр өсч оны эцэст 54.9 тэрбум төгрөгт хүрлээ.

Нийт өөрийн хөрөнгийн 38.7 тэрбум төгрөг нь нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, 16.2 тэрбум төгрөг нь хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгө юм.

Тус банк нь Монголын Худалдаа Аж Үйлвэрийн Танхим, Гадаадын Хөрөнгө Оруулалт Гадаад Худалдааны агентлаг түүнчлэн Монголын Үндэсний Аялал Зуучлалын Байгууллага зэрэг үндэсний агентлагуудтай хамтран ажиллаж зүйрлэшгүй баялаг уламжлалтай, эдийн засгийн гэгээлэг ирээдүйтэй Монгол Улсын талаарх мэдлэг мэдээллийг түгээх, хөрөнгө оруулалт татах зорилго бүхий хурал семинаруудыг зохион байгуулахад дэмжлэг туслалцаа үзүүлсээр ирлээ.

Тайлант жилд тус банк нь Улсын Гаалийн Ерөнхий Газраас “Гаалийн Түнш Банк” өргөмжлөл, Улсын Нийгмийн Даатгалын Ерөнхий Газраас “Үндэсний Шилдэг Шимтгэл Төлөгч Байгууллага” өргөмжлөлийг тус тус гардан авсан. Бид мөн МастерКарт УорлдВайд байгууллагаас МастерКарт Платинум картыг зах зээлд амжилттай нэвтрүүлж хэрэгжүүлснийхээ төлөө “Оны Шилдэг Плантинум Карт” шагналыг хүртлээ. Түүнчлэн хоёр дахь удаагаа Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит “Үндэсний Бүтээмжийн Шагнал 2007”-г хүртсэнээр Монгол Улсын Ерөнхийлөгчөөс энэхүү шагнал хүртсэн цорын ганц банк гэдэг байр сууриа хадгаллаа.

Бид ашгийн төлөө үйл ажиллагааг явуулахын зэрэгцээ, Монгол орныхоо нийгэм эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж, нийгмийн сайн сайхны төлөө олон арга хэмжээг зохион байгуулан нийгмийн хариуцлагаа байнга ухамсарласаар ирсэн. Үүний тод илрэл бол анагаах ухаан, боловсрол, соёл урлаг болон бусад салбарыг хөгжүүлэхэд зориулан 90 гаруй сая төгрөгийг зарцуулсан байна. Түүнчлэн, тус банк нь байгаль орчинд хор хөнөөлгүй үйл ажиллагааг байнга дэмжиж ажилладаг.

Манай банк нэг талаас дотоодын болон бүс нутгийн эдийн засгийн тогтвортой өсөлт, нөгөө талаас чадварлаг боловсон хүчин, олон улсын түвшин дэх өргөн хүрээний түншлэл дээрээ тулгуурлан Монгол Улсын банк санхүүгийн салбарт тэргүүлэгч байр сууриа 2008 онд ч, цаашид ч хадгалан, зогсолтгүй хөгжин дэвжих болно.



ЖОН П. ФИНИГАН
Гүйцэтгэх Захирал

2007 он Монгол орны хувьд эрчимтэй өсөлтийн жил болж, улсын төсөв 3 дахь жилдээ ашигтай гарсны зэрэгцээ гадаад валютын нөөц нэмэгдэж, ДНБ-ний өсөлт 9.9 хувь буюу гурав дахь жилдээ ойролцоогоор хоёр оронтой тоогоор өслөө.


“Нийгэм эдийн засгийн хөгжлийн тулгуур үүрэг гүйцэтгэгч”

ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ


Монгол Улсын ДНБ сүүлийн жилүүдэд тасралтгүй өсч, 2007 онд 4.5 триллион төгрөгт хүрч, 9.9 хувийн өсөлттэй гарлаа. Сүүлийн дөрвөн жилийн туршид ДНБ-ий өсөлт 7 хувиас дээш үзүүлэлттэй гарчээ.

ДНБ-ний энэхүү өсөлт нь аж үйлдвэр (32.3 хувь), барилга угсралт (22.4 хувь), тээвэр холбоо (18.6 хувь), хөдөө аж ахуй (15.8 хувь), худалдаа үйлчилгээ (15.4 хувь)-ний салбарын өсөлтөд суурилжээ. Уул уурхайн салбарын өсөлт 1.7 хувийн өсөлттэй гарсан хэдий ч ДНБ-нд эзлэх хэмжээгээр томоохон хувь буюу 27.4 хувийг эзэлсэн хэвээр байна.


Бодит ДНБ-ний өсөлт (%)




Нэг хүнд ноогдох ДНБ-ий хэмжээ (Мянган төгрөг)



Экспорт, Импорт (Сая ам.доллар)



Экспорт / ДНБ (%)



Нийт экспортын хэмжээ 2007 онд 1.9 тэрбум ам.доллар буюу ДНБ-ний 48.5 хувьд хүрсэн нь дэлхийн зах зээл дээрх зэсийн үнийн өсөлтөөс голлон шалтгаалжээ. Үүнтэй зэрэгцээд импортын хэмжээ 2.1 тэрбум ам.долларт хүрсэн байна. 2006 онтой харьцуулахад нийт гадаад худалдааны эргэлт 32.3 хувиар өсч, үүнд экспортын хэмжээ 22.4 хувь, импортын хэмжээ 42.5 хувиар нэмэгдсэн байна. Гадаад худалдааны тэнцэл алдагдалтай гарсан шалтгааныг голчлон уул уурхайн тоног төхөөрөмжийн импорт, барилга угсралтын салбарын өсөлттэй уялдсан барилгын материалын импортын огцом өсөлт голлон нөлөөлснөөр тайлбарлаж болно.


Улсын төсвийн тэнцэл 2007 онд ашигтай гарч, ДНБ-ний 2.2 хувьтай тэнцлээ.

Төсвийн зарцуулалт 2006 онд 1.3 триллион төгрөг буюу ДНБ-ий 36.6 хувь байсан бол 2007 онд 1.7 триллион төгрөгт хүрч ДНБ-ий 38.4 хувьтай тэнцлээ.


Засгийн Газраас эдийн засаг, нийгмийг дэмжих төсвийн тэлэх бодлого барьж, цалин тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүлэх, эрүүл мэнд, боловсрол, дэд бүтцэд түлхүү хөрөнгө оруулалтыг хийж байна. Улсын нэгдсэн төсвийн зарцуулалт 2000 онд ДНБ-ий 42.2 хувийг эзэлж байсантай харьцуулахад 2007 онд энэ үзүүлэлт 38.4 хувьд хүрч, буурсан байна.

Эдийн засгийн сүүлийн хэдэн жилийн нааштай өөрчлөлтүүд, төсвийн ашигтай тэнцэл хадгалагдаж байгаа нь Монгол Улсын гадаад валютын цэвэр албан нөөц түүхэндээ дээд хэмжээ буюу 972.4 сая ам.долларт хүрч, өмнөх жилээс 41.5 хувиар нэмэгдэж, 6 сарын импорттой тэнцлээ.


Улсын төсвийн тэнцэл (Тэрбум төгрөг)




Улсын төсвийн тэнцэл / ДНБ (%)



Инфляци (%)



Ханш: USD/MNT



ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ (үргэлжлэл)


Эдийн засгийн энэхүү хөгжилтэй зэрэгцээд хэрэглээний үнийн өсөлт 2007 эцэст 15.1 хувьд хүрч, энэ үзүүлэлт сүүлийн 10 жилийн туршид хамгийн өндөр түвшинд хүрсэн бөгөөд оны дунджаар 9 хувь байсан. Хэрэглээний үнийн сагсанд хүнсний бараа бүтээгдэхүүний эзлэх хувийн жин 40 гаруй хувийг эзэлдэг учир ерөнхий үнийн индекс онцгой өсөхөд голлон нөлөөлжээ.

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2007 оны туршид тогтвортой байсан буюу ердөө 0.4 хувийн өөрчлөлттэй гарсан ч, дэлхийн зах зээл дээр ам.долларын индекс 2007 оны туршид 15 хувиар унасан байна. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш тогтвортой байснаас дотоодын хэрэглээний үнийн индекс өндөрссөн буюу импортын инфляци нүүрлэх шалтгаан болжээ.


Хятадын юан, ОХУ-ын рублийн ханшийн чангаралт, шатахуун түлш, хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт дотоодын хэрэглээний үнийн өсөлтийн суурь хүчин зүйл нь болсон байна.

Сүүлийн жилүүдэд эдийн засаг дахь мөнгөжилт тасралтгүй өсч, 2007 онд өмнөх жилүүдтэй харьцуулахад онцгой өөрчлөлт гарлаа. Мөнгөний нийлүүлэлт M2-ийн хэмжээ 2007 онд 56.3 хувиар өсч, 2.4 триллион төгрөгт хүрч, ДНБ-ний 52.7 хувьд хүрлээ. Хөгжиж буй бусад орнуудтай харьцуулахад Монгол Улсын эдийн засаг дахь мөнгөжилт харьцангуй доогуур байна.

Нийт мөнгөний (M2) өсөлт (%)




Нийт мөнгө (M2)/ДНБ (%)




Банкны зээлийн хэмжээ 2.1 триллион төгрөгт хүрч, өмнөх жилээс 67.4 хувиар өсч, ДНБ-ний 45.1 хувьд хүрлээ. Чанаргүй зээлийн хувь хэмжээ 2007 онд онцгой хэмжээгээр буюу 4.91 хувиас 3.31 хувь болтол буурсан байна.

Банкны системийн нийт зээл (Тэрбум төгрөг)



Чанаргүй зээлийн харьцаа-Банкны систем (%)




Сүүлийн таван жилд банкуудын тоо хэмжээнд өөрчлөлт гараагүй ч, банкны системийн нийт актив хөрөнгө тасралтгүй өсч, 2007 онд 41 хувийн өсөлттэй гарсан байна. Банкуудын хүчтэй өрсөлдөөний дүнд зээлийн хүү буурсан хэдий ч Монголбанкны үнийн өсөлттэй тэмцэх бодлогын дүнд суурь хүү өсч, 2007 оны эцсээр 6.4 хувиас 9.9 хувьд хүрсэн байна.


Банкны системийн үзүүлэлтүүд	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007
Банкуудын тоо	12	16	16	17	17	17	16	16
Банкны салбар нэгжийн тоо	457	538	595	635	682	731	832	981
Банкны салбар нэгжид ногдох хүн амын тоо	5,268	4,540	4,160	3,943	3,703	3,501	3,132	2,686
Нийт актив (Тэрбум төгрөг)	226	333	493	826	1,109	1,585	2,320	3,384
Нэг хүнд ногдох хадгаламж (Мянган төгрөг)	38	55	88	145	204	270	374	556
Нийт актив / ДНБ	23.1%	29.4%	39.7%	60.6%	59.5%	70.0%	62.5%	74.2%
Нийт зээл / ДНБ	6.6%	12.1%	18.7%	32.5%	33.5%	36.8%	32.9%	45.1%
Банкны өөрийн хөрөнгө / ДНБ	3.1%	4.2%	5.0%	8.1%	9.3%	9.1%	7.9%	8.3%
Чанаргүй зээлийн хувь	21.9%	6.7%	5.1%	4.8%	6.4%	5.6%	4.9%	3.3%
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ (дундаж)	27.0%	24.6%	20.0%	20.4%	20.0%	18.2%	18.1%	14.2%
Банкны систем дэх ЗГ-ийн эзэмшил хувь	56.6%	48.0%	22.1%	7.3%	6.0%	4.9%	-	-
ББСБ-ийн тоо	7	28	66	88	114	150	163	137

2007 онд хөрөнгийн зах зээл идэвхитэй, өсөлттэй байлаа. Монголын Хөрөнгийн биржид 2007 онд шинээр 46.3 тэрбум төгрөгийн үнэлгээтэй компаниуд бүртгэгдэж, амжилттай арилжигдлаа. Нийт гүйлгээний хэмжээ 102.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос 5.7 дахин нэмэгдсэн, нийт зах зээлийн үнэлгээ 2006 онд 131.2 тэрбум төгрөг байсан бол 2007 онд 717.5 тэрбум төгрөгт хүрч, 5.5 дахин өссөн байна.

Монголын хөрөнгийн бирж
Зах зээлийн нийт үнэлгээ (Тэрбум төгрөг)



Монголын хөрөнгийн бирж
Үнэт цаасны гүйлгээний нийт дүн (Тэрбум төгрөг)




БАНКНЫ СИСТЕМД ЭЗЛЭХ ГОЛОМТ БАНКНЫ БАЙР СУУРЬ


2007 онд Голомт банк нийт актив болон харилцагчдаас татсан харилцах, хадгаламжийн хэмжээгээрээ Монголын банк санхүүгийн систем дэх хамгийн том банк боллоо.

Банкны системд тэргүүлэгч гол үзүүлэлтүүдийг дор тоймлон харуулав.

Нийт актив




Нийт харилцах, хадгаламж



Нийт зээл




Нийт өөрийн хөрөнгө



Гадаадын банк санхүүгийн байгууллагад байршуулсан нийт хөрөнгө



Нийт хөрвөх хөрөнгө



*Хэтийн зорилго
Монголын банкны
салбарт тэргүүлэгч,
дэлхийн жишигт
нийцсэн үйл
ажиллагаатай, нэр хүнд
бүхий найдвартай банк
байна.*

*Эрхэм зорилго
Санхүүгийн цогц
үйлчилгээ үзүүлдэг, өндөр
үр ашиг бүхий хөгжих
чадвартай, нийгмийн
хариуцлагатай,
тэргүүлэгч банк байна.*

“Санхүүгийн хүчирхэг, эрүүл тогтолцоо”


ХЭТИЙН ЗОРИЛГО, ЭРХЭМ ЗОРИЛГО

ХЭТИЙН ЗОРИЛГО


Монголын банкны салбарт тэргүүлэгч, дэлхийн жишигт нийцсэн үйл ажиллагаатай, нэр хүнд бүхий найдвартай банк байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Санхүүгийн цогц үйлчилгээ үзүүлдэг, өндөр үр ашиг бүхий хөгжих чадвартай, нийгмийн хариуцлагатай, тэргүүлэгч банк байна.



БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ




Голомт банк өнгөрөгч 2007 онд удирдлага, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийг амжилттай хэрэгжүүллээ. Энэхүү удирдлага, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлт нь Монгол Улсын эдийн засагт гарч буй хөгжил дэвшил, ирээдүйн чиг хандлагад нийцүүлэн банк, санхүүгийн системд өөрийн тэргүүлэгч байр суурийг хангахад чиглэгдсэн юм.

Түүнчлэн шинэ бүтцийн дагуу манай банкны дотоод нөөц бололцоо зохистойгоор хуваарилагдсан бөгөөд бодлого журмаа улам боловсронгуй болгох замаар банкны бүхий л үйл ажиллагаа, хяналтын тогтолцоог оновчтой болгосон.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Голомт банк “Компанийн зохистой засаглал”- ыг хэрэгжүүлэхийг үйл ажиллагаандаа мөрдөх тэргүүлэх чиглэл болгон ажиллаж байгаа бөгөөд энэ хүрээнд олон улсын стандарт, нийтлэг зарчмууд, Монгол Улсын хууль, Монголбанкнаас гаргасан журмуудыг дагаж мөрдөн үйл ажиллагаандаа нэвтрүүлэхийн зэрэгцээ, банкны дотооддоо мөрдөх дүрэм, бодлого, журмуудыг боловсруулан, дагаж мөрдөж байна.

Бид компанийн засаглалыг хэрэгжүүлэхдээ хувь нийлүүлэгчийн нягт харилцаа, Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Хяналтын Зөвлөлийн үр ашигтай хамтын ажиллагаа, үйл ажиллагааны гүйцэтгэлд суурилсан урамшуулал, нээлттэй ил тод байдал гэсэн үндсэн зарчмуудыг баримталдаг.





Зүүн гар талаас:

Н. Нацагдорж – Дэд захирал, Иргэдийн Банкны Газрын захирал

М. Чимэгмөнх - Дэд захирал, Санхүүгийн Удирдлагын Газрын захирал

Г.Ганболд – Үйл ажиллагаа хариуцсан тэргүүн дэд захирал

Жон П. Финиган – Гүйцэтгэх захирал

Л. Оюун-Эрдэнэ - Дэд захирал, Байгууллагын Банкны Газрын захирал

Г. Ганхуяг – Дэд захирал, Хөрөнгийн Удирдлагын Газрын захирал

УДИРДЛАГЫН БАГ



Зүүн гар талаас:

Б. Батцэцэг – ИБГ, Орон Сууцны Санхүүжилтийн Хэлтсийн захирал

Г. Тэгшбүрэн – ЕЗГ, Хүний Нөөцийн Хэлтсийн захирал

Н. Цэрэндаваа – Мэдээллийн Технологийн Хэлтсийн захирал

М. Чингүн – Эрсдэлийн Удирдлагын Газрын захирал

О. Хаянхярваа – ЕЗГ, Санхүү, Аж Ахуйн Хэлтсийн захирал

Ц. Байгалмаа – ИБГ, Бизнесийн Удирдлагын Хэлтсийн захирал



Зүүн гар талаас:

Г. Ариунбаяр – БТГ, Картын Төлбөр Тооцооны Төвийн захирал

Д. Батбилэг – Картын Төвийн захирал

С. Мөнхтуяа – СУГ, Бүртгэлийн Бодлого Хяналтын Хэлтсийн захирал

Б. Батнягт – Маркетингийн Хэлтсийн захирал

Ж. Ганбат – Дотоод Аудитын Газрын захирал

Д. Сугар – Бүртгэл Тооцооны Газрын захирал

БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ (үрээлжлэл)

ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧИД

Голомт банк нь “Бодь Интернэшнл ХХК” гэсэн нэг хувь нийлүүлэгчтэй хязгаарлагдмал хариуцлагатай компани юм.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ


Төлөөлөн Удирдах Зөвлөл нь хувь нийлүүлэгчдийн хурлаас томилсон банк, бизнесийн салбарт олон жил ажилласан туршлага бүхий гурван хүний бүрэлдэхүүнтэй бөгөөд банкны стратеги төлөвлөгөөг баталж, гүйцэтгэх удирдлагыг томилж, банкны зохион байгуулалтыг тодорхойлж, гадаад аудиторыг сонгож, банкны үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, дэмжлэг үзүүлж ажилладаг.

ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ

Хяналтын Зөвлөл нь Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс томилогдон банкны үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах бөгөөд үйл ажиллагаагаа Төлөөлөн Удирдах Зөвлөлд тайлагнана. Дотоод аудитын газартай өдөр тутмын харилцаатай байна.

УДИРДЛАГЫН БАГ

Голомт банк санхүүгийн системд туршлага бүхий, чадварлаг удирдлагын багтай бөгөөд бүтэц зохион байгуулалтын дагуу гүйцэтгэх захирал, дэд захирал, газрын захирал, хэлтсийн захирал гэсэн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.





2007 онд Голомт банкны хамт олны бүрэлдэхүүнд 180 ажилтан шинээр нэмэгдэж, нийт 728 ажилтантай боллоо.

Голомт банк ажилтнуудынхаа мэдлэг, мэргэжлийг хөгжүүлэхэд онцгой анхаардаг “суралцагч байгууллага” юм.

“Эрч хүчтэй, туршилагатай, чадварлаг хамт олон”

БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ (үргэлжлэл)

ХҮНИЙ НӨӨЦ

2007 оны эцсийн байдлаар тус банкны нийт ажилтны тоо 728 болсон нь 2006 оны мөн үеийнхээс 33%-аар өссөн байна. Шинээр томилогдсон ажилтнуудын 70% нь салбар, тооцооны төвүүдэд, 30% нь төвийн бусад нэгжүүдэд ажиллаж байгаа юм. Нийт ажилтны 88% нь дээд боловсрол эзэмшсэн байгаа бөгөөд мэргэжлийн төрөл чиглэлээр нь авч үзвэл 70% нь банк санхүү, эдийн засаг, бизнесийн удирдлагын үндсэн мэргэжилтэй байна.

	2006	2007
Ажилтны тоо	548	728
Салбар, тооцооны төвүүд	64 %	57%
Төв	36 %	43%
Хүйсийн харьцаа (Эрэгтэй/Эмэгтэй) харьцаа	30-70	29-71
Салбар, тооцооны төвүүд	23-77	25-75
Төв	42-58	41-59
Дунд түвшний удирдлага	40-60	40-60
Дээд түвшний удирдлага	50-50	50-50
Мэргэжлийн зэрэг		
Дээд боловсролтой	87%	88%
Дунд боловсролтой	13%	12%
Нас		
25 хүртэл	31%	33%
25-34	53%	51%
35-44	12%	12%
45-54	3%	3%
54-өөс дээш	1%	1%

2007 онд тус банк “Монгол Улсын ерөнхийлөгчийн нэрэмжит бүтээмжийн шагнал”- ыг хүртэж, Үйл Ажиллагаа хариуцсан тэргүүн дэд захирал Г.Ганболд “МУ-ын хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”, ажил үйлсээрээ шалгарсан гурван ажилтан Монголбанкнаас олгодог “Банкны шилдэг ажилтан” цол тэмдгээр шагнуулсан зэрэг нь байгууллага, удирдлага болон хамт олны маань бахдам амжилт бүтээлийн илэрхийлэл боллоо.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит Үндэсний Бүтээмжийн шагнал 2007-г хүлээн авав.

СУРГАЛТ, ХӨГЖИЛ

Голомт банк “Суралцагч байгууллага”-ынхаа хувьд ажилчдаа хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр ихээхэн анхаарал тавьдаг.

Төлөөлөн Удирдах Зөвлөл болон банкны удирдлагын баг нь хүний нөөцийн оновчтой менежментийг зохистойгоор хэрэгжүүлэх, банкны ажилтнуудын сайн сайхан байдлыг хангахад сэтгэл оюунаа харамгүй зориулдаг бөгөөд байгууллагын соёлын гол тулгуур чулуу болгон ажилтнуудынхаа төлөө олон ажлуудыг хэрэгжүүлсээр ирлээ.

Банкны гүйцэтгэл дээр тулгуурласан урамшууллын систем нь залуу үеийнхнийг татах нэгэн хүчин зүйл болсон ба одоо банкны нийт ажиллагсдын дундаж нас 29 болсон байна. Залуу ажилтнуудаа хөгжүүлэх, доороос дээш хандсан санал санаачлагуудыг дэмжсэн хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх, ажил мэргэжлээ хөгжүүлэх урам зоригийг тэдэнд дээд зэргээр өгөх орчинг бүрдүүлэх, хөхүүлэн тэтгэх боломжийг банкны удирдлага ямагт хайсаар ирсэн болно.

2007 онд тус банк ажилтнуудыг сургах, мэргэшүүлэхэд зориулж нийт 229 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, давхардсан тоогоор 1,263 ажилтан хамруулсан нь нийт ажиллагсдын 175 хувьтай тэнцүү, нэг ажилтан дунджаар 23.5 цагийн сургалтанд хамрагджээ. Түүнчлэн сургалтын бодлого чиглэлийг тодорхойлж, дараах үндсэн чиглэлүүдээр сургалт явуулсан байна.

- Харилцагчийн үйлчилгээ, бүтээмж;
- Санхүүгийн дүн шинжилгээ;
- Зээлийн үйл ажиллагаа;
- Хувь хүний менежмент ба багийн манлайлал;
- Банкны үйл ажиллагаа;
- Мөнгө угаах үйл ажиллагааны эсрэг.

	2006	2007
Нийт сургалтын зардал (Мянган төгрөг)	94,533	228,939
Нэг ажилтанд ногдох сургалтын зардал (Мянган төгрөг)	199	345
Нэг ажилтанд ногдох сургалт, цагаар	21.2	23.5
Сургалтанд оролцогсод	719	1,263

Ажилтнуудын эрүүл мэндэд анхаарал тавьж, байгууллагын соёлыг хөхүүлэн дэмжиж сайжруулах зорилгоор байгуулагдсан Спорт клуб нь мөн л идэвхтэй үйл ажиллагаануудаар дүүрэн нэгэн жилийг ардаа орхисон бөгөөд олон тооны биеийн тамир, спорт, урлаг соёлын арга хэмжээнүүд зохион байгуулсны дотор уламжлал болон тогтсон явган аялал бөгөөд энэ арга хэмжээнд 120 гаруй ажилтан идэвхтэй оролцсон байна.

Үүнээс гадна, тус клуб сагсан бөмбөг, гар бөмбөг, хөл бөмбөг зэрэг нийтийг хамарсан уралдаан тэмцээнүүд болон цасны баяр зэрэг хөгжөөнт арга хэмжээнүүдийг ажилтнуудын дунд зохион байгуулж, ажилчдын бие бялдрын хөгжил, багаар ажиллах, амьдрах сэтгэхүйд нь үнэтэй хувь нэмэр оруулсан байна.


ДЭД БҮТЭЦ

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

Голомт банк байгуулагдсан цагаасаа эхлэн үйл ажиллагааныхаа цар хүрээний өргөжилт, харилцагчдынхаа өсөн нэмэгдэж буй хэрэгцээ шаардлагад нийцүүлэн орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, энэ чиглэлээр тэргүүлэгч байсаар ирлээ. 2007 онд мэдээллийн технологийг сайжруулах, шинэчлэх чиглэлээр дараах төслүүдийг хэрэгжүүлсэн байна.

- Банкны вэб програмын шинэчлэл,
- E-Банкны үйлчилгээнд Талес е-Секюрити болон Тридум компанитай хамтран E-Токен шийдлийг нэвтрүүлж нууцлалыг сайжруулах үйл ажиллагаа,
- VoIP (Voice Over Internet Protocol) систем.

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ЕРӨНХИЙ СХЕМ



САЛБАРЫН СҮЛЖЭЭ

Голомт банк нь хүн амын нягтрал ихтэй, тогтвортой хөгжих ирээдүйтэй бүс нутагт салбар нэгжүүдээ нээх стратегийг баримталдаг.

2007 онд, үйлчилгээнийхээ цар хүрээг тэлэх, харилцагчдынхаа тоог нэмэгдүүлэх зорилгоор салбар, тооцооны төвүүдийнхээ тоог 38 хувиар буюу 12 нэгжээр нэмэгдүүлэхийн зэрэгцээ Монголд анх удаа бүрэн автоматчилагдсан “Өөртөө үйлчлэх банк” -ны үйлчилгээг өөрийн томоохон хоёр салбарт нэвтрүүлж эхлээд байна.




Голомт банк электрон банкны үйлчилгээг нэвтрүүлэх, үйлчилгээний сувгаа тэлэх тал дээр ямагт анхдагч байсаар ирсэн. Санхүүгийн дэд бүтэц хөгжих тусам интернэт, электрон банкны үйлчлүүлэгчдийн тоо даган өсч, өнгөрсөн жилтэй харьцуулахад гүйлгээний тоо хэмжээ 30 хувь, мөнгөн дүнгээр 46 хувиар өсчээ.

ИРГЭДЭД ЧИГЛЭСЭН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Эдийн засгийн тогтвортой өсөлт, дунд орлоготой давхаргын өргөжин тэлэлттэй уялдуулан Голомт банк бүтээгдэхүүнүүдийнхээ нэр төрөл, хүргэлтийн сувгуудыг эрсдэл үр ашгаа тооцон тууштайгаар олшруулж хамгийн өргөн хүрээт үйлчилгээнүүдийг хамгийн оновчтой бөгөөд тохиромжтой хэлбэрээр харилцагчиддаа хүргэх зорилт тавин ажиллаж байна.

Голомт банкны нийт активын 18 хувь, нийт орлогын 38 хувийг Иргэдийн Банкны үйл ажиллагаа бүрдүүлж байна.

Салбарын сүлжээ



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ (үрээлжлэл)


ЖИЖИГ ДУНД БИЗНЕСИЙН ЗЭЭЛ

Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хангагч гол хүчин зүйлүүдийн нэг нь жижиг дунд бизнесийн салбар бөгөөд Голомт банк энэхүү чухал салбарт зээл олгож санхүүжүүлэх замаар дэмжлэг үзүүлж байна. 2007 онд, жижиг дунд бизнесийн зээл 31%-иар өссөний дийлэнх нь худалдаа, боловсруулах үйлдвэр, барилгын салбарт олгогджээ.

Эдийн засгийн эрчимтэй хөгжил, олборлох болон барилгын салбарын хурдацтай өсөлттэй уялдуулан тус банк тусгай зориулалтын тоног, төхөөрөмж, машин механизмын түрээсийн үйлчилгээг шинээр нэвтрүүлээ.

Голомт банк харилцагчиддаа бизнесийн зээлийг өөрийн эх үүсвэрээс олгохоос гадна Азийн Хөгжлийн Банктай хамтран “Ажлын байр нэмэгжүүлэх төслийн зээл”-ийг 6 дахь жилдээ, мөн түүнчлэн Сангийн Яам, Хөрөнгө Оруулалт Хөгжлийн Сантай хамтран бага хүүтэй төслийн зээлийг олгож эхлээд байна.

Жижиг дунд бизнесийн зээл (Тэрбум төгрөг)




ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛ

Сүүлийн жилүүдэд салбар, тооцооны төвийн сүлжээнд томоохон хөрөнгө оруулалт хийсний үр дүнд, хэрэглээний зээл 2007 онд 300 гаруй хувиар өслөө.

Голомт банк 400 орчим авто машин, гэр ахуйн тавилга, цахилгаан бараа худалдаалдаг байгууллага, иргэдтэй хамтран ажиллаж харилцагчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн бараа бүтээгдэхүүнийг банкны зээлээр авах боломжийг бүрдүүлж байна.

Бид Монгол Улсынхаа ирээдүйн манлайлагчдад хөрөнгө оруулалт хийж, 2007 онд гадаад, дотоодод суралцагч оюутнуудад зориулсан Сургалтын зээлийг төгрөгөөр 20 сая хүртэл, гадаад валютаар 20,000 ам.доллар хүртэл хэмжээгээр олгож эхлээ.

Хэрэглээний зээл (Тэрбум төгрөг)




ОРОН СУУЦНЫ ЗЭЭЛ

Монгол Улсын нийгэм эдийн засгийн хөгжилтэй уялдан орон сууц худалдан авагчийн тоо нэмэгдэж байгаа нь Голомт банкны олгосон орон сууцны зээлийн хэмжээ 187 хувиар өсөхөд нөлөөлжээ. Ийнхүү орон сууцны зээлийн хэмжээгээ гурав дахь нэмэгдүүлэхдээ зээлийн стандарт шаардлагуудыг өндөр түвшинд баримтлан ажилласан.

Бага болон дунд орлоготой иргэдийг орон сууцаар хангах зорилго бүхий Монгол Улсын Засгийн газрын “40,000 орон сууц” хөтөлбөрийг Орон Сууцны Санхүүжилтийн Корпорацитай хамтран хэрэгжүүлэгч байгууллагаар тус банк шалгарлаа.

Орон сууцны зээл (Тэрбум төгрөг)



2007 онд бид бизнесийн болон хэрэглээний зээлийн хүүгээ удаа дараа бууруулахын сацуу Засгийн Газраас хэрэгжүүлж буй бага дунд орлоготой иргэдийг орон сууцжуулах “40,000 орон сууц” хөтөлбөрт идэвхтэй оролцож, шинээр ажлын байр бий болгоход дэмжлэг үзүүлэх зэрэг харилцагчиддаа чиглэсэн олон арга хэмжээг зохион байгууллаа.

“Хөгжлийн үр шимийг хамтдаа”


ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ (үрээлжлэл)

ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА


Өнгөрөгч онд бид харилцах, хадгаламжийн үйлчилгээг бүхий л төрлөөр өргөжүүлснээр, харилцах, хугацаагүй, хугацаатай, хөвөгч хүүтэй хадгаламж, урьдчилсан хүүт хадгаламж, хуримтлалын хадгаламж, хадгаламжийн сертификатууд болон хүүгийн тодорхой хэсэг нь хүүхдийн сайн сайхны төлөө зориулагддаг Алтан түлхүүр хадгаламж төгрөг болон гадаад валютын хэмжээгээрээ өссөн.

2007 онд иргэдийн харилцах, хадгаламжийн хэмжээ 64 хувиар өссөн байна.

Иргэдийн хадгаламж (Тэрбум төгрөг)



Иргэдийн хадгаламж эзэмшигчдийн тоо




КАРТЫН ҮЙЛЧИЛГЭЭ


2007 онд бид МастерКарт Платинум карт, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимтай хамтран Танхимын Алтан Виза картыг шинээр нэвтрүүллээ.

Нийт карт эзэмшигчдийн тоо 47 хувиар, гүйлгээний хэмжээ 76 хувиар тус тус өсч, электрон банкны үйлчилгээ тогтвортой өргөжихийн хэрээр АТМ болон картаар үйлчлэгч байгууллагуудын гүйлгээний хэмжээ өндөр өсөлттэй байна.

Карт эзэмшигчдийн тоо (Мянган ширхэг)



Картын зах зээл



Эх үүсвэр: Монголбанкны Судалгаа, "Монгол дахь банкны картын хэрэглээ", 2007 оны 9-р сар


БАЙГУУЛЛАГУУДАД ЧИГЛЭСЭН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Манай банк Байгууллагын банкны харилцагчиддаа харилцах данс, хадгаламж, зээл, гадаад худалдааны санхүүжилт, төлбөр тооцоо, гуйвуулга, гадаад валютын арилжаа гэсэн үндсэн зургаан төрлийн үйлчилгээг санал болгож байна.

Монголд үйл ажиллагаа явуулж байгаа бараг бүх бизнесийн томоохон байгууллагууд, төсөл хөтөлбөрүүдийн харилцах дансуудыг өөртөө байршуулах, зээл олгох зэргээр хамтран ажиллаж байгаа нь Голомт банк бол бизнесийнхний сонгох дуртай банк мөн гэдгийг харуулж байгаа хэрэг юм.

2007 онд Байгууллагын банкны зээлийн үлдэгдэл 73.5 хувиар өсч 269 тэрбум төгрөгт хүрсэн байна. Банк өөрийн бизнес, хөрөнгө оруулалтынхаа цар хүрээ, мэргэжлийн өндөр түвшинг улам сайжруулан хөгжүүлэхэд анхаарлаа ихэд хандууллаа. Банкны шинэ бүтэц нь стратегийн зорилтуудыг илүү тодорхой болгож ажилтнуудын уялдаа холбоог сайжруулж чадсанаар дотоодын болон олон улсын түвшинд томоохон харилцагчиддаа санхүүгийн цогц үйлчилгээг оновчтой түргэн, шуурхай хүргэх нөхцөл бүрдлээ.

Бизнесийн том зээл (Тэрбум төгрөг)



Бид Монгол Улсын Засгийн газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Дэлхийн Банк, Олон Улсын Хөгжлийн Агентлаг, Олон Улсын Санхүүгийн Корпораци, Азийн Хөгжлийн Банк зэрэг үндэсний болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах замаар харилцагч аж ахуйн нэгж байгууллагуудад дэмжлэг үзүүлэх боломжуудыг эрэлхийлсэн хэвээр байна. Өнгөрсөн жил, тус банк хоёр дахь удаагаа Олон Улсын Хөгжлийн Агентлагаас хэрэгжүүлж буй Хувийн Хэвшлийг Хөгжүүлэх Зээлийн Хөтөлбөрийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх банкаар сонгогдож шаардлага хангасан харилцагчдад бага хүүтэй, урт хугацааны зээлийг олгох боломжтой болсон юм.

Голомт банкны өөрийн хөрөнгө өсөн нэмэгдэж байгаатай уялдан нэг зээлдэгчид олгох зээлийн хэмжээ байнга өссөөр байна.

Дотооддоо зохион байгуулдаг сургалтын хөтөлбөрүүдээс гадна харилцагчдынхаа үйл ажиллагааны болон санхүүгийн чадавхийг хөгжүүлэх зорилго бүхий сургалт семинаруудыг тогтмол зохион байгуулсаар ирлээ. 2007 онд 19 сургалт семинар зохион байгуулсан ба тэдгээрт нийт 440 гаруй бизнес эрхлэгчид хамрагдсан байна.

Зээл (Тэрбум төгрөг)	2004	2005	2006	2007
Бизнесийн том зээл	82	119	155	269
Жижиг Дунд Бизнесийн зээл	10	13	18	24
Хэрэглээний зээл	3	4	5	20
Орон сууцны зээл	4	5	8	22
Нийт	99	141	186	335

ГАДААД ТӨЛБӨР ТООЦОО


Сүүлийн таван жилд гадаад худалдааны эргэлт гучаас дээш хувиар өсөхийн зэрэгцээ Монголчууд олноороо гадаадад ажиллаж, амьдрах болсон, мөн гадаадын компаниуд Монголд хөрөнгө оруулалт хийж байгаа нь гадаад төлбөр тооцоо мөнгөн дүн, тоо хэмжээгээрээ өсөх үндэс болж байна.

Голомт банк дэлхийн тэргүүлэгч банкуудтай өргөн хүрээний хамтын ажиллагаатай бөгөөд, 2007 онд Citibank, Canadian Imperial Bank of Commerce, ING Bank, Kazkommertsbank, ОАО Внешторгбанк, Bank of China зэрэг дэлхийн нэр хүнд бүхий банкуудтай харилцаа шинээр тогтоож, хамтын ажиллагааны гэрээ байгуулсан.

Тус банк нь харилцагч банкуудаараа дамжуулан олон улсын хэмжээнд төлбөр тооцоо хийхээс гадна, Вестерн Юнионы сүлжээгээр гадаад төлбөр тооцооны үйлчилгээг үзүүлж байна. Вестерн Юнион нь 200 гаруй улс оронд үйл ажиллагаагаа явуулдаг мөнгөн гуйвуулгын дэлхийн томоохон, нэр хүнд бүхий компани юм. Вестерн Юнионы сүлжээгээр төлбөр тооцоо хийснээр дэлхийн аль ч өнцөг булан бүрээс хэдхэн минутын дотор найдвартайгаар мөнгөө хүлээн авч, шилжүүлэх боломжтой юм.

Гадаадын харилцагч банкуудаараа дамжуулан хийсэн болон Вестерн Юнионы сүлжээгээр хийсэн гадаад төлбөр тооцооны эргэлт буюу харилцагчдын гадаадын улс орон руу шилжүүлсэн, гадаадын байгууллагаас хүлээн авсан мөнгөн төлбөрийн хэмжээ өмнөх оноос 45 хувиар нэмэгдэж 3.7 триллион төгрөгт хүрсэн бөгөөд энэ нь Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлтийн 79 хувьтай тэнцүү байна.


Голомт банк
СВИФТ-ээр хийгдсэн гадаад төлбөр тооцоо,
зах зээлд эзлэх хувь



■ Монголоос явсан

Эх үүсвэр: Wachovia банк, Олон улсын төлбөр тооцооны семинар, 2008 оны 1-р сар

Голомт банк
Гадаад төлбөр тооцооны эргэлт (Тэрбум төгрөг)



■ Ирсэн ■ Явсан

2007 онд Монгол Улсын нийт гадаад худалдааны 52 хувь нь Хятад улстай хийгдсэн бөгөөд Хятадын юан гадаад төлбөр тооцоонд өргөн ашиглагдаж байна. Голомт банк нийт юанаар хийгдэх төлбөр тооцоонд тэргүүлэгч бөгөөд нийт юаны төлбөр тооцооны 70 хувь нь Голомт банкаар дамжин хийгдэж байна. Голомт банкаар хийгдсэн юаны төлбөр тооцоо өмнөх оноос 51 хувиар нэмэгджээ.

Свифт сүлжээгээр дамжуулан хийж байгаа Монгол Улсын нийт гадаад төлбөр тооцооны хувьд, шилжиж ирсэн төлбөр тооцооны 37 хувь, шилжүүлсэн төлбөр тооцооны 43 хувь нь Голомт банкаар хийгдэж байна.

Мөн гадаад худалдааны санхүүжилтийн үйл ажиллагаа өмнөх онтой харьцуулахад нийт мөнгөн дүнгээрээ 83 хувиар өссөн байна.

НӨӨЦИЙН БОЛОН АРИЛЖААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хөрөнгийн Удирдлагын Газар нь Актив Пассивын Хорооноос тодорхойлсон бодлого, чиглэлийн хүрээнд банкны нөөц, хөрвөх чадвар, хүүгийн түвшинг эрсдэлийн тодорхой түвшинд хамгийн өндөр үр ашигтай байхаар удирддаг. Актив Пассивын удирдлагын уламжлалт төвийг сахисан бодлого нь банкны үндсэн бодлогуудын нэг хэвээр байгаа бөгөөд цаашид эрсдэл үр ашгийн тэнцвэрийг хангаж бизнесээ өргөжүүлэх өргөн боломж байна.

МӨНГӨНИЙ ЗАХЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Нийт хөрөнгийн хэмжээгээрээ хамгийн том бөгөөд төлбөрийн чадвар хамгийн сайтай банкны хувьд Голомт банк нь банк хоорондын зах зээл дээр томоохон байр суурийг эзэлдэг.

Тус банк Засгийн газрын бонд, Монголбанкны үнэт цаасны арилжаанд идэвхтэй оролцдог бөгөөд 2007 онд нийт 40.9 тэрбум төгрөгийн Засгийн газрын бонд арилжаалагдсаны 10.1 тэрбумыг буюу 25 хувийг, 4.2 триллион төгрөгийн Монголбанкны үнэт цаас арилжаалагдсаны 1.3 тэрбум буюу 31 хувийг тус тус худалдан авсан байна.


ГАДААД АКТИВ, ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖАА

2007 оны эцсийн байдлаар Монголын банкны системийн хэмжээнд нийт 423.6 тэрбум төгрөгийн гадаад актив буюу бэлэн гадаад валют чек, гадаадын банкинд байршуулсан харилцах, хадгаламж, гадаадын үнэт цаас, гадаадын банк болон оршин суугч бусад олгосон зээл байгаагийн 46 хувь нь Голомт банкинд байршиж байгаа бөгөөд энэ үзүүлэлтээрээ дотоодын банкны системд тэргүүлээ.


Голомт банкны гадаад активын 7 хувь нь бэлэн гадаад валют, чек, 93 хувь нь гадаадын банк санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж байна.

Гадаадын банк санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламжийн 97 хувь нь олон улсын нэр хүнд бүхий байгууллагуудаас А-ээс дээш үнэлгээ авсан банк, санхүүгийн байгууллагуудад байршжээ.

Голомт банк
Гадаад актив (Тэрбум төгрөг)



Голомт банк
Гадаад актив, зах зээлд эзлэх хувь




САНХҮҮГИЙН ҮР ДҮН

Голомт банк үйл ажиллагааныхаа тогтвортой өсөлтийн үр дүнд татварын дараах ашгаа сүүлийн таван жилд долоо дахин өсгөж, 2007 онд хамгийн өндөр ашигтай ажиллалаа.

2007 онд нийт хөрөнгө өмнөх онд 353.2 тэрбум төгрөг байснаас 298.9 тэрбум төгрөг буюу 85 хувиар өсч 652 тэрбум төгрөгт хүрснээр нийт активынхаа хэмжээгээр Монголын хамгийн том банк болсон байна.

Бизнесийн бүхий л түвшинд өмнөх жилүүдээс өндөр ашигтай ажиллаж, 2006 онд дундаж өөрийн хөрөнгийн өгөөж 10.7 хувь байсан бол 2007 онд 17.3 хувь болон өссөн, үүний зэрэгцээ дундаж активын өгөөж өмнөх оноос 0.8 нэгжээр нэмэгдэж 1.6 хувь болж ашигт ажиллагаанд бодитой ахиц гарчээ.


Татварын дараах ашиг (Сая төгрөг)




Нэг ажилтанд ноогдох ашиг (Мянган төгрөг)



Дундаж активын өгөөж (%)



Дундаж өөрийн хөрөнгийн өгөөж (%)




Харилцагчдаас татсан харилцах, хадгаламж 81 хувиар буюу 228.8 тэрбум төгрөгөөр өсч 512.5 тэрбум төгрөгт, харилцагчдад олгосон зээл 85 хувиар буюу 148.3 тэрбум төгрөгөөр өсч 323 тэрбум төгрөгт тус тус хүрсэн.

Хэдийгээр эрсдэлтэй актив өндөр өсөлттэй байгаа боловч зээл, харилцах хадгаламжийн харьцаа ерөнхийдөө тогтвортой хадгалагдаж 2006 онд 62 хувь байсан бол 2007 онд ялимгүй өсч 63 хувьд хүрчээ.


Банкны нөөц 169.2 тэрбум төгрөг байснаас 87 хувь буюу 146.4 тэрбум төгрөгөөр өсч 315.6 тэрбум төгрөгт хүрлээ.

Дээрх санхүүгийн үр дүнгүүд бүхэлдээ Актив, Пассивын Бодлогын хэрэгжилт юм. Голомт банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт Монголбанкны шаардлагыг бүрэн хангаж ажилласан бөгөөд оны эцсийн байдлаар 49.3 хувь, жилийн дунджаар 53 хувьтай байлаа.


Нийт актив (Тэрбум төгрөг)




Цэвэр зээл (Тэрбум төгрөг)



Харилцагчдын харилцах, хадгаламж (Тэрбум төгрөг)



Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах хадгаламж (Тэрбум төгрөг)



САНХҮҮГИЙН ҮР ДҮН (үргэлжлэл)

Эрсдэлтэй активын хэмжээ 85 хувиар өсөхийн зэрэгцээ цэвэр хүүгийн орлого 5.67 тэрбум төгрөгөөр (65 хувиар) өсч 14.3 тэрбум төгрөгт хүрлээ. Зээлийн хүүгийн орлого 14 тэрбум төгрөгөөр (63 хувь) өсч 36.6 тэрбум төгрөгт, хадгаламжийн хүүгийн зардал 11 тэрбум төгрөгөөр (62 хувь) өсч 28 тэрбум төгрөгт тус тус хүрчээ.


Засгийн Газрын болон Төв Банкны үнэт цаасны арилжаанд идэвхтэй оролцсоноор борлуулахад бэлэн үнэт цаасны хүүгийн орлого 1.7 тэрбум (373 хувь) төгрөгөөр өсч 2.2 тэрбумд хүрсэн байна.

Хүүгийн бус шимтгэл үйлчилгээний цэвэр орлого 96 хувиар өсч (3.5 тэрбум төгрөг) 7.2 тэрбум төгрөгт хүрсэн нь дараах орлогын өсөлтөөс шалтгаалжээ.


- Харилцагчдын дансны тоо хэмжээ, хэрэглээний өсөлтөөс шалтгаалан дансны шимтгэл, үйлчилгээний хураамжийн орлого 618 сая төгрөгөөр (63 хувиар) өссөн;
- Нийт зээлийн багцын өсөлтөөс хамааран зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний шимтгэл, хураамжийн орлого 493 сая төгрөгөөр (63 хувиар) өссөн;
- Олон улсын болон дотоодын мөнгөн гуйвуулга, төлбөр тооцооны идэвхтэй үйл ажиллагааны үр дүнд гуйвуулгын шимтгэлийн орлого 829 сая төгрөгөөр өссөн;
- 76 хувийн картын гүйлгээний өсөлт, 47 хувийн карт эзэмшигчдийн тооны өсөлтийн үр дүнд картын орлого 98 сая төгрөгөөр өссөн;

Энэхүү хүүгийн болон хүүгийн бус орлогын өсөлттэй уялдан үйл ажиллагааны орлого 74 хувиар буюу 21.6 тэрбум төгрөг хүртэл өссөн байна.


Цэвэр хүүгийн орлого (Сая төгрөг)




Цэвэр хүүгийн бус орлого (Сая төгрөг)



Цэвэр хүүгийн ахиуц (%)



Үйл ажиллагааны орлого (Сая төгрөг)




Зээлийн болзошгүй эрсдэлийн сангийн зардлын хэмжээ 2006 онд 2.6 тэрбум төгрөг байсан бол 2007 онд 10 хувиар буурч 2.3 тэрбум төгрөг болсон.

Нийт зээлийн эрсдэлийн сангийн зардлын 76 хувь нь бизнесийн том зээлийн, үлдсэн хэсэг нь жижиг дунд бизнесийн болон хэрэглээний зээлийн болзошгүй эрсдэлийн сангийн зардал байна.

Өмнөх онд чанаргүй зээлийн хувь хэмжээ 6.7 хувь байсан бол 4.2 хувь болж буурсан бөгөөд үүнд Тусгай Активын хэлтсийн чанаргүй зээлүүдийг төлүүлэх талаар авсан арга хэмжээнүүд нөлөөлсөн. Нийт зээлийн болзошгүй эрсдэлийн сан нь чанаргүй зээлийн 102 хувьтай тэнцүү байна.


Чанаргүй зээлийн хувь хэмжээ (%)




Үйл ажиллагааны зардал 3.9 тэрбум төгрөгөөр буюу 63 хувиар өсч 10.1 тэрбум төгрөгт хүрсэн. Энэхүү өсөлт нь үйл ажиллагааны өндөр гүйцэтгэлтэй уялдсан урамшуулал, үйл ажиллагааны томоохон үр дүнгүүд, өсөлт бүхий бизнесд хийж буй хөрөнгө оруулалттай шууд холбоотой.

Боловсон хүчний зардал 45 хувиар, элэгдлийн зардал 155 хувиар өссөн нь Голомт банк сүүлийн хэдэн жилд ажиллагсад болон техник технологид онцгой анхаарч, хөрөнгө оруулалт хийж байгаагийн илрэл юм. Үйл ажиллагааны зардлын удирдлагын үр дүнд зардал орлогын харьцаа буюу үйл ажиллагааны зардлыг үйл ажиллагааны орлогод харьцуулсан харьцаа 2006 онд 50 хувь байсан бол 2007 онд ахиц гарч 47 хувь болсон.

Зардал орлогын харьцаа (%)



Боловсон хүчний зардал/Нийт үйл ажиллагааны орлого (%)




2006 онд орлогын албан татварын зардалд 1.1 тэрбум төгрөг буюу нийт татварын өмнөх орлогын 31 хувьтай тэнцэх, 2007 онд 1.8 тэрбум төгрөг буюу нийт татварын өмнөх орлогын 20 хувьтай тэнцэх татвар төлсөн. 2007 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулиар аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хувь хэмжээ буурч 3 тэрбумаас дээш (2006 онд: 100 саяас дээш) татвар ноогдох орлогод төлөх татвар 30 хувиас 25 хувь болж, 3 тэрбум хүртэл (2006 онд: 100 сая хүртэл) татвар ноогдох орлогод 15 хувиас 10 хувийн татвар төлөх болж буурсан.

ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭ


Голомт банк өөрийн хөрөнгөө удирдахдаа нэг талаас бизнесийн өсөлтийг хангах, харилцагчдын өмнө банкны эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх нөгөө талаас хувь нийлүүлэгчдэд зах зээлд өрсөлдөхүйц өгөөжийг бий болгох зохистой түвшинг хангаж ажилладаг.

Банкны өөрийн хөрөнгийн хэмжээ 2007 онд 7.4 тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашиг, Кредит Свисстэй байгуулсан гэрээний дагуу 10 сая ам.долларын 5 жилийн хугацаатай хоёрдогч өглөгөөр нэмэгдэж, нийт 19.1 тэрбум төгрөгөөр өсч 54.9 тэрбум төгрөгт хүрсний 38.7 тэрбум төгрөг буюу 69 хувь нь нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө байна. Жилийн эцсийн байдлаар эрсдэлээр жигнэсэн актив нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа 10.14 хувь, нийт өөрийн хөрөнгийн харьцаа 14.39 хувь болж Монголбанкнаас тогтоосон шаардлагаас даруй 4 хувиар өндөр байна.

Нийт өөрийн хөрөнгө (Тэрбум төгрөг)



Өөрийн хөрөнгийн хүрэлцээ (%)



Кредит Свисс банктэй Хоёрдогч өглөгт хөрвөх зээллэгийн гэрээнд Монголбанкны ерөнхийлөгч А. Батсүхийг байлцуулан гарын үсэг зурлаа.

ТАВАН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ҮР ДҮН

Доорх хүснэгтэд Голомт банкны 2003 оноос 2007 он хүртэлх хугацааны үйл ажиллагааны үр дүнг харуулав.

	2003	2004	2005	2006	2007
Балансын үзүүлэлтүүд (Сая төгрөг)					
Нийт актив	114,059	183,417	273,253	353,161	652,051
Нийт харилцах, хадгаламж	93,220	147,125	232,838	283,707	512,485
Цэвэр зээл	46,789	90,943	131,817	174,700	323,026
Нийт өөрийн хөрөнгө	9,793	14,590	20,275	35,794	54,871
Эрсдэлийн сангууд	5,295	8,010	10,579	12,338	14,314
Орлогын тайлангийн үзүүлэлтүүд (Сая төгрөг)					
Хүүгийн орлого	10,157	14,111	19,632	26,955	44,564
Хүүгийн зардал	(5,466)	(8,374)	(13,284)	(18,283)	(30,228)
Цэвэр хүүгийн орлого	4,691	5,737	6,348	8,672	14,336
Цэвэр хүүгийн бус орлого	1,557	3,200	4,249	3,698	7,231
Үйл ажиллагааны зардал	(3,011)	(3,714)	(4,450)	(6,179)	(10,078)
Эрсдэлийн сангийн зардал	(1,400)	(2,689)	(2,708)	(2,563)	(2,299)
Татварын зардал	(747)	(782)	(1,057)	(1,109)	(1,811)
Татварын дараах ашиг	1,089	1,752	2,381	2,520	7,378
Санхүүгийн бүтцийн харьцаанууд					
Нийт харилцах, хадгаламж / Нийт актив (%)	81.7%	80.2%	85.2%	80.3%	78.6%
Өөрийн хөрөнгө / Нийт актив (%)	8.6%	8.0%	7.4%	8.9%	5.9%
Цэвэр зээл / Нийт актив (%)	41.0%	49.6%	48.2%	49.5%	49.5%
Цэвэр зээл / Нийт харилцах, хадгаламж (%)	50.2%	61.8%	56.6%	61.6%	63.0%
Чанаргүй зээлийн харьцаа (%)	9.9%	8.4%	8.6%	6.7%	4.2%
Хөшүүргийн харьцаа (Дахин)	10.6	11.6	12.5	8.9	10.9
Ашигт ажиллагааны харьцаанууд					
Дундаж активын өгөөж (%)	1.2%	1.2%	1.1%	0.8%	1.6%
Дундаж өөрийн хөрөнгийн өгөөж (%)	15.5%	15.1%	14.4%	10.7%	17.3%
Цэвэр хүүгийн ахиуц (%)	6.8%	5.4%	3.8%	4.0%	4.1%
Зардал, орлогын харьцаа (%)	48.2%	41.6%	42.0%	50.0%	46.7%
Нэг ажилтанд ноогдох ашиг (Мянган төгрөг)	4,020	5,277	5,807	4,598	10,134
Эрсдэлийн үзүүлэлтүүд					
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ >10%	15%	13%	12%	17%	14%
Нийт гадаад валютын эрсдэлийн үзүүлэлт <+/-40%	28%	21%	32%	39.7%	8%
Нэг зээлдэгч түүнд холбогдох этгээдэд олгосон зээлийн нийт өөрийн хөрөнгөнд эзлэх хувь <20%	12%	19%	18%	18%	17%
Холбогдох этгээдэд олгосон зээлийн нийт өөрийн хөрөнгөнд эзлэх хувь <5%	1%	1%	0.1%	2%	3%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар > 18%	58%	51%	52%	53%	49%
Үндсэн хөрөнгийн харьцаа < 8%	2%	1%	1%	1%	1%

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА БА ХЯНАЛТ

Голомт банк үйл ажиллагаандаа учирч болох эрсдэлийг зээлийн, хөрвөх чадварын, хүүний, ханшийн, арилжааны буюу зах зээлийн, үйл ажиллагааны эрсдэлүүд гэсэн үндсэн бүлгүүдэд ангилдаг.

Эрсдэлийн Удирдлагын газар нь бүхий л эрсдэлийг хянаж, гүйцэтгэх захиралд шууд тайлагнаж ажилладаг. Эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго нь Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс тогтоосон эрсдэлийн зохистой түвшинд бизнесийн нэгжүүдэд актив хөрөнгийг зохистой хуваарилах замаар банкны ашигт ажиллагааг дээшлүүлэхэд чиглэнэ. Эрсдэлийн удирдлагын үндсэн үйл ажиллагаа нь эрсдэлийг тодорхойлох, хэмжих, хянах гэсэн дарааллаар тасралтгүй зохион байгуулагдаж ажилладаг.

ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Голомт банк эрсдэлийг системтэй зөв удирдах, хянах шаардлагын дагуу зохион байгуулалтын бүтцийг тогтоож, улмаар эрсдэлийг хариуцаж, удирдаж ажилладаг. Үүнд :

- Төлөөлөн Удирдах Зөвлөл нь банкны зорилго, зорилтуудыг тогтоож, бүхий л нэгжүүдийг зохион байгуулах бодлого, стратеги, зарчмуудыг баталж, мөрдүүлэх ерөнхий үүргийг гүйцэтгэдэг. Мөн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь эрсдэлийн багцын шинжилгээ, тайланг тогтмол авч байх зорилгоор Хяналтын Зөвлөл, Актив Пассивын хороо, Удирдлагын хороо, Зээлийн хороог томилж ажиллуулдаг;
- Эдгээр хороодууд нь Эрсдэлийн Удирдлагын газрын оролцоотойгоор эрсдэлийн удирдлагын стратегийг хөгжүүлэх, бодлого, зарчмуудыг хэрэгжүүлэх үүрэгтэй;
- Банкны бүхий л нэгжүүд өөрсдийн эрсдэлийг хариуцаж, удирдаж ажиллах үүрэгтэй;
- Эрсдэлийн Удирдлагын газар нь банкны хэмжээнд бодлого, журам, зохицуулалтуудын хэрэгжилтэд бие даасан хяналтын үүргийг гүйцэтгэнэ;
- Дотоод Аудитын газар эрсдэлийн удирдлага, хяналт, банкны засаглал, зохион байгуулалтын зохицол, үр дүнтэй байдалд хяналт тавьж, Хяналтын Зөвлөлд тайлагнаж ажиллана.

ЭРСДЭЛИЙН ТҮВШИН БА ХЯЗГААРЛАЛТ

Голомт банк доорхи хүчин зүйлсийг харгалзаж судалсны үндсэн дээр банкны эрсдэлийн түвшин, хязгаарлалтыг тогтоож ажилладаг. Үүнд:

- Гадаад, дотоод эдийн засгийн орчны төлөв байдал;
- Сангийн болон мөнгөний бодлого;
- Хууль эрх зүй, зохицуулалтууд;
- Зээл, санхүүгийн зах зээлийн өрсөлдөөн;
- Хувь нийлүүлэгчдийн хүлээлт, таамаглал;
- Стратеги, санхүүгийн зорилт.

ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ

Голомт банк нь банк болон харилцагч хоёр талын харилцан ашигтай нөхцлийг бүрдүүлсэн, зээлийн эрсдэлийг бууруулах олон талт арга, хэрэгсэл, практик туршлагуудыг нэвтрүүлсэн, үр дүнтэй хэрэгждэг зээлийн бодлого, үйл ажиллагаатай юм. Банкны нийт зээлийн нийт хөрөнгөд эзлэх хувь хэмжээ 2007 оны эцсээр 49.5 хувь, чанаргүй зээл 4.2 хувьтай байна.

Голомт банк нь зээлдэгчийн зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг хугацаанд нь бүрэн барагдуулж чадах эсэхэд зээлийг олгох үед судалж, олгосны дараа тогтмол хугацаанд хяналт тавих замаар зээлийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг. Мөн түүнчлэн зээлийн эрсдэлийн удирдлагын чухал бүрэлдэхүүн болох зээлийн хэмжээ, хязгаарлалт, зэрэглэл тогтоох, зээлдэгчдэд тавих урьдач нөхцөл болон барьцаа хөрөнгөд тодорхой шаардлага тавьж ажилладаг. Зарим онцгой үед зээлдэгчийн эрсдэлийг бүрэн тодорхойлох, илрүүлэх шаардлагын дагуу мэргэжлийн экспертүүд оролцуулан өргөтгөсөн судалгаа хийдэг. Зээл олгох эсэх шийдвэрийг хэмжээ, нөхцөл, онцлогоос хамааруулан шат дараатай дамжлагатай Зээлийн хороодуудаар хэлэлцүүлж баталдаг. Үүнд:

- Салбар нэгжийн зээлийн хороо - 30 сая төгрөг хүртэл;
- Зээлийн Дэд хороо - 30 сая төгрөгөөс 200 сая төгрөг хүртэл;
- Зээлийн хороо - 200 сая төгрөгөөс дээш.

Голомт банк нь цөөн тооны этгээд, бизнес, эдийн засгийн салбараас аливаа хэлбэрээр хамаарах хамаарлыг бага түвшинд байлгах бодлого, зарчимтай ажилладаг. Банк зээлийн бодлогодоо нэг зээлдэгчид тавих зээлийн дээд хэмжээ, тодорхой нэг эдийн засгийн салбарт олгосон нийт зээлийн хэмжээ нийт зээлийн багцад эзлэх хувийг тогтоож, баримталж ажилладаг.

Банк нь зээлдэгчид ба харилцааны менежерүүдийн тооны харьцааг тэнцвэртэй хадгалж, зээлдэгчид тавих хяналтыг үр дүнтэй зохион байгуулдаг. Энэ нь чанаргүй зээлийг эрт илрүүлэх боломжийг олгодог.

Сүүлийн жилүүдэд банкны системийн хүчтэй өрсөлдөөний дүнд зээлийн хүү буурч, зээлдэгчийн зүгээс байнга хүүний бага түвшинг шаардаж байна. Голомт банк үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх замаар зээлийн бодит хүүг тогтоон ажиллаж байна. Зээлийн бодлого, хүүний өөрчлөлтийн саналыг Актив Пассивын болон Зээлийн хороогоор хэлэлцүүлж шийдвэрлэдэг.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА БА ХЯНАЛТ (үргэлжлэл)


ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН ЗАГВАРЧЛАЛ

Голомт банк зээлийн эрсдэлийг тооцох загварыг боловсруулан, үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна. Уг загвар нь зээлийн хугацаа хэтрэлт, хүлээх алдагдлын үзүүлэлтийг үнэлдэг бөгөөд эдгээр үзүүлэлтүүдээр банкны ирээдүйд хүлээж болох зээлийн эрсдэлийг тооцдог юм.

Энэхүү загвар нь Олон улсын Базелийн хорооноос баталсан зөвлөмж, Нягтлан бодох Бүртгэлийн Стандартын хүрээнд нийцэн боловсрогдож, Дэлхийн нэр хүнд бүхий аудитын “Эрнст Энд Янг” компаниар баталгаажуулагдсан болно.

Энэхүү загварыг иргэдийн болон бизнесийн зээл, эдийн засгийн салбараар зээлийн эрсдэлийг үнэлэхэд ашигладаг. 2007 онд нийт үнэлгээгээр хугацаа хэтрэлт 2.5 хувь, хүлээгдэж буй эрсдэл 0.3 хувиар тооцогдсон бөгөөд энэ үзүүлэлт жилээс жилд буурчээ.


Зээлийн загварчлал



САЛБАРЫН ШИНЖИЛГЭЭ

Голомт банк эрсдэлийн багцыг эдийн засгийн салбараар ангилж, дүн шинжилгээ хийж үйл ажиллагаандаа ашигладаг. 2007 оны эцсээр банкны нийт актив 651.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх жилээс 95 хувиар өссөн байна. Банкны нийт активт гадаадын өндөр зэрэглэлийн банк санхүүгийн байгууллагуудад хадгалуулсан хөрөнгө томоохон хувийг эзэлж байна. Энэ нь банк нэг талаас санхүү төлбөрийн чадварыг хангах зорилгоор найдвартай газарт байршуулах бодлоготой шууд холбоотой. Голомт банк Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй банкуудтай харьцуулахад хөрвөх чадвартай актив хөрөнгөөр тэргүүн зэрэгт ордог бөгөөд гадаад тооцооны тал орчим хувийг дангаараа гүйцэтгэдэг байна.

Банкны актив хөрөнгө эдийн засгийн салбараар (Тэрбум төгрөг)



*Хамгийн найдвартай
банк учраас
харилцагчид манай
банкыг сонгож
үйлчлүүлдэг ажээ.*

“Итгэл хүлээсэн- Найдвартай банк”

ХӨРВӨХ ЧАДВАРЫН ЭРСДЭЛ


Хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь актив пассивын эргэн төлөгдөх хугацааг хооронд нь зохицуулж чадаагүй, урт хугацаатай, их хэмжээний зээл олгох, улмаар банкны актив хөрөнгө богино хугацаанд бэлэн мөнгө болж хөрвөх чадвар сулрах, харилцагчийн төлбөр тооцоог хугацаанд гүйцэтгэж чадахгүйд хүрэхийг хэлнэ.

Эрсдэлийн Удирдлагын газар нь Актив Пассивын хорооноос баталсан эрсдэлийг урьдчилан тодорхойлох 30 гаруй харьцаа, үзүүлэлтүүдийг байнга тооцож, үнэлгээ дүгнэлт гаргаж ажилладаг.

Доорх графикт актив хөрөнгийн эргэн төлөгдөх хугацааны шинжилгээг харуулав. Графикаас актив хөрөнгийн 94 хувь нь нэг жил хүртэл хугацаатай байгаа нь Голомт банк хөрвөх чадварын үзүүлэлтээр маш сайн байгааг харуулна.

Хөрвөх чадварын харьцаа	2006	2007
12 сарын 31	53.2%	49.3%
Жилийн дундаж	47.3%	53.0%
Жилийн хамгийн өндөр	53.2%	59.3%
Жилийн хамгийн бага	43.2%	49.3%

Эргэн төлөгдөх хугацааны шинжилгээ



Голомт банк хөрвөх чадварыг хангаж ажиллахын тулд дараахь бодлогыг баримталж ажилладаг: Үүнд:

- Сайн, зөв бүтэцтэй баланс,
- Тогтвортой санхүүжилтийн эх үүсвэр,
- Харилцагчид хандсан найрсаг үйлчилгээ,
- Хөрвөх чадвар бүхий актив хөрөнгийн удирдлага.

Эрсдэлийн Удирдлагын газраас эрсдэлийн нөлөөллүүдэд тогтмол мониторинг хийж, Актив Пассивын хороонд тайлагнадаг. Үүнд төрөл бүрийн нөхцөл байдал дахь мөнгөн урсгалын үнэлгээ, мөнгөний эрэлтийн прогноз, онцгой байдалд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, балансын бүтцийн өөрчлөлтийн мэдрэмжийн шинжилгээ зэргүүд багтдаг.

ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ

Зах зээлийн эрсдэл гэдэг нь валютын ханш, хүүний өөрчлөлтийн дүнд актив пассивын бодит үнэ цэнэд өөрчлөлт орохыг хэлнэ.

Актив Пассивын хороо зах зээлийн эрсдэлийг удирдах лимит, хязгаарлалтуудыг тогтоож, биелэлтэнд байнгын мониторинг хяналт тавьдаг.

Хөрөнгийн Удирдлагын газар өдөр тутмын үйл ажиллагаандаа Актив Пассивын хорооноос тогтоосон бодлого, лимит хязгаарлалтын хүрээнд үйл ажиллагаа явуулж, зах зээлийн эрсдэлийг удирдаж ажилладаг.

ХҮҮГИЙН ЭРСДЭЛ


Хүүгийн эрсдэл гэдэг нь зах зээл дээр хүү хэлбэлзсэний үр дүнд банкны орлогод өөрчлөлт орохыг хэлдэг. Дараах хүснэгтэд хүүгийн болзошгүй өөрчлөлтийн дүнд орлогын тайланд үзүүлэх мэдрэмжийн шинжилгээг харуулав.

	Хүүний өөрчлөлт (Basis Point)	Татварын өмнөх ашигт үзүүлэх нөлөө
2007	+90	-0.008%
2007	-120	0.008%
2006	+150	-0.017%
2006	-150	0.017%

ГАДААД ВАЛЮТЫН ЭРСДЭЛ

Валютын эрсдэл нь ханшийн өөрчлөлтөөс банкны ашигт ажиллагаанд өөрчлөлт орох байдлаар илэрдэг. Голомт банк гурван төрлийн “VaR” аргачлалыг ашиглан гадаад валютын нийт эрсдэлийг тооцоолдог. “VaR” нь зах зээлийн хэвийн нөхцөлд өндөр нарийвчлалтай итгэх завсарт хүлээж болох алдагдлыг хэмждэг.

“VaR” нь банкны зүгээс гадаад валютын ханшийн эрсдэлийг удирдах үндсэн хэрэгсэл юм. Өдөр тутмын “VaR” үр дүнг Актив Пассивын хороонд танилцуулж, лимит хязгаарлалтын хүрээнд байгаа эсэхэд хяналт тавьдаг. Доорх графикд 99 хувийн нарийвчлалтай итгэх завсарт (ten days of holding period) тооцож гаргасан 2007 оны “VaR” үр дүнг үзүүлэв.



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛ

Үйл ажиллагааны эрсдэл нь Базелийн хорооноос гаргасан зөвлөмжид тодорхойлсноор банкны дотоод үйл ажиллагаа, хүн, систем болон гадаад хүчин зүйлээс үүсэх эрсдэлийг багцлан ойлгоно.

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага нь банкны бүхий л үйл ажиллагаатай холбогдон үүсэх эрсдэлийг таньж мэдэх, үнэлэх, хяналт тавих, удирдах болон удирдлагыг холбогдох мэдээлэл, тайлангаар хангаж шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлж ажилладаг.

Эрсдэлийн Удирдлагын газар 2007 онд өнгөрсөн хугацааны банкны үйл ажиллагаанаас үүссэн алдаа, дутагдал, нэмэгдэл зардлын өгөгдлүүдийг нэгтгэн мэдээллийн баазыг үүсгэсэн. Энэ нь банк үйл ажиллагааны алдаа, дутагдлыг таамаглах, учир шалтгааныг тодорхойлох, эрсдэлийг үнэлэх боломжийг олгодог.

Голомт банк давтамж багатай, алдагдлын нөлөөлөл өндөртэй эрсдэлийг тодорхойлох зорилгоор гадны мэргэжлийн байгууллагуудаас ийм төрлийн статистик мэдээ цуглуулж, үнэлгээ тогтоодог. Үүний дүнд ийм төрлийн эрсдэлийг зайлуулах бодлого, журмуудыг сайжруулах, нэвтрүүлэх бололцоо олгодог төдийгүй мэргэжлийн даатгалын байгууллагуудад энэ төрлийн эрсдэлийг шилжүүлдэг.

Үйл ажиллагааны эрсдэлийг удирдахад хамгийн чухал арга бол сайн боловсруулагдсан сургалтын хөтөлбөр, кейсүүд, бодлого журмууд мөн бөгөөд Эрсдэлийн Удирдлагын газраас энэ тал дээр онцгой ач холбогдол өгч ажилладаг.

МЭДЭЭЛЛИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Голомт банк нь 2007 онд мэдээллийн системийн аюулгүй байдлын бодлогыг сайжруулан үйл ажиллагаанд нэвтрүүлж байна. Мэдээллийн системийн аюулгүй байдлын бодлого нь банкны мэдээллийн системийн байнгын тасралтгүй ажиллагааг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, мэдээллийн системд зөвшөөрөлгүй хандах, мэдээллийг өөрчлөх, мэдээллийн системд халдахаас хамгаалах, халдлага осол гарсан үед банкны мэдээллийн системийн бүрэн байдлыг хангахад чиглэнэ.

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ЭРСДЭЛ

Энэ онд бүтцийн өөрчлөлтийн хүрээнд Бодлогын хэрэгжилт, хяналтын албыг шинээр байгуулсан. Энэхүү алба нь Голомт банкны үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа дотоодын эрх зүйн зохицуулалт нь Монгол Улс болон Олон улсын холбогдох гэрээ, конвенци, хуулиуд, ёс зүйн кодоод нийцэж буй байдалд хяналт тавьж хуулийн хариуцлага хүлээх, санхүүгийн алдагдалд орох, нэр хүндээ алдах зэрэг эрсдэлүүдээс хамгаалах үүрэгтэй.

МӨНГӨ УГААХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Голомт банкны бодлогыг шинэчлэн боловсруулж мөрдөж ажиллах болсон. Энэхүү шинэчилэгдсэн бодлоготой холбогдуулан банкны бүхий л харилцагчийн мэдээллийг өргөтгөн, шинэчлэх ажил хийгдэж дууслаа. Өдөр тутмын гүйлгээнд хяналт тавих ажлыг автоматжуулан онлайн горимд шилжүүлж, хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Монголбанкны Санхүүгийн Мэдээллийн Албанд холбогдох тайлан мэдээг тогтмол гаргаж хамтран ажиллаж ирсэн.

Мөн хамтын ажиллагааны хүрээнд гадаадын харилцагч банкуудын шаардлагатай мэдээллээр хангаж хамтран ажиллаж байна.

Бизнесийн амжилт маань бидний ажиллаж амьдардаг орчинтой нягт уялдаатай гэдэгт Голомт банк итгэдэг. Тиймээс ч бид залуусын хөгжил, эрүүл мэнд, боловсрол, хүмүүнлэгийн чиглэлээр амьдралын чанар, чансааг дээшлүүлэх нийгмийн хариуцлагатай хөтөлбөрүүдийг дэмжихэд анхаарлаа төвлөрүүлэн ажилладаг.

ХҮҮХДҮҮДИЙН ТӨЛӨӨ

Бидний хамгийн үнэ цэнэтэй баялаг болох хүүхдүүдийнхээ сайн сайхны төлөө, тэдэнд итгэл найдвар, боломж бий болгохын төлөө нийгмийн олон төрөлт арга хэмжээнүүдийг зохион байгуулсаар ирлээ.

Тэдгээрийн нэг нь олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр тус банк түнш байгууллагуудтайгаа хамтран хүнд нөхцөлд амьдарч буй хүүхдүүдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Хүүхэд бүрийн төлөө” сэдэвт арга хэмжээг зохион байгуулсан явдал юм.

ОЮУТНУУДЫН ТӨЛӨӨ

Авъяаслаг, чадвартай залуусын сонирхлыг татах, тэднийг хөгжүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах нь бидний өрсөлдөх чадавхийн нэгэн бүрэлдэхүүн хэсэг юм. Эрдэм шинжилгээний бага хурал, сургалтын төлбөрийн дэмжлэг, оюутнуудтай болон оюутны клубүүдтэй хамтарсан олон нийтийн арга хэмжээ зэрэг оюутнуудыг дэмжих хэд хэдэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсээр ирлээ. 2003 оноос эхлэн Голомт банк их дээд сургуулиудад амжилттай, сайн суралцаж байгаа оюутнуудад зориулсан “Оюутны Тэтгэлэг Хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2007 онд 100 оюутанд тэтгэлэг олгосон.

БИЕЙН ТАМИР, СПОРТЫН БОЛОН УРЛАГЫН АРГА ХЭМЖЭЭНҮҮДИЙГ ИВЭЭН ТЭТГЭСЭЭР

Тус банк Азийн Боксын XXIV аварга шалгаруулах тэмцээн, Соёлын Төв Өргөөний 20 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулсан “Эгшиг дууны цэнгэлийн чуулал” тоглолтыг тус тус ивээн тэтгэлээ.

Голомт банк Монголын Үндэсний Олимпийн Багийн томоохон спонсор нь хэвээр байгаа агаад 2008 онд Бээжин хотноо болох олимпийн наадамд бэлтгэх ажилд нь тал бүрийн дэмжлэг үзүүлсээр байна.

БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД:

Харилцах, хадгаламжийн үйлчилгээ

- Харилцах
- Овердрафт
- Хугацаатай хадгаламж
- Хугацаагүй хадгаламж
- Хөвөгч хүүтэй хадгаламж
- Урьдчилсан хүүт хадгаламж
- Хуримтлалын хадгаламж
- Хадгаламжийн сертификат

Зээлийн үйлчилгээ

- Аж ахуйн нэгжийн зээл
 - Эргэлтийн хөрөнгийн зээл
 - Зээлийн шугам
 - Хөрөнгө оруулалтын зээл
 - Тусгай зориулалттай тоног төхөөрөмжийн түрээс
 - Банк бус санхүүгийн байгууллагын зээл
 - Хувийн хэвшлийг хөгжүүлэх зээл
 - Ашигт малтмалын зээл
- Банк хоорондын захиар олгох зээл
- Хамтын санхүүжилтийн зээл

Картын үйлчилгээ

- Мастер карт (дотоодын, олон улсын)
- Виза карт (дотоодын, олон улсын)
- Ко брэнд карт

Баталгаа

- Тендерийн баталгаа
- Төлбөрийн баталгаа
- Гүйцэтгэлийн баталгаа

Аккредитив

- Экспортын
- Импортын

Цахим банк

- Электрон банк
- Интернет банк
- SMS банк
- Биллинг
- Телефон банк

Төлбөр тооцоо, гуйвуулга

- Вестерн Юнион
- Олон улсын мөнгөн шилжүүлэг
- Дотоодын мөнгөн шилжүүлэг

Хувийн банкны үйлчилгээ

Бизнесийн зөвлөгөө өгөх үйлчилгээ

Үнэт зүйл хадгалах үйлчилгээ

Гадаад валютын арилжаа

Эскроу дансны үйлчилгээ

ИРГЭДЭД:

Харилцах, хадгаламжийн үйлчилгээ

- Харилцах
- Овердрафт
- Хугацаатай хадгаламж
- Хугацаагүй хадгаламж
- Хөвөгч хүүтэй хадгаламж
- Урьдчилсан хүүт хадгаламж
- Хуримтлалын хадгаламж
- Хадгаламжийн сертификат

Зээлийн үйлчилгээ

- Жижиг дунд бизнесийн зээл
 - Эргэлтийн хөрөнгийн зээл
 - Хөрөнгө оруулалтын зээл
 - Тусгай зориулалттай тоног төхөөрөмжийн түрээс
 - Дахин санхүүжилтийн зээл
 - Жижиг дунд бизнесийг хөгжүүлэх зээл
 - Азийн хөгжлийн банкны ажлын байр нэмэгдүүлэх төслийн зээл
 - Импортын зээл
 - Хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн жижиг дунд бизнесийг дэмжих зээл
 - Ногоон зээл
- Хэрэглээний зээл
 - Ахуйн хэрэглээний зээл
 - Орон сууцны засварын зээл
 - Цалингийн зээл
 - Автомашины зээл
 - Картын зээл
 - Сургалтын зээл
 - Картын инстолмент зээл
 - Хадгаламж барьцаалсан зээл
 - Тэтгэврийн зээл
 - Шуурхай зээл
- Орон сууцны зээл
 - АХБанкны санхүүжилтэй
 - Өөрийн эх үүсвэрийн
 - 40 мянган айлын орон сууц төслийн

Цахим банк

- Электрон банк
- Интернет банк
- SMS банк
- Биллинг
- Телефон банк

Төлбөр тооцоо, гуйвуулга

- Вестерн Юнион
- Олон улсын мөнгөн шилжүүлэг
- Дотоодын мөнгөн шилжүүлэг

Картын үйлчилгээ

- Мастер карт
 - Платинум
 - Алтан (дотоодын, олон улсын)
 - Энгийн (дотоодын, олон улсын)
 - Маестро (оюутны)
- Виза карт
 - Платинум
 - Алтан (дотоодын, олон улсын)
 - Классик (дотоодын, олон улсын)
 - Виза электрон (оюутны)
 - Тунгалаг
- Ко брэнд карт
 - Миат мэйлэж
 - Айр нэтворк
 - Чамперс
- Алтан түрүү юаны карт

Хувийн банкны үйлчилгээ

Бизнесийн зөвлөгөө өгөх үйлчилгээ

Үнэт зүйл хадгалах

Чекийн үйлчилгээ

Эскроу дансны үйлчилгээ

БАНКНЫ САЛБАР НЭГЖҮҮДИЙН ХАЯГ

ГОЛОМТ БАНКНЫ ТӨВ АЛБА

3, Сүхбаатарын талбай,
Улаанбаатар хот, 210620А
Утас: +(976-11) 311971, 311530
Факс: +(976-11) 312307, 311958
И-шуудан: mail@golomtbank.com
Вэб: http://www.golomtbank.com

УЛААНБААТАР ХОТОД БУЙ САЛБАР, НЭГЖҮҮД

	Нэр	Хаяг	Холбоо тогтоох утас, факс
1-р салбар	Төв Салбар	Худалдааны гудамж 6/2, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот	Утас: (976-11) 310759, 313155 Факс: +(976-11) 326231
2-р салбар	Сансар Салбар	15-р хороолол, Баянзүрх дүүрэг, Баянцээл худалдааны төв, Улаанбаатар хот	Утас: +(976-11) 456980 Факс: +(976-11) 456829
3-р тооцооны төв	Нисэх Тооцооны төв	Хан-Уул дүүрэг, “Чингис хаан” Олон Улсын Нисэх буудал, Улаанбаатар хот	Утас: +(976-11) -283205 Факс: +(976-11) -283205
4-р тооцооны төв	100 айл Тооцооны төв	Сүхбаатар дүүрэг, 11-р хороолол, 7-р хороо Улаанбаатар хот	Утас: +(976-11)-350542 Факс: +(976-11)-350544
5-р салбар	Ард Салбар	Бага тойруу гудамж, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11) 320712, Факс: +(976-11) 330436
6-р салбар	Солонго Салбар	Нацагдоржийн гудамж, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11) 320814 Факс: +(976-11) 318479
7-р салбар	Саппоро Салбар	1-р хороолол, Сонгино-Хайрхан дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11) 681267 Факс: +(976-11) 680367
8-р салбар	Москва Салбар	Москва комплекс, 3-р хороолол, Баянгол дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11) 305419 Факс: +(976-11) 368602
9-р тооцооны төв	Гааль Тооцооны төв	Улаанбаатар хот, Гаалийн газрын байр, Баянгол дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11) 242943 Факс: +(976-11) 242943
10-р тооцооны төв	Багануур Тооцооны төв	Багануур дүүрэг, Холбооны байр, Улаанбаатар хот	Утас: +(976-01-21) 22333 Факс: +(976-01-21) 20818
12-р салбар	Зээлийн төв	Энхтайваны өргөн чөлөө, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11) 330072 Факс: +(976-11) 330621
13-р салбар	Голомт хотхон Салбар	Үндсэн хуулийн гудамж, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11) 322943 Факс: +(976-11) 322943
17-р тооцооны төв	Цамбагарав Тооцооны төв	Цамбагарав худалдааны төв, 1-р хороолол, Сонгино хайрхан дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11) 680762 Факс: +(976-11) 680763
19-р тооцооны төв	Цэцээ гүн Тооцооны төв	Чингэлтэй дүүрэг, 4-р хороо Улаанбаатар хот	Утас: +(976-11)316395 Факс: +(976-11)316395
20-р тооцооны төв	Тэди Тооцооны төв	Чингэлтэй дүүрэг, Самбуугийн гудамж -46, 5-р хороо, Улаанбаатар хот	Утас: +(976-11) 325970 Факс: +(976-11) 325970
22-р тооцооны төв	120.000 Тооцооны төв	Хан-Уул дүүрэг, 1-р хороо, 120 мянгат үйлчилгээний төв	Утас: +(976-11) 70130080
23-р тооцооны төв	Энхтайваны гүүр Тооцооны төв	Чингисийн өргөн чөлөө-11, 2-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот Тээвэр үйлчилгээний төв	Утас: +(976-11) 315949
24-р тооцооны төв	Тамир Тооцооны төв	Ард-Аюушийн гудамж, 3-р хороолол, Баянгол дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11) 304959 Факс: +(976-11) 304959

ОРОН НУТАГТ БУЙ САЛБАР ТӨВҮҮД

	Нэр	Хаяг	Холбоо тогтоох утас, факс
11-р Тооцооны төв	Дорнод Тооцооны төв	Дорнод аймаг, Хэрлэн сум, 7-р баг	Утас: +(976-01-582)-22703 Факс: +(976-01-582)-22702
13-р Тооцооны төв	Замын үүд Тооцооны төв	Дорноговь аймаг, Замын үүд сум, 1-р баг	Утас: +(976-025-245)-43773 Факс: +(976-025-245)-43773
14-р Тооцооны төв	Орхон Салбар	Орхон аймаг, Баян-Өндөр сум, Амарын талбай	Утас: +(976-01-352)-25100 Факс: +(976-01-352)-22510
21-р Тооцооны төв	Орхон-Пирамид Тооцооны төв	Орхон аймаг, Баян-Өндөр сум, Согоот баг	Утас: +(976-01-352)-23300 Факс: +(976-01-352)-23300
15-р Тооцооны төв	Дархан Салбар	Дархан-уул аймаг, Дархан сум, 13 дугаар баг, Нийгмийн даатгалын хэлтсийн байр.	Утас: +(976-01-372)-27136 Факс: +(976-01-372)-27136
18-р Тооцооны төв	Хөвсгөл Тооцооны төв	Хөвсгөл аймаг, Мөрөн сумын 3 дугаар хороо	Утас: +(976-01-382)-21474 Факс: +(976-01-382)-21474
16-р Тооцооны төв	Өмнөговь Тооцооны төв	Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 3-р баг	Утас: +(976-01-532)-23991 Факс: +(976-01-532)-23990



Голомт банкны төв байр болон Бодь цамхаг



ГОЛОМТ БАНК



ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТЫН ТАЙЛАН

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**Голомт Банк ХХК-ийн хувьцаа эзэмшигчид**

Бид Голомт Банк ХХК-ийн 2007 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх тайлан тэнцэл, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн орлого, үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн дараах санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор Банкны захирлуудын хүлээх үүрэг

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь Банкны захирлуудын хариуцлага байдаг. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх мөн нөхцөл байдалд уялдсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх замаар залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэж байх хариуцлага орно.

Аудиторын хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт гарган, өөр аливаа нэг этгээдэд биш Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 91 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох та бүхэнд тайлагнах нь бидний үүрэг юм. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Бид аудитаа Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Тэдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудад нийцэж ажиллах мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой баталгаажуулалтыг олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Сонгон авах горимууд нь залилан болон алдааны улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдсэнээс үүсэх эрдслийн үнэлгээ зэргийг багтаасан аудиторын мэргэжлийн үнэлэмжүүдээс хамаарна. Тэдгээр эрсдэлийн үнэлгээнүүдийг хийхдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй эсэх талаар дүгнэлт гаргах зорилгоор биш зөвхөн тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиох үүднээс байгууллагын санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, тэдгээрийг үнэн зөв толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг харгалзаж үздэг. Мөн аудитын ажилд хэрэглэгдэж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын таарамж, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тооцооллуудын бодитой эсэхийг үнэлж үзэх ажил орно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадсан гэдэгт бид итгэлтэй байна.

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр эдгээр санхүүгийн тайлангууд нь 2007 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу үнэн, зөв бодитой үзүүлсэн байна.

 Ernst & Young Mongolia Audit LLC
ЭРNST Энд ЯНГ
МОНГОЛИА
АУДИТ
ХХК
УХН7346 2685247

Улаанбаатар, Монгол Улс
2008 оны 2 дугаар сарын 29

ГОЛОМТ БАНК ХХК
2007 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН
ЖИЛИЙН ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

	Тодруулга	2007 мян.төг	2006 мян.төг
Хүү болон түүнтэй адилтгах орлого	3	44,563,827	26,954,740
Хүү болон түүнтэй адилтгах зардал	4	(30,227,766)	(18,282,530)
Хүүгийн цэвэр орлого		14,336,061	8,672,210
Шимтгэл хураамжийн орлого	5	6,445,506	4,405,661
Шимтгэл хураамжийн зардал	5	(1,238,795)	(1,015,137)
Шимтгэл хураамжийн цэвэр орлого	5	5,206,711	3,390,524
Бусад үйл ажиллагааны орлого	6	2,023,997	307,612
Үйл ажиллагааны орлого		21,566,769	12,370,346
Үйл ажиллагааны зардал	7	(10,078,312)	(6,179,410)
Зээлийн үнэ цэнийн бууралтын өмнөх ашиг		11,488,457	6,190,936
Зээлийн үнэ цэнийн бууралтын зардал	8	(2,299,279)	(2,562,829)
Татварын өмнөх ашиг		9,189,178	3,628,107
Орлогын албан татварын зардал	9	(1,811,455)	(1,108,565)
Банкны хувьцаа эзэмшигчдэд ногдох тайлант жилийн ашиг		7,377,723	2,519,542

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ГОЛОМТ БАНК ХХК

2007 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ ТАЙЛАН ТЭНЦЭЛ

	Тодруулга	2007 мян.төг	2006 мян.төг
АКТИВ			
Бэлэн мөнгө, Төв банкин дахь харилцах	10	74,529,087	40,130,171
Бусад банк санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	11	206,106,834	114,084,513
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	12	2,565,117	688,092
Санхүүгийн хөрөнгө оруулалт-Борлуулахад бэлэн	13	34,950,867	14,996,837
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	14	323,026,324	174,700,230
Үндсэн хөрөнгө	15	4,718,911	3,470,099
Биет бус хөрөнгө	16	1,938,152	304,491
Бусад актив	17	4,215,615	4,787,031
НИЙТ АКТИВ		652,050,907	353,161,464
ПАССИВ			
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	18	36,819,404	20,237,532
Харилцагчдын харилцах, хадгаламж	19	512,485,147	283,706,768
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	12	2,690,323	688,092
Зээлээр авсан эх үүсвэр	20	21,911,445	6,876,911
Хоёрдогч өглөг	21	15,860,015	4,500,000
Бусад өр төлбөр	22	23,436,369	5,427,724
Татварын өглөг		176,415	430,371
НИЙТ ПАССИВ		613,379,118	321,867,398
БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД НОГДОХ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ			
Дүрмийн сан	23	21,934,142	21,934,142
Хуримтлагдсан ашиг		16,737,647	9,359,924
НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		38,671,789	31,294,066
НИЙТ ПАССИВ БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		652,050,907	353,161,464

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ГОЛОМТ БАНК ХХК
2007 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН
ЖИЛИЙН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тодруулга	Дүрмийн сан мян.төг	Хуваарилагдах Хуримтлагдсан ашиг мян.төг	Нийт мян.төг
2006 оны 1 сарын 1-нээр	13,434,142	6,840,382	20,274,524
Тайлант жилийн цэвэр ашиг	-	2,519,542	2,519,542
Тайлант жилд нэмэгдсэн	23	8,500,000	8,500,000
2006 оны 12 сарын 31-эээр	21,934,142	9,359,924	31,294,066
Тайлант жилийн цэвэр ашиг	-	7,377,723	7,377,723
2007 оны 12 сарын 31-нээр	21,934,142	16,737,647	38,671,789

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ГОЛОМТ БАНК ХХК

2007 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	2007	2006
	мян.төг	мян.төг
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Татварын өмнөх ашиг	9,189,178	3,628,107
<i>Тохируулга :-</i>		
Үндсэн хөрөнгийн элэгдэл	1,621,590	636,292
Биет бус хөрөнгийн хорогдуулалт	257,924	89,020
Данснаас хассан үндсэн хөрөнгө	33,395	4,096
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын алдагдал	2,252,121	2,562,829
Бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдал	47,158	-
Ханшийн өөрчлөлтийн бодит бус алдагдал	92,709	446,866
Санхүүгийн хөрөнгө оруулалт борлуулсны олз	-	(22,430)
Үндсэн хөрөнгө борлуулсны гарз	-	1,320
Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг	13,494,075	7,346,100
<i>Үйл ажиллагааны активын өөрчлөлтүүд:-</i>		
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	(150,670,924)	(45,893,029)
Бусад актив	524,258	(568,095)
<i>Үйл ажиллагааны пассивын өөрчлөлтүүд:-</i>		
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	16,581,872	12,801,543
Харилцагчдын харилцах, хадгаламж	228,778,379	50,869,212
Бусад өр төлбөр	18,032,727	1,040,735
Үйл ажиллагаанаас орсон бэлэн мөнгө	126,740,387	25,596,466
Орлогын албан татварын төлөлт	(2,065,411)	(883,960)
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	124,674,976	24,712,506
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Санхүүгийн хөрөнгө оруулалтын цэвэр бууралт/(өсөлт)	(19,954,030)	5,002,757
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	14,804
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	(2,903,797)	(1,049,134)
Биет бус хөрөнгийн худалдан авалт	(1,891,585)	(273,174)
Хөрөнгө оруулалтанд зарцуулсан цэвэр мөнгөн гүйлгээ	(24,749,412)	3,695,253
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Дүрмийн сангийн өсөлт	-	8,500,000
Зээлийн санхүүжилтийн татан авалт	17,443,664	2,308,406
Зээлийн санхүүжилтийн эргэн төлөлт	(2,409,130)	(3,543,954)
Хоёрдогч өглөгийн татан авалт	11,461,139	4,500,000
Санхүүгийн үйл ажиллагаанаас орсон цэвэр мөнгөн гүйлгээ	26,495,673	11,764,452
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт	126,421,237	40,172,211
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл (Тодруулга 24)	154,214,684	114,042,473
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл (Тодруулга 24)	280,635,921	154,214,684

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ГОЛОМТ БАНК ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2007 ОНЫ 12 САРЫН 31

1. БАНКНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Тус банкны үндсэн үйл ажиллагаа нь Монголбанкнаас олгосон 8 тоот зөвшөөрлийн дагуу банк, санхүүгийн үйлчилгээ байна. Тайлант хугацаанд банкны үйл ажиллагааны мөн чанарт томоохон өөрчлөлт гараагүй болно.

Банк нь Монгол улсад бүртгэлтэй, тус улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг хязгаарлагдмал хариуцлагатай компани юм. Банкны үндсэн үйл ажиллагаагаа явуулдаг албан хаяг нь Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар хот 210620А Монгол Улс.

Банкны толгой компани Монгол улсад бүртгэлтэй Бодь Интернэшнл ХХК юм.

ТУЗ-ын 2008 оны 2 сарын 29-ний өдрийн шийдвэрээр Банкны 2007 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн тайланг баталж, нийтэд мэдээлэхийг зөвшөөрсөн.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД

2.1 ТАЙЛАН БЭЛТГЭХ ҮНДЭСЛЭЛ

Банкны санхүүгийн тайлангууд нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу бэлтгэгдсэн болно (СТОУС).

Санхүүгийн тайлангууд нь бодит үнээр хэмжигдсэн үүсмэл санхүүгийн хэрэглүүр болон борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын дахин үнэлгээг эс тооцвол түүхэн өртгийн зарчмаар бэлтгэгдсэн болно. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг тодруулгад өөрөөр зааснаас бусад тохиолдолд Монгол төгрөгөөр, мянганы орноор тайлагнасан.

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО

(а) Хүү болон түүнтэй адилтгах орлого ба зардал

“Арилжаалах зорилгоор эзэмшиж байгаа” эсвэл “Бодит үнийн өсөлт бууралт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх” гэж ангилагдсан санхүүгийн хэрэглүүрүүдээс бусад бүх хүүтэй санхүүгийн хэрэглүүрүүдийн хүүгийн орлого, зардлыг холбогдох санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрийн үр ашигт хүүгийн хувийг хэрэглэн орлогын тайланд “Хүү болон түүнтэй адилтгах орлого” ба “Хүү болон түүнтэй адилтгах зардал” гэж хүлээн зөвшөөрнө. Үнэ цэнийн бууралтад орсон зээл, урьдчилгааны хүүгийн орлогоос бусад хүүгийн орлогыг аккруэл сууриар орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө. Үнэ цэнийн бууралтад орсон санхүүгийн хөрөнгийн хүүгийн орлогыг анхны үр ашигт хүүгийн хувь хэмжээгээр тооцож хүлээн зөвшөөрнө.

(б) Хураамж ба шимтгэлийн орлого

Банкны шимтгэл, хураамжийн орлого ихэвчлэн мөнгөн гуйвуулгын хураамж, зээл олголтын хураамж, дебит болон кредит картын хураамж болон харилцах дансны зарлагын шимтгэлээс бүрддэг. Хураамж ба шимтгэлийн орлогыг үйлчилгээ үзүүлсэн хугацаанд нь голдуу аккруэл сууриар хүлээн зөвшөөрдөг.

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(б) Хураамж ба шимтгэлийн орлого (үргэлжлэл)

Зээл олгогдох магадлалтай зээлийн үүргийн хураамж болон зээлтэй холбоотой бусад хураамжуудыг (өсөн нэмэгдэх зардлуудын хамт) хойшлуулж зээлийн үр ашгийн хүүгийн залруулга гэж хүлээн зөвшөөрдөг.

(в) Гадаад валютын хөрвүүлэг

Банк нь санхүүгийн тайлангаа өөрийн үйл ажиллагааны болон тайлагналын мөнгөн нэгж болох Монгол төгрөгөөр гаргадаг. Гадаад валютын гүйлгээг анх бүртгэхдээ гүйлгээ хийгдсэн өдрийн ханшаар үйл ажиллагааны мөнгөн нэгжрүү хөрвүүлж бүртгэнэ. Гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг тайлан тэнцлийн өдрийн ханшаар дахин хөрвүүлдэг. Ханшийн бүх зөрүүг орлого, үр дүнгийн тайланд бүртгэнэ. Түүхэн өртөг нь гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг анхны гүйлгээний өдрийн ханшаар хөрвүүлнэ. Бодит үнэ цэнэ нь гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг бодит үнэ цэнэ тодорхойлогдсон өдрийн ханшаар хөрвүүлнэ.

(г) Орлогын албан татвар

Банк нь Монгол Улсын татварын хууль, тогтоомжид заасан татвар ногдох орлогыг нэмэгдүүлэхгүй орлого болон татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлын зүйлсээр залруулсан, санхүүгийн тайлагналын зорилгоор тодорхойлсон өөрийн орлогоос тайлан тэнцлийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй татварын хувь хэмжээгээр бодож өөрийн орлогын албан татварын хэмжээг тодорхойлдог.

Тайлан тэнцлийн өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн татвар ногдох дүн ба санхүүгийн тайлан дээрх бүртгэлийн дүнгийн хооронд гарах түр зөрүүнд өр төлбөрийн аргыг ашиглан хойшлогдсон татварыг хүлээн зөвшөөрнө. Үндсэндээ татвар ногдох бүх түр зөрүүнд хойшлогдсон татварын өрийг татвараас хасагдах бүх түр зөрүү, ашиглагдаагүй татварын хөнгөлөлт ба чөлөөлөлтөнд дараа тооцох татварын авлагыг тэдгээрт харгалзах татвар ногдох ашиг орж ирэх нь тодорхой болсон үед хүлээн зөвшөөрнө. Хэрэв түр зөрүү нь гүүдвил, сөрөг гүүдвил, эсвэл бизнесийн нэгдлийн бус хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээнээс бий болсон ба нягтлан бодох бүртгэлийн ашиг, татвар ногдох ашгийн аль алинд нөлөө үзүүлэхгүй бол хойшлогдсон татварыг хүлээн зөвшөөрөхгүй.

Тайлан тэнцлийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй эсвэл үйлчилж хараахан эхлээгүй байгаа татварын хувь хэмжээнүүд дээр үндэслэн хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах тайлант хугацаанд хэрэглэгдэхээр хүлээгдэж буй татварын хувь хэмжээгээр хойшлогдсон татварыг тооцно. Өөрийн хөрөнгөд шууд бүртгэх гүйлгээнээс үүссэн (энэ тохиолдолд хойшлогдсон татварыг мөн өөрийн хөрөнгөд шууд бүртгэнэ), эсвэл бизнесийн нэгдэлээс үүссэн (энэ тохиолдолд хойшлогдсон татвар нь үүссэн гүүдвил эсвэл сөрөг гүүдвил дүнд орно) хойшлогдсон татвараас бусад бүх хойшлогдсон татварыг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө.

(д) Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь бэлэн мөнгө ба Монголбанк болон бусад банкинд байршуулсан харилцах, хадгаламжаас бүрдэнэ.

(е) Санхүүгийн хэрэглүүр - анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт

(i) Хүлээн зөвшөөрөх өдөр

Санхүүгийн хөрөнгө худалдан авах, худалдахад холбогдох хөрөнгийг нь зах зээлийн журам, хэлцлээр тогтоосон хугацаанд зайлшгүй шилжүүлэхийг шаарддаг эдгээр худалдан авалт, борлуулалтыг арилжаа

хийгдсэн өдөр нь хүлээн зөвшөөрдөг. Өөрөөр хэлбэл банк хөрөнгийг худалдах, худалдан авахыг амласан өдөр хүлээн зөвшөөрнө. Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийг арилжааны өдрөөр хүлээн зөвшөөрнө.

(ii) Санхүүгийн хэрэглүүрийн анхны хүлээн зөвшөөрөлт

Анх хүлээн зөвшөөрч буй санхүүгийн хэрэглүүрүүдийн ангилал нь тэдгээрийн зориулалт, шинж чанараас шалтгаална. Санхүүгийн хэрэглүүрүүдийг анхлан бодит үнээр нь хэмжих ба харин бодит үнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэхгүй санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн хувьд бодит үнэ дээр тэдгээртэй шууд холбоотой худалдан авалтын эсвэл гаргалтын ахиуц зардлуудыг нэмсэн дүнгээр бүртгэнэ.

(iii) Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгддэг үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд

Үүсмэл санхүүгийн хэрэглүүрт кросс валютын своп, валютын ханшийн форвард гэрээ хэлцэлүүд, гадаад валютын опцион зэрэг багтана. Деривативуудийг бодит үнэ цэнээр нь бүртгэдэг ба бодит үнэ цэнэ нь эерэг байгаа үед хөрөнгө, харин сөрөг байгаа үед өр төлбөр гэж бүртгэнэ. Арилжаалах зорилгоор эзэмшиж буй үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнийн өөрчлөлтийг “Арилжааны цэвэр орлого” -д тусгадаг.

Хөрвөх чадвартай, хоёрдогч өглөгт агуулагдсан өөрийн хөрөнгө болон валютын үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд гэх мэт өөр санхүүгийн хэрэглүүрт агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийг салгаж авч үзэх ёстой ба агуулагдсан болон агуулагч гэрээнүүдийн эдийн засгийн үзүүлэлтүүд болон эрсдэлүүд нь нягт хамааралгүй, мөн агуулагч гэрээг нь арилжаалах зорилгоор эзэмшээгүй ба анхны хүлээн зөвшөөрөлтөөр бодит үнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгддэг ангилалд оруулаагүй байвал тэдгээрийг бодит үнээр нь бүртгэнэ. Агуулагч гэрээнд байсан ба тусгаарлуулсан үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийг арилжааны багцанд бодит үнэ цэнийн өөрчлөлттэй нь бодит үнээр нь бүртгэдэг ба тус өөрчлөлтийг нь орлого, зарлагын дансанд тайлагнадаг.

(iv) Арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр

Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдээс бусад, арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хэрэглүүрүүдийг багтаасан арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрүүдийг тайлан тэнцэлд бодит үнээр нь бүртгэнэ. “Арилжааны цэвэр орлого”-д бодит үнийн өөрчлөлтийг тусгана. Хүүгийн болон ногдол ашгийн орлого эсвэл зардлыг гэрээний нөхцлийн дагуу эсвэл гэрээний төлбөрийн эрх үүссэн үед “Цэвэр арилжааны орлого”-д бүртгэнэ.

Энэ ангилалд өрийн үнэт цаас, өөрийн хөрөнгө болон голдуу ойрын хугацаанд буцаан худалдан авах эсвэл худалдах зорилгоор эзэмшиж байгаа үнэт цааснууд багтана.

(v) Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгддэг санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр

Дараах нөхцлүүд хангагдсан үед санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг анхлан хүлээн зөвшөөрөхдөө энэ ангилалд оруулахаар шийдвэрлэж болно. Үүнд:

- энэхүү шийдвэр нь хөрөнгийг хэмжих эсвэл хөрөнгөөс үүсэх олз гарзыг ялгаатай сууриар орлого зардалд хүлээн зөвшөөрснөөс бий болох тууштай бус байдлыг арилгах эсвэл дорвитойгоор бууруулах бол эсвэл
- санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр нь санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн бүлгийн нэг хэсэг эсвэл тэдгээрийг эрсдэлийн удирдлагын бодлого эсвэл хөрөнгө оруулалтын стратегийн дагуу бодит үнэ дээр нь суурилан удирдаж, гүйцэтгэлийг нь хэмждэг бол эсвэл
- санхүүгийн хэрэглүүрт агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэглүүр багтаж байгаа бол (гэхдээ агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэглүүр нь мөнгөн урсгалыг нь ихээхэн хэмжээгээр өөрчлөхгүй нь эсвэл бага хэмжээний судалгааны үндсэн дээр эсвэл огт судалгаагүйгээр уг хэрэглүүр тусдаа бүртгэгдэхгүй нь тодорхой байгаагаас бусад тохиолдолд).

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(e) Санхүүгийн хэрэглүүр - анхны хүлээн зөвшөөрөлт ба дараа тайлангийн хэмжилт (үргэлжлэл)

(v) Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгддэг санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр (үргэлжлэл)

Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг тайлан тэнцэлд бодит үнээр нь тусгана. Бодит үнийн өөрчлөлтийг “Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн цэвэр олз эсвэл гарз” дансанд бүртгэнэ. Орж ирэх эсвэл төлөх хүүг гэрээний нөхцлийн дагуу хүүний орлого, зардалд хуримтлуулж, ногдол ашгийн орлогыг тус ногдол ашгийг хүртэх эрх үүссэн үед нь “Үйл ажиллагааны бусад орлого”-д бүртгэнэ.

(vi) ‘Анхны өдөр’-ийн ашиг

Идэвхигүй зах зээл дээрх арилжааны үнэ нь ижил хэрэглүүрүүдийн хувьд зах зээл дээр ажиглаж болохуйц одоогийн зах зээлийн бодит үнээс зөрүүтэй эсвэл зөвхөн зах зээл дээр ажиглаж болохуйц өгөгдлийг багтаасан хувьсагчтай үнэлгээний загварт үндэслэн тогтоосон бодит үнээс зөрүүтэй байвал уг зөрүү (энэ нь бодит үнэ ба арилжааны үнийн зөрүү буюу анхны өдрийн ашиг юм) Банк орлого, үр дүнгийн тайлангийн “Арилжааны цэвэр орлого”-д шууд хүлээн зөвшөөрнө. Ажиглах боломжгүй өгөгдлийг ашигласан тохиолдолд арилжааны үнийн зөрүү ба загварын үнийн зөрүүг орлого үр дүнгийн тайланд өгөгдлүүд нь ажиглаж болохуйц болох үед эсвэл тухайн хэрэглүүрийг үл хүлээн зөвшөөрөх үед л хүлээн зөвшөөрнө.

(vii) Дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалт

Банк нь дуусгавар хугацаа хүртэл эзэмших эерэг хандлага, чадвартай, тогтмол эсвэл тодорхойлж болохуйц төлбөртэй ба тогтоосон хугацаатай санхүүгийн хэрэглүүрүүдийг дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалт гэнэ. Эхний хэмжилтийн дараа дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалтыг үр ашигт хүүгийн арга ашиглаж тооцсон хорогдуулсан өртгөөс үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр хэмжинэ. Хорогдуулсан өртгийг үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болох худалдан авалтын урамшуулал, хөнгөлөлт болон шимтгэлийг оролцуулан тооцдог. Хорогдуулалт нь орлого үр дүнгийн тайлангийн “Хүү болон түүнтэй адилтгах орлого”-д багтана. Уг хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтаас үүссэн алдагдлыг орлого, үр дүнгийн тайлангийн “Санхүүгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын алдагдал” хэсэгт хүлээн зөвшөөрнө.

(viii) Банкуудад байршуулсан харилцах, хадгаламж ба харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа

Бусад банкуудад байршуулсан харилцах, хадгаламж болон харилцагчид олгосон зээл ба урьдчилгаа нь идэвхтэй зах зээл дээр бүртгэлгүй, тогтмол эсвэл тодорхойлох боломжтой төлбөрүүдтэй, тогтсон дуусгавар хугацаатай санхүүгийн хэрэглүүрүүд юм. Эдгээр санхүүгийн хэрэглүүрүүд нь богино хугацаанд шууд эсвэл дахин борлуулах зорилгогүй ба “Арилжаалах зорилгоор эзэмшиж байгаа хөрөнгө”, “Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт” эсвэл “Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх” ангилалуудад багтдаггүй. Анх хэмжээний дараа бусад банкуудад байршуулсан харилцах, хадгаламж болон харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн хорогдуулсан өртгөөс үнэ цэнэ бууралтын санг хассан дүнгээр бүртгэнэ. Хорогдуулсан өртгийг үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болох худалдан авалтын урамшуулал, хөнгөлөлт болон шимтгэлийг оролцуулан тооцно. Хорогдуулалт нь орлого, үр дүнгийн тайлангийн “Хүү болон түүнтэй адилтгах орлого”-д багтана. Уг хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтаас үүссэн алдагдал нь орлого, үр дүнгийн тайлангийн “Зээлийн алдагдлын зардал” хэсэгт хүлээн зөвшөөрөгдөнө.

(ix) Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт гэж анхны хүлээн зөвшөөрөлтөөр ийнхүү ангилагдсан эсвэл бодит үнийн өөрчлөлт нь орлого зарлагын дансанд бүртгэгддэг, дуусгавар хугацаа хүртэл эзэмших эсвэл зээл ба урьдчилгаа гэсэн ангилалд багтаагүй санхүүгийн хөрөнгийг хэлнэ. Эдгээрт өөрийн хөрөнгийн хэрэглүүр, хөрөнгө оруулалтын байгууллагад хийсэн хөрөнгө оруулалтууд ба мөнгөний зах зээл ба бусад өрийн хэрэгслүүд багтдаг.

Анх хүлээн зөвшөөрсний дараа борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтыг бодит үнээр нь хэмждэг. Бодит бус ашиг алдагдлыг шууд өөрийн хөрөнгөд “Борлуулахад бэлэн сан”-д хүлээн зөвшөөрдөг. Хөрөнгө оруулалтыг борлуулахад, өмнө хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан ашиг эсвэл алдагдлыг Орлого үр дүнгийн “Үйл ажиллагааны орлого” эсвэл “Бусад үйл ажиллагааны зардал”-д хүлээн зөвшөөрнө. Банк нь нэг төрлийн үнэт цаасанд нэгээс илүү хөрөнгө оруулалттай байвал тэдгээрийг борлуулахдаа “эхэлж авснаа эхэлж зарлагдах” зарчмыг хэрэгжүүлсэн гэсэн ойлголттой байгаа. Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтыг өөрт байх хугацаанд олсон хүү үр ашигт хүүгийн аргаар олсон хүүгийн орлого гэж тайлагнадаг. Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтыг өөрт байх хугацаанд олсон ногдол ашгийг төлбөрийн эрх нь тогтоогдсон үед орлого үр дүнгийн тайланд “Үйл ажиллагааны бусад орлого”-д хүлээн зөвшөөрдөг. Ийнхүү хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтаас үүссэн алдагдлыг орлого үр дүнгийн “Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдал”-д хүлээн зөвшөөрөөд борлуулахад бэлэн сангаас хасч өгнө.

(x) Зээлээр авсан эх үүсвэр ба хоёрдогч өр төлбөр

Гэрээт зохицуулалтын агуулга нь өөрийн тодорхой тооны хувьцааны оронд бэлэн мөнгө эсвэл өөр ямар нэг санхүүгийн хөрөнгийг өгөх үүргийг Банкнд үүсгэж байгаа үед, Банкаас гаргасан бөгөөд “Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх” гэж ангилагдаагүй санхүүгийн хэрэглүүрүүдийг “Зээлээр авсан эх үүсвэр” гэсэн нэрээр өр төлбөрийн хэсэгт ангилна. Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн аль алиных нь элементүүдийг агуулсан нийлмэл санхүүгийн хэрэглүүрүүдийн бүрэлдэхүүн хэсгүүдийг салгаж тус тусд нь бүртгэх бөгөөд өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүн хэсгийн дүн нь нийт дүнгээс өр төлбөрийн хэсгийн бодит үнийг (уг өр төлбөр үүссэн өдрийн бодит үнэ) хассан дүн байна.

Анх хүлээн зөвшөөрсний дараа, зээллэгүүдийг дараагийн тайлант хугацаанд үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ. Хорогдуулсан өртгийг тооцохдоо зээл авах үеийн хөнгөлөлт, урамшуулал ба үр ашигт хүүгийн нэг салшгүй хэсэг болж буй зардлуудыг авч үзнэ.

(ё) Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт

(i) Санхүүгийн хөрөнгө

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг (хэрэглэх боломжтой бол, санхүүгийн хөрөнгийн нэг хэсгийг эсвэл хоорондоо төсөөтэй нэг бүлэг санхүүгийн хөрөнгүүдийг) үл хүлээн зөвшөөрнө:

- Тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрх нь дууссан; эсвэл
- Банк тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал авах эрхээ шилжүүлсэн эсвэл “дамжуулан өнгөрөөх” хэлцэлийн дагуу хүлээн авсан мөнгөө нийт дүнгээр нь удаан хугацаагаар саатуулалгүйгээр гуравдагч талд төлөх мөн (а) үүрэг хүлээсэн
- Банк хөрөнгийн бараг бүх эрсдэл ба шагналыг гуравдагч талд шилжүүлсэн эсвэл (б) банк тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдэл ба өгөөжийг шилжүүлээгүй боловч хөрөнгийн хяналтыг шилжүүлсэн

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(ё) Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт (үргэлжлэл)

(i) Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

Банк хөрөнгөөс мөнгө хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл “дамжуулан өнгөрөөх” хэлцэл хийсэн боловч хөрөнгөтэй холбоотой ихэнх эрсдэл, шагнал болон хяналтыг шилжүүлээгүй тохиолдолд хөрөнгийг Банкны уг хөрөнгөд үргэлжлүүлэн оролцооор байх хэмжээгээр нь хүлээн зөвшөөрнө. Энэхүү үргэлжилсэн оролцоо нь шилжүүлсэн хөрөнгийн баталгаа хэлбэртэй байвал оролцоог тус хөрөнгийн анхны бүртгэлийн дүн ба Банкны төлөх шаардлагатай болох хамгийн их дүнгийн аль багаар хэмжинэ.

Шилжүүлсэн хөрөнгөтэй холбоотой үргэлжилсэн оролцоо нь борлуулсан ба/эсвэл худалдан авсан опцион (үүнд бэлэн мөнгөөр төлбөр хийгддэг опцион эсвэл ижил төрлийн хэлэлцээр багтсан) хэлбэртэй байвал тус оролцооны дүн нь Банкны буцаан худалдан авч болзошгүй шилжүүлсэн хөрөнгийн дүн юм. Гэсэн хэдий ч, бодит үнэ цэнээр хэмжигддэг хөрөнгийг худалдах опционтой үед Банкны үргэлжлүүлэн оролцооор байх хэмжээ нь шилжүүлсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ болон опцион хэрэгжих үнийн аль багаар нь хязгаарлагдана.

(ii) Санхүүгийн өр төлбөр

Санхүүгийн өр төлбөрийг төлөхөөс чөлөөлөгдсөн, өр төлбөр цуцлагдсан эсвэл хугацаа нь дууссан бол үл хүлээн зөвшөөрдөг. Хэрэв одоо оршин байгаа санхүүгийн өр төлбөрийн зээлдүүлэгч нь хэвээрээ боловч ялгаатай нөхцөлтэй зээлийн гэрээгээр орлуулсан эсвэл одоо байгаа зээлийн нөхцөл эрс өөрчлөгдсөн бол эдгээр өөрчлөлт шинэчлэлтийг санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт гэж үзэх ба тус тусынх нь дансны үнийн зөрүүг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө.

(ж) Бодит үнэ цэнийн тодорхойлолт

Идэвхтэй зах зээл дээр арилжаалагдаж буй санхүүгийн хэрэглүүрүүдийн тайлан тэнцлийн өдрийн бодит үнэ нь аливаа гүйлгээний зардлыг хасаагүй биржийн ханш болон диллерийн үнэ (урт позицийн хувьд нийлүүлэлтийн үнэ, богино позицийн хувьд эрэлтийн үнэ) -н дээр үндэслэгддэг.

Идэвхтэй зах зээл дээр бүртгэлгүй санхүүгийн хэрэглүүрүүдийн хувьд бодит үнийг нь тохиромжтой үнэлгээний аргуудыг ашиглан тодорхойлно. Эдгээр аргуудад цэвэр өнөөгийн үнэ цэнийн аргачлал, зах зээлийн үнийн мэдээ нь байдаг ойролцоо төсөөтэй өөр бусад санхүүгийн хэрэглүүрүүдтэй харьцуулсан арга, опционы үнэлгээний загвар болон бусад тохиромжтой аргууд багтана.

(з) Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Банк нь санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгүүд нь үнэ цэнийн бууралтад орсныг нотлох бодит нотолгоо байгаа эсэхийг тайлан тэнцлийн өдөр бүр үнэлж үзнэ. Хэрэв хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрсний дараа нэг буюу түүнээс олон тооны “Алдагдлын тохиолдол”-ын улмаас үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо бий болсон ба уг “Алдагдлын тохиолдол” нь санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн бодитойгоор тооцоолох боломжтой ирээдүйн мөнгөн урсгалд нөлөөлж байгаа үед санхүүгийн хөрөнгийг эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзнэ.

Үнэ цэнийн бууралтын нотолгоонд зээлдэгч эсвэл бүлэг зээлдэгчид нь санхүүгийн томоохон хүндрэлд орсон, зээлийн хүү болон үндсэн төлбөр зөрчилд орсон, дампуурал эсвэл санхүүгийн өөр бусад дахин зохион байгуулалтанд орох магадлалтай болсон, зөрчилтэй холбоотой эдийн засгийн нөхцөл байдалд гарсан өөрчлөлт гэх мэт тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалд хэмжиж болохуйц бууралт байгааг харуулсан бодит өгөгдөл бий болох зэрэг орно.

(i) Бусад банкуудад олгосон зээл, тэдгээрт байршуулсан харилцах, хадгаламж ба харилцагчдад олгосон зээл, урьдчилгаа

Хорогдуулсан өртгөөр бүртгэгддэг бусад банкуудад олгосон зээл, тэдгээрт байршуулсан харилцах, хадгаламж ба харилцагчдад олгосон зээл, урьдчилгааны дүнгүүдийн хувьд Банк нь эхлээд чухал ач холбогдолтой санхүүгийн хөрөнгө тус бүрийн хувьд үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа эсэхийг нэг бүрчлэн (тусгайлан), дараа нь чухал ач холбогдолгүй санхүүгийн хөрөнгүүдийг нийлүүлэн (бүлгээр нь) үнэлнэ. Хэрэв Банк нь нэг бүрчлэн үнэлэгдсэн санхүүгийн хөрөнгийн үнэлгээний хувьд (чухал ач холбогдолтой эсвэл ач холбогдолгүйг үл харгалзан) үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байхгүй гэж үзвэл ойролцоо зээлийн эрсдэлийн шинж чанар бүхий санхүүгийн хөрөнгийн бүлэгт оруулан үнэ цэнийн бууралтыг нь нэгдсэн байдлаар үнэлдэг. Үнэ цэнийн бууралтын нэг бүрчилсэн үнэлгээ хийгдсэн, үнэ цэнийн бууралтын алдагдал нь хүлээн зөвшөөрөгдсөн, эсвэл үргэлжилж буй хөрөнгийг бүлгийн үнэ цэнийн бууралтын үнэлгээнд оруулахгүй.

Үнэ цэнийн бууралтын алдагдал гарсан талаар бодит нотолгоо байгаа бол алдагдлыг тухайн хөрөнгийн бүртгэлийн дүн ба ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн (биеллээ олоогүй буй ирээдүйд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг оруулахгүй) зөрүүгээр хэмжинэ. Хөрөнгийн бүртгэлийн дүнг эрсдэлийн сангийн дансаар бууруулах ба алдагдлын дүнг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө. Хүүгийн орлогыг хөрөнгийн анхны, үр ашигт хүүгийн хувиар бууруулсан хөрөнгийн бүртгэлийн дүнгээс үргэлжлүүлэн тооцно. Цаашид эргэн төлөгдөх ямар нэг бодит чиг хандлага байхгүй ба барьцаа хөрөнгө нь бүрэн ашиглагдсан эсвэл банк уруу бүрэн шилжсэн үед зээлийг холбогдох зээлийн эрсдэлийн сангийн хамт данснаас хасна.

Хэрэв дараагийн тайлант жилд үнэ цэнийн бууралтын алдагдлын хэмжээ нь уг үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараа тохиолдсон үйл явдлын улмаас өссөн эсвэл буурсан байвал өмнө хүлээн зөвшөөрсөн эрсдэлийн сангийн дансыг бууруулж эсвэл нэмэгдүүлж залруулга хийнэ.

Хэрэв өмнө данснаас хассан байсан зээл эргэн төлөгдвөл тус төлөлтийг “Зээлийн алдагдлын зардал” дансны кредит талд бичнэ.

Орж ирнэ гэж тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг санхүүгийн хөрөнгийн анхны, үр ашигт хүүгийн хувиар дискаунтладаг. Зээлийн хүүгийн хувь нь хөвөгч байх нөхцөлд үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих хөнгөлөлтийн хувь нь өнөөгийн үр ашигт хүүгийн хувьтай тэнцүү байна. Барьцаатай санхүүгийн хөрөнгийн ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн тооцоо нь барьцааг нь хураан авах магадлалтай эсэхээс үл хамааран тус барьцааг хураан авч албадан борлуулахад гарах зардлыг хассаны дараах мөнгөн урсгалыг харуулдаг.

Үнэ цэнийн бууралтын нэгдсэн байдлаар үнэлэхийн тулд санхүүгийн хөрөнгийн төрөл, хамаарах салбар, газарзүйн байрлал, барьцаа хөрөнгийн төрөл, хугацаа хэтрэлтийн байдал болон бусад хүчин зүйлс зэрэг зээлийн эрсдэлийн шинж чанарыг агуулсан банкны дотоод зээллэгийн ангиллын системд үндэслэн тэдгээрийг бүлэглэнэ.

Эрсдэлийн бүлэг тус бүр дээр түүхэн дундаж алдагдлыг харгалзах зээлийн үлдэгдэлд нь хувааж үнэ цэнийн бууралтын алдагдлыг тооцох энгийн аргачлалыг сонгосон. Өнөө үед үгүй болсон түүхэн нөхцөл байдлын нөлөөг арилгах, түүхэн алдагдлын суурилж буй жилүүдэд хамааралгүй өнөөгийн нөхцөл байдлын нөлөөг харуулах үүднээс түүхэн алдагдлын мэдээнд өнөө үед ажиглагдахуйц өгөгдлүүдэд үндэслэн тохиргоо хийнэ.

Ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалын өөрчлөлтийн тооцоолол нь жил жилийн ажиглаж болохуйц холбогдох өгөгдлүүдийн өөрчлөлтүүдийг тусгасан. Үүнд: ажилгүйдлийн түвшин, эд хөрөнгийн үнэ, өргөн хэрэглээний барааны үнэ, төлбөрийн чадавхи, алдагдлыг илэрхийлэх хүчин зүйлс бүлгээр болон ач холбогдлоор нь.

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(з) Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)

(i) Бусад банкуудад олгосон зээл, тэдгээрт байршуулсан харилцах, хадгаламж ба харилцагчдад олгосон зээл, урьдчилгаа (үргэлжлэл)

Ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалыг тооцоолоход ашигласан аргачлал, таамаглалуудыг тооцоолсон алдагдал, бодитоор хүлээсэн алдагдлын хоорондын зөрүүг багасгах зорилгоор тогтмол хянана.

(ii) Дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт

Банк нь дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт нэг бүр дээр үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа эсэхийг үнэлж үзнэ. Үнэ цэнэ бууралтын алдагдал гарсан талаар бодит нотолгоо байгаа бол алдагдлыг тухайн хөрөнгийн бүртгэлийн дүн ба тооцоолсон ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ хоёрын зөрүүгээр хэмжинэ. Хөрөнгийн бүртгэлийн дүнг бууруулж, алдагдалын дүнг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө.

Хэрэв дараагийн тайлант жилд тооцоолж байсан үнэ цэнийн бууралтын алдагдлын хэмжээ нь уг үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараа тохиолдсон үйл явдлын улмаас буурвал өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын алдагдалыг “Санхүүгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын алдагдал” дансны кредитэд бүртгэнэ.

(iii) Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтын хувьд, Банк нь хөрөнгө оруулалт эсвэл бүлэг хөрөнгө оруулалт нь үнэ цэнийн бууралтад орсныг нотлох бодит нотолгоо байгаа эсэхийг тайлан тэнцлийн өдөр бүр үнэлж үзнэ.

“Борлуулахад бэлэн” гэж ангилагдсан өөрийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын хувьд үнэ цэнийн бууралтын бодит нотолгоонд бодит үнэ цэнэ нь тус хэрэглүүрийн өртгөөс их хэмжээгээр эсвэл тогтмол буурч байх явдал ордог. Үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа тохиолдолд хуримтлагдсан алдагдал (худалдан авалт ба өнөөгийн бодит үнэ цэнэ хоёрын зөрүүнээс орлого үр дүнгийн тайланд өмнө нь хүлээн зөвшөөрсөн байсан тухайн хөрөнгө оруулалттай холбоотой үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжигдэх)-ыг өөрийн хөрөнгөөс хасч орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө. Өөрийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнэ бууралтын алдагдлын буцаалтыг орлого, үр дүнгийн тайлангаар дамжуулдаггүй, үнэ цэнийн бууралтын дараах бодит үнэ цэнийн өсөлтийг өөрийн хөрөнгөд шууд хүлээн зөвшөөрдөг.

“Борлуулахад бэлэн” гэж ангилагдсан өөрийн хөрөнгийн хэрэглүүрийн хувьд түүний үнэ цэнийн бууралтыг хорогдуулсан өртгөөр бүртгэгдэх санхүүгийн хөрөнгүүдтэй адил шалгуур үзүүлэлтүүд дээр суурилан үнэлнэ. Зээлийн бууруулсан бүртгэлийн дүнгээс анхны үр ашигт хүүгийн хувь хэмжээгээр тооцон, хүүг үргэлжлүүлэн хуримтлуулах ба “Хүү ба түүнтэй адилтгах орлого”-ын нэг хэсэг болгон бүртгэнэ. Хэрэв дараагийн тайлант жилд өөрийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ нь өссөн ба уг өсөлт нь үнэ цэнэ бууралтын алдагдлыг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрсний дараа тохиолдсон үйл явдалтай уялдаатай болох нь тогтоогдсон бол, үнэ цэнийн бууралтын алдагдлыг орлого үр дүнгийн тайлангаар дамжуулан буцаана.

(iv) Зээлийн шинэчилсэн гэрээ

Банк нь барьцаа хөрөнгийг хурааж өөрийн болгохоос илүүтэйгээр аль болох гэрээг шинэчлэн байгуулах боломжийг хайж байдаг. Үүнд зээлийн эргэн төлөлтийн хуваарийг сунгах, зээлийн шинэ нөхцөлийг санал болгох зэрэг ойлголтыг хамруулж болох юм. Зээлийн гэрээг нэгэнт шинэчлэн байгуулсан бол зээлийг хугацаа хэтэрсэн гэж үзэхгүй. Гэрээнд заасан зээлийн шалгуур нөхцөлүүд биелж буй эсэх, ирээдүйн

зээл төлөлт хийгдэх баталгаа байгаа эсэхийг баталгаажуулах үүднээс зээлийн шинэчилсэн гэрээнд удирдлагын зүгээс байнгын хяналт тавин ажилладаг. Эдгээр зээл нь зээлийн анхны үр ашигт хүүгийн хувиар тооцоологддог нэг бүрчилсэн болон нийлмэл үнэ цэнийн бууралтын үнэлгээнд хамрагдсаар байх юм.

(и) Санхүүгийн хэрэглүүрүүдийг цэвэршүүлэх

Хэрэв байгууллага нь хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэх хуулиар олгогдсон эрхтэй, тооцоог цэвэр дүнгээр нь барагдуулах, эсвэл хөрөнгийг борлуулж өр төлбөрийг нь барагдуулах ажлыг нэгэн зэрэг хийхээр зэхэж байгаа л бол санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрүүдийг хооронд нь цэвэршүүлэн, цэвэр дүнгээр тайлан тэнцэлд толилуулах эрхтэй. Мастер цэвэршүүлэлт гэрээнүүдийн хувьд энэ нь хэрэгждэггүй ба холбогдох хөрөнгө болон өр төлбөрийг нийт дүнгээр нь тайлан тэнцэлд тус тусад нь толилуулдаг.

(й) Үндсэн хөрөнгө

Бүх үндсэн хөрөнгийг өртгөөр нь анх бүртгэдэг. Дараагийн тайлант хугацаанд гарсан зардлыг тухайн зардалтай холбогдсон ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг Банк хүртэх магадлалтай ба өртгийг нь найдвартайгаар хэмжих боломжтой тохиолдолд л хөрөнгийн бүртгэлийн дүнд нэмж эсвэл тусдаа хөрөнгө болгох хоёрын аль таарамжтай гэж үзсэнээр нь хүлээн зөвшөөрдөг. Аливаа сольсон хэсгийн бүртгэлийн дүнг үл хүлээн зөвшөөрнө. Бүх урсгал засварыг тэдгээрийн гарсан тайлангийн хугацаанд орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрдөг.

Хүлээн зөвшөөрсний дараах үед үндсэн хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан өртгөөр илэрхийлдэг.

Дуусаагүй барилгад элэгдэл байгуулдаггүй. Үндсэн хөрөнгийн элэгдлийг үндсэн хөрөнгийн төрөл бүрээр, дараах ашиглалтын жилийг үндэслэн шулуун шугамын аргаар байгуулдаг. Үүнд:

Барилга, байшин	40 жил
Тавилга, тээврийн хэрэглүүр	10 жил
Компьютер	3 жил

Үндсэн хөрөнгийн дүн, элэгдүүлэх хугацаа, арга нь өмнө хийгдсэн тооцоолол ба үндсэн хөрөнгөд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн өгөөжийн хүлээгдэж буй хэрэглээний хэв загварт нийцэж байгаа гэдгийг баталгаажуулах үүднээс үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жилийн эцэс бүрт хянаж үздэг.

Үндсэн хөрөнгийг худалдан борлуулах үед эсвэл тэдгээрийн ашиглалтаас ирээдүйд эдийн засгийн үр өгөөж орж ирэхгүй гэж үзсэн үед бүртгэлээс хасна. Үндсэн хөрөнгийн борлуулалтын цэвэр орлого (хэрэв байгаа бол), дансны цэвэр үнэ хоёрын зөрүүг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрдөг.

(к) Биет бус хөрөнгө

Тусад нь олж авсан биет бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь бүртгэдэг. Анх хүлээн зөвшөөрсний дараа, биет бус хөрөнгийг хуримтлагдсан хорогдуулалт болон үнэ цэнэ бууралтын алдагдлыг хассан өртгөөр нь тайланд тусгадаг.

Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа нь хязгаарлагдмал эсвэл хязгаарлагдмал бус байдаг. Хязгаарлагдмал ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн хувьд эдийн засгийн үр ашигтай ашиглалтын хугацааны турш хорогдуулж, үнэ цэнийн бууралтанд орсон байх магадлалын шинж тэмдэг илэрсэн тохиолдолд үнэ цэнийн бууралтад орсон эсэхийг үнэлнэ. Удирдлага хязгаарлагдмал бус хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулах хугацаа болон аргачлалыг хамгийн багадаа тайлант жил бүрийн эцэст хянаж үздэг.

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(к) Биет бус хөрөнгө (үргэлжлэл)

Тухайн хөрөнгийн хүлээгдэж буй ашиглалтын хугацаа эсвэл хүлээгдэж буй ирээдүйн үр өгөөжийн хэв загвар нь өөрчлөлтийг хорогдуулалтын хугацаа эсвэл аргыг аль тохиромжтой байдлаар өөрчлөх замаар бүртгэлд тусгах ба уг өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт гэж авч үзнэ. Хязгаарлагдмал хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулалтын зардлыг орлого, үр дүнгийн тайланд биет бус хөрөнгийн үүрэгтэй нь нийцсэн зардлын бүлэгт хүлээн зөвшөөрнө.

Банкны биет бус хөрөнгөд компьютерийн програм хангамж болон лицензүүд багтдаг бөгөөд тэдгээр нь хязгаарлагдмал ашиглалтын хугацаатай байна. Эдгээр биет бус хөрөнгийг тэдгээрийн ойролцоолон тооцоолсон ашиглалтын хугацаа болох 3 жилийн хугацаанд шулуун шугамын аргаар хорогдуулна.

(л) Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Хөрөнгө нь үнэ цэнийн бууралтад орсон байж болох шинж тэмдэг байгаа эсэхийг Банк тайлант хугацаа тутамд шалгаж үздэг. Хэрэв тийм шинж тэмдэг илэрсэн эсвэл жилд нэг удаа хийдэг хөрөнгийн үнэ цэнийн бууралтын тестийг хийж гүйцэтгэх үед Банк нь хөрөнгөөс цуглуулан авах боломжтой дүнг тооцож үздэг. Цуглуулан авах дүн нь хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн бодит үнэ цэнэ (борлуулалтын зардлыг хасаж тооцсон) ба ашиглалтын өртөг хоёрын аль өндөр нь байна. Хөрөнгийн дансны дүн нь цуглуулан авах дүнгээс илүү байгаа үед хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзэн цуглуулан авах дүнгээр нь бууруулан бүртгэнэ. Ашиглалтын үнийг үнэлэхдээ, тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалыг мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ ба хөрөнгөд харгалзах эрсдэлүүдийн талаарх өнөөгийн зах зээлийн үнэлгээнүүдийг тусгасан татварын өмнөх хөнгөлөлтийн хувь хэмжээгээр дискаунтчилан өнөөгийн үнэ цэнийг олно.

Тайлан тэнцлийн өдөр бүр өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын алдагдал арилсан эсвэл буурсан эсэх талаар ямар нэгэн шинж тэмдэг байгаа эсэх талаар үнэлгээг хийдэг. Хэрэв тийм шинж тэмдэг илэрвэл нөхөн төлөгдөх дүнг ойролцоолон тооцож үзнэ. Хамгийн сүүлд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрснөөс хойш хөрөнгийн цуглуулан авах дүнг тодорхойлоход ашигласан тооцооллуудад өөрчлөлт гарсан тохиолдолд л өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг буцаана. Хэрэв тийм бол хөрөнгийн бүртгэлийн дүнг цуглуулан авах дүн хүртэл нь өсгөж бүртгэнэ. Энэ өссөн дүн нь хэрэв өмнөх жилүүдэд хөрөнгөд үнэ цэнийн алдагдалыг хүлээн зөвшөөрөөгүй байсан бол байх ёстой байсан бүртгэлийн цэвэр дүнгээс (элэгдлийг хассан цэвэр дүн)-гээс хэтрэхгүй байна. Ийм буцаалтуудыг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө. Ийм буцаалтыг хийсний дараа, хөрөнгийн шинэ бүртгэлийн дүн (үлдэгдэл өртгийг хассан дүн)-г түүний ашиглалтын хугацаанд системтэйгээр хуваарилах үүднээс элэгдлийн зардалд залруулга хийнэ.

(м) Буцаан худалдан авах, урвуу буцаан худалдан авах хэлцлүүд

Ирээдүйд тодорхой заасан хугацаанд буцаан худалдан авах нөхцөлтэй хэлцэл ('repo')-ийн дор худалдсан үнэт цааснуудыг тайлан тэнцлээс үл хүлээн зөвшөөрдөггүй. Хүлээн авсан холбогдох бэлэн мөнгөө хуримтлуулсан хүүгийн хамт тайлан тэнцэлд 'Зээлдүүлсэн үнэт цаас ба буцаан худалдан авах хэлцлүүдийн бэлэн мөнгөөрх барьцаа' гэж тусгагдах ба энэ нь Банкинд олгосон зээл гэсэн эдийн засгийн утга агуулгыг илэрхийлдэг байна. Борлуулсан ба ирээдүйд буцаан худалдан авах үнийн зөрүүг хүүгийн зардал гэж үзэж үр ашигт хүүгийн аргыг ашиглан гэрээний хугацааны турш хуримтлуулна. Харин хөрөнгө хүлээн авагч нь тус хөрөнгийг борлуулах эсвэл барьцаанд тавих эрхтэй үед тус хөрөнгийг 'Барьцаанд тавьсан арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө' гэж тайлан тэнцэлд бүртгэнэ.

Харин буцаан худалдах хэлцэл ('урвуу репо')-ийн дор худалдан авсан үнэт цааснуудыг тайлан тэнцэлд хүлээн зөвшөөрдөггүй. Төлсөн мөнгө хуримтлуулсан хүүгийн хамт тайлан тэнцэлд 'Зээлсэн үнэт цаас ба урвуу буцаан худалдан авах хэлцлүүдийн бэлэн мөнгөөрх барьцаа' гэж тусгагдана. Худалдан авсан ба буцаан худалдах үнийн зөрүүг хүүгийн орлого гэж үзэж үр ашигт хүүгийн аргыг ашиглан гэрээний хугацааны турш хуримтлуулна.

(н) Санхүүгийн баталгаа

Банк бизнесийн хэвийн нөхцөлд голдуу тендерийн баталгаанаас бүрдэх санхүүгийн баталгаануудыг гаргадаг. Санхүүгийн баталгааг санхүүгийн тайланд анхлан бүртгэхдээ бодит үнээр нь буюу хүлээн авсан урамшууллын дүнгээр "Бусад өглөг"-т хүлээн зөвшөөрдөг. Ийнхүү анхлан хүлээн зөвшөөрсний дараа, баталгаа бүрт Банкны хүлээх хариуцлагыг хорогдуулсан урамшуулал ба уг баталгааны улмаас үүсэх аливаа нэг санхүүгийн үүргийг биелүүлэхэд шаардлагатай зардлын хамгийн сайн тооцоолсон дүн хоёрын аль ихээр нь хэмжинэ.

Санхүүгийн баталгааны холбогдох өр төлбөрийн аливаа өсөлтийг орлого, үр дүнгийн тайлангийн "Үнэ цэнийн бууралтын алдагдал" дансанд бүртгэнэ. Хүлээн авсан урамшууллыг санхүүгийн баталгааны хүчинтэй байх хугацааны туршид нь шулуун шугамын аргаар тооцож орлого, үр дүнгийн тайлангийн "Үйл ажиллагааны бусад орлого" дансанд хүлээн зөвшөөрнө.

(о) Ажиллагсдын тэтгэмж

(i) Богино хугацаат тэтгэмж

Цалин ба түүнтэй холбогдох бусад зардлуудыг Банкны ажилчдаас холбогдох үйлчилгээг үзүүлсэн тухайн жилд нь зардалд тусгана. Ажилтнуудад ээлжийн амралт зэрэг богино хугацааны чөлөөтэй үед нөхөн олговрыг ажилласан жилийг нь харгалзан олгодог, бөгөөд өвчтэй байх хугацааны нөхөн олговрыг цаг тухайд нь олгодог байна.

(ii) Заавал төлөх даатгалын шимтгэлүүд

Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд нь Монгол улсын Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын санд шимтгэл төлдөг. Эдгээр шимтгэлийг гарсан хугацаанд нь орлого, үр дүнгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.

(ө) Үйл ажиллагааны түрээс

Түрээслэгч тал бүх эрсдэлийг хүлээж, ашгийг хүртэх үйл ажиллагааны түрээсд төлж байгаа түрээсийн төлбөрийг түрээсийн хугацаанд шулуун шугамын аргаар бодож орлого, үр дүнгийн тайланд зардлаар бүртгэнэ.

(п) Энгийн хувьцааны ногдол ашиг

Энгийн хувьцааны ногдол ашгийг өр төлбөрт хүлээн зөвшөөрдөг бөгөөд Банкны хувь нийлүүлэгчдийн шийдвэрээр зөвшөөрөгдсөний дараа өөрийн хөрөнгөөс хасна. Банкны удирдлага ногдол ашгийг хугацааны дундуурх тайлант хугацааны үеэр зарласан ба эдгээр нь Банкны эрх мэдлээс гарсан тохиолдолд эдгээрийг өөрийн хөрөнгөөс хасч тусгана. Тухайн жилийн ногдол ашгийг тайлангийн өдрөөс хойш олгохоор шийдвэрлэсэн бол "Тайлангийн өдрийн дараа болсон үйл явдал" тодруулгад тусгана.

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУДАД ОРСОН ӨӨРЧЛӨЛТҮҮД

Банк нь дараах шинэ болон нэмэлт өөрчлөлт хийгдсэн СТОУС-ууд ба Санхүүгийн тайлагналын олон улсын тайлбарын хороо ("СТОУТХ")-ноос гаргасан тайлбаруудыг тайлант хугацаанд дагаж мөрдсөн.

* СТОУС 7	Санхүүгийн хэрэглүүрүүд: Тодруулгууд
* НББОУС 1	Нэмэлт өөрчлөлт - Капиталын толилуулга
* СТОУТХ 7	НББОУС 29 "Хэт инфляци бүхий эдийн засгийн үеийн санхүүгийн тайлагнал"-ын "Дахин гүйцэтгэлийн аргыг ашиглах нь"
* СТОУТХ 8	СТОУС 2-ын үйлчлэх хүрээ
* СТОУТХ 9	Агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийн дахин үнэлгээ
* СТОУТХ 10	Хугацааны дундуурх санхүүгийн тайлагнал ба үнэ цэнийн бууралт

Дээрх дагаж мөрдөж буй шинэ болон нэмэлт өөрчлөлт хийгдсэн стандарт, тайлбарууд нь НББүртгэлийн бодлого, санхүүгийн үр дүн болон банкны байдалд нөлөөлөөгүй болно. Гэсэн хэдий ч СТОУС 7 - Санхүүгийн хэрэглүүрүүд: Тодруулга нь нэмэлт тодруулга болон Тодруулга 31-т үзүүлсэнчлэн харьцуулсан тоон үзүүлэлтүүдийн өөрчлөлтүүдийг шаардсан байна.

Эдгээр санхүүгийн тайлангуудыг батлах өдрийн байдлаар дараах стандарт, нэмэлт өөрчлөлт, тайлбарууд нь батлагдах шатандаа байсан ба хэрэгжиж эхлээгүй байсан болно. Үүнд:

* СТОУС 3 (Шинэчилсэн)	- Бизнесийн нэгдэл
* СТОУС 8	- Үйл ажиллагааны сегмент
* НББОУС 1 (Шинэчилсэн)	- Санхүүгийн тайлангийн толилуулга
* НББОУС 23 (Шинэчилсэн)	- Зээлийн зардал
* НББОУС 27	- Нэгтгэсэн санхүүгийн тайлан ба салангид санхүүгийн тайлан
* СТОУС 2 (Нэмэлт өөрчлөлт)	- Хувьцаанд суурилсан төлбөрүүд - Хэрэгжүүлэх нөхцөл болон цуцлалт
* НББОУС 32 (Нэмэлт өөрчлөлт)	- Санхүүгийн хэрэглүүрүүд: Толилуулга, НББОУС 1: Санхүүгийн тайлангийн толилуулга - Санхүүгийн хэрэглүүрүүд
* СТОУТХ 11	- СТОУС 2 Бүлэг аж ахуйн нэгж ба халаасны хувьцааны ажил гүйлгээнүүд
* СТОУТХ 12	- Үйлчилгээний эрхийн хэлэлцээ
* СТОУТХ 13	- Харилцагчдад чиглэсэн хөтөлбөр
* СТОУТХ 14	- НББОУС 19- Тогтсон дүнтэй тэтгэмжийн хөрөнгө, санхүүжилтийн шаардлагууд, тэдгээрийн хоорондын ажиллагаанд тавигдах хязгаарлалтууд

Банкны захирлууд нь эдгээр стандарт, нэмэлт өөрчлөлт, тайлбаруудыг ирээдүйд дагаж мөрдөхөд банкны санхүүгийн тайланд материаллаг нөлөөлөл үзүүлэхгүй гэсэн таамаглалтай байна.

2.4 ТООЦООЛЛЫН ӨӨРЧЛӨЛТ

Банк тайлант хугацаанд 2007 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжихээр компьютерийн тоног төхөөрөмжийн ашиглах хугацааг 5 жилээс 3 жил болгон өөрчилсөн. Энэ өөрчлөлт нь нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтөд тооцогдсоноор хойших хугацаанд үйлчилж тухайн тайлант жилийн элэгдлийн зардлыг 709,326 сая төгрөгөөр өсгөхөд нөлөөлсөн байна.

2.5 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУДАА МӨРДӨХИЙН ЯВЦАД САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДСӨН ДҮНГҮҮДИЙГ ТОДОРХОЙЛОХДОО ӨӨРИЙН ҮНЭЛЭЛТ БОЛОН ТООЦООЛЛУУДЫГ АШИГЛАСАН. АШИГЛАСАН ХАМГИЙН ТОМООХОН ҮНЭЛЭЛТ БОЛОН ТООЦООЛЛУУДЫГ ДООР ХАРУУЛАВ:

Банк нягтлан бодох бүртгэлийн бодлогуудаа мөрдөхийн явцад санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөгдсөн дүнгүүдийг тодорхойлохдоо өөрийн үнэлэлт болон тооцооллуудыг ашигласан. Ашигласан хамгийн томоохон үнэлэлт болон тооцооллуудыг доор харуулав:

(i) Санхүүгийн хэрэглүүрүүдийн үнэлгээ

Санхүүгийн тайланд бүртгэлтэй байгаа санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн бодит үнийг идэвхтэй зах зээлийн үнээр тодорхойлох боломжгүй үед математик загварчлалуудыг багтаасан үнэлгээний төрөл бүрийн аргыг ашигладаг. Бодит үнэ цэнийг тогтоохын тулд эдгээр загваруудад оруулах өгөгдлийг боломжтой бол ажиглаж болохуйц зах зээлээс авдаг. Хэрэв боломжгүй бол тодорхой хэмжээний үнэлэмжийг удирдлагаас шаарддаг. Энэхүү үнэлэмж нь хүлээн авах орлого, деривативуудийн хоорондын хамаарал (корреляц) болон хэлбэлзэл зэрэг загварт хэрэглэгдэх өгөгдлүүдийг авч үздэг.

(ii) Зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралт

Банк нь үнэ цэнийн бууралтын санг орлого, үр дүнгийн тайланд бүртгэх шаардлагатай эсэхийг үнэлэх үүднээс тайлагналын өдөр бүр асуудалтай зээл, урьдчилгаануудыг хянаж үздэг. Тухайлбал, шаардлагатай сангийн түвшинг тодорхойлох үед ирээдүйн мөнгөн урсгалын дүн, хугацааг ойролцоолон тооцоолоход удирдлагын үнэлэмж шаардагддаг. Ийм тооцоолол нь олон тооны хүчин зүйлүүдийн талаарх таамаглалууд дээр үндэслэдэг ба бодит үр дүнгээс өөр байж болох бөгөөд энэ нь ирээдүйд сангийн хэмжээнд өөрчлөлт оруулахад хүргэж болно.

Дангаараа том дүнтэй зээл ба урьдчилгаанд байгуулсан тусгай сангаас гадна, Банк тусгай сан байгуулах шаардлагатай гэж онцгойлон авч үзээгүй боловч анх олгож байх үеийнхээс зөрчилд өртөх магадлал нь өссөн зээлүүдэд бүлгийн үнэ цэнийн бууралтын санг байгуулдаг. Ингэхдээ тухайн салбарын эрсдэл өссөн эсэх, технологийн хоцрогдолд орсон эсэх, мөн түүнчлэн мөнгөн урсгалд бүтцийн доройтол эсвэл саатал байгаа эсэх зэрэг олон тооны хүчин зүйлүүдийг харгалзан үздэг.

3. ХҮҮ БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГО

	2007	2006
	мян.төг	мян.төг
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	36,563,857	22,477,897
Бусад банк дахь харилцах, хадгаламж, тэдгээрт олгосон зээл	5,808,323	3,962,133
Санхүүгийн хөрөнгө оруулалт - Борлуулахад бэлэн	2,154,334	454,969
Санхүүгийн хөрөнгө оруулалт – Дуусгавар хугацаа хүртэл эзэмших	-	36,933
“Урвуу буцаан худалдан авах гэрээ”	37,313	22,808
	44,563,827	26,954,740

4. ХҮҮ БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ЗАРДАЛ

	2007	2006
	мян.төг	мян.төг
Харилцагчдын харилцах, хадгаламж	28,204,180	17,412,096
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	1,062,395	237,473
Зээл болон хоёрдогч өглөг	953,418	632,961
Буцаан худалдан авах гэрээ	7,773	-
	30,227,766	18,282,530

5. ШИМТГЭЛ ХУРААМЖИЙН ЦЭВЭР ОРЛОГО

	2007	2006
	мян.төг	мян.төг
Шимтгэл хураамжийн орлого		
Дансны үйлчилгээний шимтгэл, хураамж	1,602,751	984,244
Карттай холбоотой шимтгэл, хураамж	1,410,870	1,312,204
Зээлтэй холбоотой шимтгэл, хураамж	1,277,383	783,867
Гуйвуулгын шимтгэл	2,154,502	1,325,346
	6,445,506	4,405,661
Шимтгэл хураамжийн зардал		
Банкаар үйлчлүүлсний зардал	(689,765)	(559,237)
Мастер картын гүйлгээний зардал	(101,483)	(100,525)
Виза картын гүйлгээний зардал	(373,030)	(299,952)
Бусад карттай холбоотой зардал	(74,517)	(55,423)
	(1,238,795)	(1,015,137)
Шимтгэл хураамжийн цэвэр орлого	5,206,711	3,390,524

6. БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО

	2007	2006
	мян.төг	мян.төг
Валютын ханшийн бодит олз	2,062,179	683,533
Валютын ханшийн бодит бус гарз	(92,709)	(446,866)
Санхүүгийн хөрөнгө оруулалт борлуулсны олз – Дуусгавар хугацаа хүртэл эзэмших	-	22,430
Бусад үйл ажиллагааны орлого	54,527	48,515
	2,023,997	307,612

7. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

	2007	2006
	мян.төг	мян.төг
Зар сурталчилгаа	457,969	275,517
Харилцаа холбоо	422,177	380,718
Үндсэн хөрөнгийн элэгдэл (Тодруулга 15)	1,621,590	636,292
Биет бус хөрөнгийн хорогдуулалт (Тодруулга 16)	257,924	89,020
Зочин төлөөлөгчийн зардал	34,466	21,059
Цалин, холбогдох зардлууд*	2,598,998	1,787,838
Байрны түрээс	1,406,606	1,105,036
Харуул хамгаалалтын зардал	901,429	515,362
Бичиг хэргийн зардал	342,411	263,081
Томилолтын зардал	418,153	256,148
Үндсэн хөрөнгө борлуулсны гарз/(олз)	-	1,320
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз (Тодруулга 15)	33,395	4,096
Үйл ажиллагааны бусад зардал	1,583,194	843,923
	10,078,312	6,179,410

	2007	2006
	мян.төг	мян.төг
* Цалин, холбогдох зардлууд		
Цалин, шагнал, урамшуулал	2,018,645	1,410,357
Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл	339,774	271,250
Сургалт	228,939	94,533
Тэтгэмж	11,640	11,698
	2,598,998	1,787,838

8. ЗЭЭЛИЙН ҮНЭ ЦЭНЭ БУУРАЛТЫН ЗАРДАЛ

	2007	2006
	мян.төг	мян.төг
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа		
Бизнесийн зээл	1,746,611	2,442,155
Бизнесийн жижиг зээл	(9,573)	197,939
Хэрэглээний зээл	518,105	(5,805)
Орон сууцны зээл	(9,475)	5,884
Бусад зээл	6,453	(77,344)
	2,252,121	2,562,829
Бусад авлага	47,158	-
	2,299,279	2,562,829

9. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРДАЛ

	2007	2006
	мян.төг	мян.төг
Тайлант жилийн үр дүнд ногдох:		
орлогын татвар	1,811,455	1,108,565

Банк нь санхүүгийн тайлант орлогын дүнг орлогын татварын хуульд заасан чөлөөлөгдөх эсвэл үл чөлөөлөгдөх зүйлүүдээр залруулсан дүнг үндэслэн орлогын татварын зардлыг тооцдог. Банк 3 тэрбум (2006 онд 100 сая) төгрөг хүртэл ашгаас 10% (2006 онд 15%)-ийн, 3 тэрбумаас (2006 онд 100 сая) дээш төгрөгийн ашгаас 25% (2006 онд 30%)-ийн орлогын албан татвар төлдөг. Засгийн газрын бондын хүүгийн орлогод татвар тооцохгүй. Зээлийн үнэ цэнийн бууралтын алдагдлаас хамгаалах сан нь татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцогдоно.

Татварын өмнөх ашгаас хуулиар тогтоосон хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардлыг Банкинд хүчин төгөлдөр үйлчлэх орлогын татварын хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардалд хэрхэн тохируулсныг дараах байдлаар үзүүлэв. Үүнд:

	2007	2006
	мян.төг	мян.төг
Татварын өмнөх ашиг	9,189,178	3,628,107
25 %-ийн орлогын албан татвар (2006 онд: 30%)	2,297,295	1,088,432
Татвараас чөлөөлөгддөг орлого	(60,106)	(7,365)
Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардал	24,266	42,498
Бага хувийн татвар ногдох орлогын нөлөө	(450,000)	(15,000)
Тайлант жилийн татварын зардал	1,811,455	1,108,565

9. ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Түр зөрүү гараагүй тул өмнөх болон тайлант санхүүгийн жилүүдэд хойшлогдсон татварыг тусгаагүй болно.

Банкны удирлага нь Банкны үйл ажиллагаанд хамаарах бүх татварын хуулиудыг мөрдсөн гэж үзэж байна.

10. БЭЛЭН МӨНГӨ, ТӨВ БАНКИН ДАХЬ ХАРИЛЦАХ

	2007	2006
	мян.төг	мян.төг
Бэлэн мөнгө	32,037,098	19,907,641
Монголбанк дахь харилцах	42,491,989	20,222,530
	74,529,087	40,130,171

Монгол банкнаас тавигддаг шаардлагын дагуу Монголбанкинд харилцах данс байршуулдаг. Монгол банкинд байршуулах бэлэн мөнгөний заавал байлгах үлдэгдлийг татан төвлөрүүлсэн хөрөнгийн 14 хоногийн дундаж дээр үндэслэн тогтоосон хувиар бодож гаргадаг. 2007 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монголбанкны тогтоосон заавал байлгах нөөцийн хэмжээ 19,406 сая төгрөг (2006 онд: 11,647 сая төгрөг) байсан.

11. БУСАД БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА ДАХЬ ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ

	2007	2006
	мян.төг	мян.төг
Бусад банк санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	196,095,723	114,084,513
Зээл ба урьдчилгаа	10,011,111	-
	206,106,834	114,084,513

Бусад банк санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламжид дотоод болон гадаад валютаар илэрхийлэгдсэн харилцах данс, гадаад, дотоодын санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламж, дотоодын санхүүгийн байгууллагын богино хугацаат хадгаламжууд орно.

Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан 43.89 сая төгрөгийн (2006 онд 39.24 сая төгрөг) хөрөнгийг Тодруулга 20-д тусгасанчлан банкнаас авсан зээлийн барьцаанд тавьсан болно.

12. ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Доорх мэдээлэлийг үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнийг нэрлэсэн дүнгийн хамт толилуулсан байна. Нэрлэсэн дүн нь (энэ нь нийт дүнгээр бүртгэгдсэн) үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн (ү.с.х.) салшгүй хамааралтай хөрөнгийн дүн байдаг бөгөөд үүсмэл санхүүгийн хэрэглүүрийнх нь бодит үнийг энэхүү хөрөнгөд үндэслэн хэмждэг. Нэрлэсэн дүн нь ажил гүйлгээний жилийн эцсийн үлдэгдлийг харуулдаг ба зах зээлийн болон зээлийн эрсдэлийн алийг нь ч илэрхийлээгүй болно.

	2007	2006
	мян.төг	мян.төг
Хөрөнгө		
- Арилжаалах зорилгоор эзэмшиж байгаа үүсмэл санхүүгийн хэрэглүүр гадаад валютын форвард гэрээнүүд	2,565,117	688,092
Өр төлбөр		
- Арилжаалах зорилгоор эзэмшиж байгаа үүсмэл санхүүгийн хэрэглүүр гадаад валютын форвард гэрээнүүд	2,565,117	688,092
- Өөрийн хөрөнгө ба валютын үүсмэл санхүүгийн хэрэглүүр (Тодруулга 21)	125,206	-
	2,690,323	688,092
Нэрлэсэн дүн		
Арилжаалах зорилгоор эзэмшиж байгаа үүсмэл санхүүгийн хэрэглүүр		
- Гадаад валютын форвард гэрээнүүд	83,121,971	53,361,480
- Өөрийн хөрөнгө ба валютын үүсмэл санхүүгийн хэрэглүүр	11,699,700	-
	94,821,671	53,361,480

2007 оны 12-р сарын 31-ний байдлаар, гадаад валютын форвард гэрээнүүд нь харилцагч нартай хийсэн, талуудын хооронд дуусах хэлцэлүүдтэй холбоотой байсан.

13. САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

	2007	2006
	мян.төг	мян.төг
Борлуулахад бэлэн:		
Бодит үнэ цэнээр бүртгэсэн Монголбанкны үнэт цаас	30,825,708	14,995,837
Бодит үнэ цэнээр бүртгэгдсэн хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй Засгийн газрын бонд	3,924,159	-
Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй өөрийн хөрөнгийн хэрэглүүр	201,000	1,000
	34,950,867	14,996,837

Монголбанкны үнэт цаас нь гурван сар болон түүнээс доош хугацаатай богино хугацааны, хүү тооцдог үнэт цаас байдаг бөгөөд тэдгээрийг бодит үнээс нь хямдруулсан нөхцөлтэйгээр гаргадаг. Засгийн газрын бондыг Сангийн Яамнаас 6 сараас бага хугацаатай, хямдруулсан нөхцөлтэйгээр гаргадаг.

Хөрөнгийн бирж дээр бүртгэлтгүй ба өөрийн хөрөнгөд хийсэн хөрөнгө оруулалт нь Монголын Ипотекийн Корпорацид хийсэн хөрөнгө оруулалт юм. Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй зах зээлийн үнэ нь байхгүй ба үнэлгээний аргачлалуудаар энэхүү хэрэглүүрийн бодит үнийг найдвартайгаар тогтоох боломжгүй тул өртгөөр нь бүртгэсэн болно. Энэ хөрөнгө оруулалтад зах зээл байхгүй ба Банк энэхүү хөрөнгө оруулалтаа урт хугацаагаар эзэмшихээр төлөвлөж байгаа.

14. ХАРИЛЦАГЧДАД ОЛГОСОН ЗЭЭЛ БА УРЬДЧИЛГАА

	2007 мян.төг	2006 мян.төг
Бизнесийн зээл	268,702,207	155,001,672
Бизнесийн жижиг зээл	24,190,933	18,442,555
Хэрэглээний зээл	20,390,181	4,824,451
Орон сууцны зээл	21,810,634	7,335,845
Бусад	580,119	467,417
	335,674,074	186,071,940
Хуримтлагдсан хүүгийн авлага	1,665,765	966,144
Нийт зээл ба урьдчилгаа	337,339,839	187,038,084
Үнэ цэнэ бууралтын сан	(14,313,515)	(12,337,854)
Зээл ба урьдчилгааны цэвэр дүн	323,026,324	174,700,230

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын сан

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын сангийн тохируулгыг зээлийн анги тус бүрээр нь салган үзүүлбэл:

	Бизнесийн зээл мян.төг	Бизнесийн жижиг зээл мян.төг	Хэрэг- лээний зээл мян.төг	Орон сууцны зээл мян.төг	Бусад зээл мян.төг	Нийт зээл мян.төг
2007 оны 12 сарын 31						
2007 оны 1-р сарын 1-нээр	11,382,684	842,623	15,628	62,990	33,930	12,337,855
Нэмэгдсэн	3,191,669	523,212	551,580	181,654	49,032	4,497,147
Төлөгдсөн	(1,445,058)	(532,785)	(33,475)	(191,129)	(42,579)	(2,245,026)
Данснаас хассан	(276,563)	-	-	-	-	(276,563)
Ханшийн зөрүү	76	12	9	4	1	102
2007 оны 12-р сарын 31-нээр	12,852,808	833,062	533,742	53,519	40,384	14,313,515
Тусгай үнэ цэнийн бууралт	6,738,805	84,306	6,044	-	-	6,829,155
Бүлгийн үнэ цэнийн бууралт	6,114,003	748,756	527,698	53,519	40,384	7,484,360
	12,852,808	833,062	533,742	53,519	40,384	14,313,515
Тусгай үнэлгээгээр үнэ цэнийн бууралтанд орсон зээлийг сангаас хасахаас өмнөх зээлийн нийт дүн	13,755,154	255,198	11,497	-	-	14,021,849

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын сан (үргэлжлэл)

2006 оны 12 сарын 31	Бизнесийн зээл мян.төг	Бизнесийн жижиг зээл мян.төг	Хэрэг-лээний зээл мян.төг	Орон сууцны зээл мян.төг	Бусад зээл мян.төг	Нийт зээл мян.төг
2006 оны 1-р сарын 1-нээр	9,743,180	646,066	21,479	57,228	111,513	10,579,466
Нэмэгдсэн	4,863,605	378,205	12,887	12,097	2,302	5,269,096
Төлөгдсөн	(2,421,450)	(180,266)	(18,692)	(6,213)	(79,646)	(2,706,267)
Данснаас хассан	(781,800)	-	-	-	-	(781,800)
Ханшийн зөрүү	(20,851)	(1,383)	(46)	(122)	(239)	(22,641)
2006 оны 12-р сарын 31-нээр	11,382,684	842,622	15,628	62,990	33,930	12,337,854
Тусгай үнэ цэнийн бууралт	10,082,428	228,463	-	-	-	10,310,891
Бүлгийн үнэ цэнийн бууралт	1,300,256	614,159	15,628	62,990	33,930	2,026,963
	11,382,684	842,622	15,628	62,990	33,930	12,337,854
Тусгай үнэлгээгээр үнэ цэнийн бууралтанд орсон зээлийг сангаас хасахаас өмнөх зээлийн нийт дүн	21,494,954	254,378	-	-	-	21,749,332

Банкнаас харилцагчдад олгосон ба тусгай үнэлгээнд хамрагдсан гэж үзэж буй зээлийн барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнэ нь 2007 оны 12 сарын 31-ний байдлаар 16,899 сая төгрөг (2006 онд 25,902 сая төгрөг) байна. Эдгээр үнэлгээг удирдлагаас хамгийн сүүлийн үеийн боломжит мэдээлэлд үндэслэн гаргасан. Дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 28 “ Барьцаа хөрөнгө ба зээлийн бусад сайжруулалтууд” хэсгээс үзнэ үү.

15. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

2007 оны 12 сарын 31	Барилга байшин мян.төг	Түрээсийн байрны засвар мян.төг	Тавилга, эд хогшил тээврийн хэрэгсэл мян.төг	Дүн мян.төг
Өртгөөр				
2007 оны 1-р сарын 1-нээр	1,261,351	30,538	4,429,052	5,720,941
Нэмэгдсэн	169,397	-	2,734,400	2,903,797
Данснаас хассан	-	-	(328,762)	(328,762)
2007 оны 12-р сарын 31-нээр	1,430,748	30,538	6,834,690	8,295,976
Хуримтлагдсан элэгдэл				
2007 оны 1-р сарын 1-нээр	236,933	22,054	1,991,855	2,250,842
Тайлант жилд байгуулсан (Тодруулга 7)	65,521	3,054	1,553,015	1,621,590
Данснаас хассан	-	-	(295,367)	(295,367)
2007 оны 12-р сарын 31	302,454	25,108	3,249,503	3,577,065
Дансны үнэ (цэвэр)	1,128,294	5,430	3,585,187	4,718,911

15. ҮНДСЭН ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

2006 оны 12 сарын 31	Барилга байшин мян.төг	Түрээсийн байрны засвар мян.төг	Тавилга, эд хогшил тээврийн хэрэгсэл мян.төг	Дүн мян.төг
Өртгөөр				
2006 оны 1-р сарын 1-нээр	1,238,443	30,538	3,534,774	4,803,755
Нэмэгдсэн	22,908	-	1,026,226	1,049,134
Худалдан борлуулсан	-	-	(50,414)	(50,414)
Данснаас хассан	-	-	(81,534)	(81,534)
2006 оны 12-р сарын 31-нээр	1,261,351	30,538	4,429,052	5,720,941
Хуримтлагдсан элэгдэл				
2006 оны 1-р сарын 1-нээр	173,804	19,001	1,533,473	1,726,278
Тайлант жилд байгуулсан (Тодруулга 7)	63,129	3,053	570,110	636,292
Худалдан борлуулсан	-	-	(34,290)	(34,290)
Данснаас хассан (Тодруулга 7)	-	-	(77,438)	(77,438)
2006 оны 12-р сарын 31	236,933	22,054	1,991,855	2,250,842
Дансны цэвэр үнэ	1,024,418	8,484	2,437,197	3,470,099

16. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

	Програм хангамж, лиценз	
	2007 мян.төг	2006 мян.төг
Өртгөөр		
1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар	549,493	276,319
Нэмэгдсэн	1,891,585	273,174
12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар	2,441,078	549,493
Хуримтлагдсан хорогдуулга		
1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар	245,002	155,982
Тайлант жилд байгуулсан (Тодруулга 7)	257,924	89,020
12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар	502,926	245,002
Дансны цэвэр үнэ	1,938,152	304,491

17. БУСАД ХӨРӨНГӨ

	2007	2006
	мян.төг	мян.төг
Бусад авлага	1,311,913	1,412,767
Хасах нь: Үнэ цэнийн бууралтын сан	(47,158)	-
	1,264,755	1,412,767
Урьдчилж төлсөн зардал	2,531,331	3,065,234
Хангамжийн бусад бараа материал	419,529	309,030
	4,215,615	4,787,031
Бусад авлагын үнэ цэнийн бууралтын сан		
2007 оны 1-р сарын 1-нээр	-	-
Тайлант жилд байгуулсан	47,158	-
2007 оны 12-р сарын 31-нээр	47,158	-

18. БУСАД БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ

	2007	2006
	мян.төг	мян.төг
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	36,819,404	20,237,532

Банк санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламжид дотоодын болон гадаадын банкнуудаас байршуулсан гадаад валют болон төгрөгийн харилцах болон хугацаатай хадгаламжууд орно.

19. ХАРИЛЦАГЧДЫН ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ

	2007	2006
	мян.төг	мян.төг
Төсвийн байгууллагын харилцах, хадгаламж		
- Харилцах данс	37,586,720	6,557,016
- Хугацаагүй хадгаламж	2,969	15,008,170
- Хугацаатай хадгаламж	10,008,767	864,007
Хувийн секторын харилцах, хадгаламж		
- Харилцах данс	83,881,027	35,942,765
- Хугацаагүй хадгаламж	2,337,897	2,741,539
- Хугацаатай хадгаламж	13,057,676	2,435,536
Иргэдийн харилцах, хадгаламж		
- Харилцах данс	35,670,712	20,871,296
- Хугацаагүй хадгаламж	125,168,340	72,090,654
- Хугацаатай хадгаламж	188,370,831	119,352,979
Бусад харилцах, хадгаламж		
- Харилцах данс	11,632,095	5,770,593
- Хугацаагүй хадгаламж	2,299,520	463,529
- Хугацаатай хадгаламж	2,468,593	1,608,684
	512,485,147	283,706,768

20. ЗЭЭЛЭЭР АВСАН ЭХ ҮҮСВЭР

	2007 мян.төг	2006 мян.төг
Барьцаатай:		
Ландесбанк Берлин	519,681	479,931
Барьцаагүй:		
Дэлхийн Банкны Зээл I	1,037,860	1,141,952
Дэлхийн Банкны Зээл II	-	778,878
Дэлхийн Банкны Зээл III	307,857	336,615
Азийн Хөгжлийн Банк	5,094,950	3,161,114
Монголбанк	1,122,113	978,421
Монгол Улсын Засгийн Газар	13,828,984	-
	21,391,764	6,396,980
Нийт	21,911,445	6,876,911

Ландесбанк Берлин

Ландесбанк Берлин зээлийг Герман улсад барилга худалдаж авахад ашигласан. Зээлийн хүүгийн хувь хэмжээ нь жилийн 7.45% - 8.87% (2006 онд 7.45%-8,87%) байсан. Банк нь 1996 оны 6 дугаар сараас эхлэн зээлийн эргэн төлөлтийг улирал бүр хийж эхэлсэн ба эцсийн төлбөр хийх хугацаа нь 2025 оны 9 дүгээр сар. Тодруулга 11-т заасны дагуу зээлийн барьцаанд бусад банк санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламжийг тавьсан байна.

Дэлхийн банкны зээл I

Дэлхийн Банкны энэ зээлийг “Хувийн хэвшлийг хөгжүүлэх зээлийн хөтөлбөр”-ийн хүрээнд төрөл бүрийн зээлдэгчдэд олгодог. Дэлхийн Банкны зээлийн хүүгийн хувь хэмжээ нь жилийн 8,33%-8,39% (2006 онд 7,63%-8,42%) байсан. Зээлийн эргэн төлөлт нь төрөл бүрийн эргэн төлөлтийн хуваариудын дагуу хийгддэг ба эцсийн төлбөр хийх хугацаа нь 2010 оны 3 дугаар сар.

Дэлхийн банкны зээл II

Дэлхийн Банкны энэ зээлийг “Хувийн хэвшлийг хөгжүүлэх зээлийн хөтөлбөр”-ийн хүрээнд төрөл бүрийн зээлдэгчдэд олгодог. Дэлхийн Банкны зээлийн хүүгийн хувь хэмжээ нь жилийн 6,58% - 11,50% (2006 онд 7,46%-9,81%) байсан. Зээлийн эргэн төлөлт нь төрөл бүрийн эргэн төлөлтийн хуваариудын дагуу хийгддэг ба эцсийн төлбөр хийх хугацаа нь 2009 оны 6 дугаар сар.

Дэлхийн банкны зээл III

Энэ зээл нь банкны ажилчдын сургалтанд зориулагдсан ба жилийн 2%-ийн тогтмол хүүтэй (2006 онд 2% байсан). Эргэн төлөлтийн хуваарийн дагуу үндсэн төлбөрийг 2004 оны 11 дүгээр сараас эхлэн хагас жил тутамд төлөх ба эцсийн төлбөр хийх хугацаа нь 2019 оны 5 дугаар сар.

Азийн Хөгжлийн Банк

Энэ зээлийг орон сууцны зээл хүсэгчдэд олгосон. Зээлийн хүүгийн хувь хэмжээ нь жилийн 7.64%-8.04% (2006 онд 8.13%-8.29%) байсан. Зээлийн эргэн төлөлтийн хугацаа төрөл бүрийн эргэн төлөлтийн хуваариудын дагуу байна.

Монголбанк

2001 оны 5 дугаар сараас эхлэн төгрөгийн зээлийг Монголбанкнаас авч ажиллаж байна. Энэхүү зээл нь Монгол Улсад ажлын байр нэмэгдүүлэх, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилготой. Зээлийн хүү нь жилийн 10% (2006 онд:10%) ба зээлийг бүрэн эргүүлэн төлөх хугацаа нь 2009 оны 12 дугаар сар.

Монгол Улсын Засгийн Газар

Банк 2007 онд Сангийн яамнаас хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн зээл авсан. Зээлийн жилийн хүү нь 5.48%. Зээлийн хүүг 2008 оны 7 дугаар сараас эхлэн сар бүр төлж эхлэх ба зээлийг бүрэн эргүүлэн төлөх хугацаа нь 2009 он.

Банк суурьшлын бүс нутагт барилга орон сууц байгуулах санхүүжилтийг бий болгох зорилгоор Сангийн яамнаас 40.000 айлын орон сууц хөтөлбөрийн зээлийг авсан. Зээлийн жилийн хүү нь 7.00 %, хагас жилээр төлөх нөхцөлтэй ба зээлийг бүрэн эргүүлэн төлөх хугацаа нь 2017 он.

Тайлант хугацаанд Банк нь өөрийн хүлээсэн үүргийн дагуу үндсэн зээл болон хүүгийн төлбөрийг цаг хугацаанд нь гүйцэтгэж байсан ба аливаа нэг зөрчил гаргаагүй болно.

21. ХОЁРДОГЧ ӨГЛӨГ

	2007 МЯН.ТӨГ	2006 МЯН.ТӨГ
Кредит Свисс-ээс авсан хоёрдогч өглөгийн хөрвөх зээл	11,360,015	-
Монгол Шуудан банкнаас авсан хоёрдогч өглөгийн зээл	4,500,000	4,500,000
	15,860,015	4,500,000

Кредит Свисс-ээс авсан хоёрдогч өглөгийн хөрвөх зээл

2007 оны 12 дугаар сарын 21-ний өдөр Голомт Банк Кредит Свисс-ийн Сингапурын салбараас 5 жилийн хугацаатай, 10 сая ам. долларын хоёрдогч өглөгийн хөрвөх зээлийг авсан. Энэхүү хоёрдогч өглөгийн хөрвөх зээлийг дараахи нөхцөлтэй авсан байна. Үүнд:

- Хөрвөх сонголт – Кредит Свисс банк нь хөрвөх бололцоот хугацааны дотор хоёрдогч өглөгийн хөрвөх зээлийг банкны нэг бүр нь 1000 төгрөгний нэрлэсэн өртөгтэй ердийн хувьцаанд шинээр хөрвүүлэх сонголт хийх эрхтэй.
- Хөрвөх хувьцааны тоо-Үндсэн зээлийн үлдэгдэл дүн/худалдах үнэ
- Нэгж хувьцааны үнэ – 2007 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар аудитлагдсан цэвэр өөрийн хөрөнгөөс хөрвүүлэх үед хуваарилагдсан ногдол ашигийг хассан дүнг тохирсон хувиар өсгөж гарсан үнэ болон хөрвүүлэх үед хувьцаат компани болох үеийн анхны борлогдсон үнээс хуваарилагдсан ашигийг хассан үнийн аль хямд нь
- Хөрвүүлэлтийн хугацаа- 2007.12.21-ээс эхлээд 5 жил 7 хоног
- Хөрвөх зээлийн хүү нь 3 сарын ЛИБОР дээр нэмэх нь 2.5 хувь байх бөгөөд улирал тутам төлөгдөнө
- Таван жилийн дотор банк хувьцаат компани болж чадаагүй бол эсвэл хувьцаат компани болсон ч Кредит Свисс банк зээлийг хувьцаа болгон хөрвүүлэх эрхээ эдлэхгүй бол Кредит Свисс банк зээлийн үндсэн өрийг бүтэн төлүүлэх, хувьцаат компани болж чадаагүй бол Өөрийн Дотоод Өгөөжийг нь 20 хувиар тооцсон нэмэлт хүү тооцох бөгөөд урд төлсөн хүүг хасан зээл авсан өдрөөс тооцон авна.

21. ХОЁРДОГЧ ӨГЛӨГ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Кредит Свисс-ээс авсан хоёрдогч өглөгийн хөрвөх зээл (үргэлжлэл)

(ё) Зээлийн хэмжээг нэмэх бололцоо – Тодорхой нөхцөл биелсэн нөхцөлд 2008 оны эцэс хүртэл ижил нөхцлөөр хоёрдогч өглөгийн хөрвөх зээлийн үндсэн дүнг 20 сая ам доллар болгох боломж байгаа.

(ж) Банкны хувьцаа эзэмшигч нь хоёрдогч өглөгийн хөрвөх зээлд баталгаа гаргаж гэрээгээр үүрэг хүлээсэн байна.

Нийт хөрвөх чадвартай, хоёрдогч өглөгийн зээллэгээс хүлээн авсан мөнгийг (гүйлгээний зардлыг хассан цэвэр дүн) өр төлбөр ба агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэглүүр гэсэн хоёр бүрэлдэхүүнээр нь салгасан. Агуулагдсан өөрийн хөрөнгө болон гадаад валютын үүсмэл санхүүгийн хэрэглүүрийг Банкны таамаглал болон зах зээлийн үнэ дээр суурилсан стандарт опционы үнэлгээний загварыг ашиглаж үнэлсэн. Агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийн үнийг авч үзсэний дараах үлдэх үнийг өр төлбөрт ногдуулсан болно.

	Өр төлбөрийн бүрэлдэхүүн мян.төг	Агуулагдсан ү.с.х. бүрэлдэхүүн (Тодруулга 12) мян.төг	Нийт мян.төг
Зээл авсан өдрийн байдлаарх орлого	11,335,933	125,206	11,461,139
Тайлант жилийн хугацаанд төлсөн үр ашигт хүү	24,082	-	24,082
12 сарын 31-нээр	11,360,015	125,206	11,485,221

2007 оны 12 сарын 31-ний өдрөөрх өөрийн хөрөнгө болон гадаад валютын үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнийг стандарт опционы үнэлгээний загвараар тодорхойлсон.

Монгол Шуудан Банк ХХК-аас авсан хоёрдогч өглөг

Хоёрдогч өглөгийг ажлын капиталын зорилгоор авсан. Зээлийн хүүгийн хувь хэмжээ нь жилийн 13% (2006 онд: 13%) байна. Зээлийн төлбөрийг бүхлээр нь хийх ба төлбөр хийх хугацаа нь 2011 оны 12 дугаар сар юм.

Тайлант хугацаанд Банк нь өөрийн хүлээсэн үүргийн дагуу хоёрдогч өглөгийн үндсэн зээл болон хүүгийн төлбөрийг цаг хугацаанд нь гүйцэтгэж байсан ба аливаа нэг зөрчил гаргаагүй болно.

22. БУСАД ӨР ТӨЛБӨР

	2007 мян.төг	2006 мян.төг
Өглөг	6,926,288	3,887,829
Гадаад гуйвуулга	608,278	220,137
Клирингийн саатал	15,901,803	1,319,758
	23,436,369	5,427,724

23. ДҮРМИЙН САН

	Хувьцааны тоо		Дүн	
	2007	2006	2007 мян.төг	2006 мян.төг
1 дүгээр сарын 1-нээр	-	-	21,934,142	13,434,142
Тайлант жилд нэмэгдсэн	-	-	-	8,500,000
Нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнээр хөрвүүлсэн энгийн хувьцаа	21,934,142	-	-	-
12 дугаар сарын 31-нээр	21,934,142	-	21,934,142	21,934,142

Банк 2007 оны 12 дугаар сарын 14-ний өдөр дүрмийн сангаа нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 21,934,142 энгийн хувьцаанд хөрвүүлсэн.

24. МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

	Тодруулга	2007	2006
		мян.төг	мян.төг
Бэлэн мөнгө, Монголбанк дахь хөрөнгө	10	74,529,087	40,130,171
Бусад банк санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	11	206,106,834	114,084,513
		280,635,921	154,214,684

25. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮРИЙН БОДИТ ҮНЭ ЦЭНЭ

Санхүүгийн тайланд тусгагдсан санхүүгийн хэрэглүүрүүдийн дансны үнэ болон бодит үнүүдийг анги тус бүрээр нь доор харуулав. Энэхүү хүснэгт нь санхүүгийн бус хөрөнгө ба өр төлбөрийн бодит үнийг багтаагаагүй болно.

Тодруулга	Дансны үнэ		Бодит үнэ		Хүлээн зөвшөөрөгүй олз/гарз		Хүлээн зөвшөөрөгүй олз/гарз	
	2007	мян.төг	2007	мян.төг	2007	мян.төг	2006	мян.төг
Санхүүгийн хөрөнгө								
Бэлэн мөнгө, төв банк дахь харилцах	10	74,529,087	74,529,087	-	40,130,171	40,130,171	-	-
Бусад банк санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	11	206,106,834	206,106,834	-	114,084,513	114,084,513	-	-
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	12	2,565,117	2,565,117	-	688,092	688,092	-	-
Санхүүгийн хөрөнгө оруулалт-Борлуулахад бэлэн								
Монголбанкны үнэт цаас	13	30,825,708	30,825,708	-	14,995,837	14,995,837	-	-
Застгийн газрын бонд	13	3,924,159	3,924,159	-	-	-	-	-
Хөрөнгийн бирж дээр арилжигдаагүй хувьцаа	13	201,000	201,000	*	1,000	1,000	-	-
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	14	323,026,324	325,176,237	2,149,913	174,700,230	170,142,646	(4,557,584)	-
Бусад актив	17	1,264,755	1,264,755	-	1,412,767	1,412,767	-	-
Санхүүгийн өр төлбөр								
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	18	36,819,404	36,819,404	-	20,237,532	20,237,532	-	-
Харилцагчдын харилцах, хадгаламж	19	512,485,147	512,485,147	-	283,706,768	283,706,768	-	-
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	12	2,690,323	2,690,323	-	688,092	688,092	-	-
Зээлээр авсан санхүүжилт	20	21,911,445	22,529,391	(617,946)	6,876,911	7,198,780	(321,869)	-
Хоёрдогч өглөг	21	15,860,015	15,860,015	-	4,500,000	4,500,000	-	-
Бусад өглөг	22	23,436,369	23,436,369	-	5,427,724	5,427,724	-	-
Нийт бодит бус бодит үнийн өөрчлөлт					1,531,967			
					(4,879,453)			

* Тодруулга 13-т дурьдсанчлан, хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй өөрийн хөрөнгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг үнэлгээний аргачлалуудаар найдвартайгаар тогтоох боломжгүй юм

25. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮРИЙН БОДИТ ҮНЭ ЦЭНЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дараах аргачлал, таамаглалыг ашиглан санхүүгийн тайланд бодит үнэ цэнээр бүртгэгдээгүй санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнийг тодорхойлсон.

Бодит үнэ цэнэ нь дансны үнэтэйгээ ойролцоо хөрөнгө

Бэлэн мөнгөнд хөрвөх чадвартай болон богино хугацааны (1 жилээс доош) санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн хувьд тэдгээрийн бодит үнэ нь дансны үнэтэй ойролцоо байдаг гэж таамагладаг. Энэ таамаглал нь мөн хугацаагүй хадгаламж, хугацаатай хадгаламж болон хувьсах хүүтэй санхүүгийн хэрэглүүрд ашиглагдсан.

Тогтмол хүүтэй санхүүгийн хэрэглүүр

Хорогдуулсан өртгөөр илэрхийлэгдсэн тогтмол хүүтэй санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн бодит үнэ цэнэ нь ижил төстэй санхүүгийн хэрэглүүрүүдийн одоогийн зах зээл хүү болон тэдгээр санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг хүлээн зөвшөөрсөн үеийн зах зээлийн хүүгийн харьцуулалтаар тооцоологдоно. Тогтмол хүү төлдөг хадгаламжийн бодит үнэ цэнэ нь адилхан зээлийн эрсдэл болон хугацаатай зээлүүдийн мөнгөний зах зээлийн хүүгээр дискаунтлагдсан бэлэн мөнгөний урсгал дээр суурилна. Хөрөнгийн бирж дээр арилжаалагддаг өрийн хувьд бодит үнэ цэнэ нь зах зээлийн үнэ дээр үндэслэн тооцогдоно. Хөрөнгийн биржд зах зээлийн үнэ нь байхгүй өрийн бодит үнийг тодорхойлохдоо одоо зах зээл дээр байгаа хүүнүүдийн хугацаагаарх бүтцийн муруйд үндэслэн харгалзах эргэн төлөгдөх хугацаагаар нь дискаунтчилсан мөнгөн урсгалын загварчлалыг ашигласан.

Үүсмэл санхүүгийн хэрэглүүр

Гадаад валютын ханшны форвард гэрээнүүдийн бодит үнэ цэнэ нь ижил төстэй хугацаануудтай гадаад валютын ханшны форвард гэрээнүүдийн одоогийн үнүүдэд суурилж тооцоологддог. Өөрийн хөрөнгө болон ханшны үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн үнэлгээнд суурь опционы үнэлгээний загварыг ашигласан ба чингэхдээ гадаад валютын ханшны хэлбэлзэл, спот ханшны тооцоолсон үнэлгээ болон хугацааны нөхцлийг авч үздэг.

26. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР БА ҮҮРЭГ

Харилцагчийн санхүүгийн хэрэгцээг хангахын тулд банк олон төрлийн цуцлашгүй үүргийг хүлээснээс болзошгүй өр төлбөр үүсдэг байна. Хэдийгээр эдгээр үүргүүд нь тайлан тэнцэлд хүлээн зөвшөөрөгдөөгүй ч зээлийн эрсдэлийг агуулсан байдаг учраас Банкны нийт эрсдэлийн нэг хэсэг байдаг юм.

	2007 мян.төг	2006 мян.төг
Болзошгүй өр төлбөр		
Санхүүгийн баталгаа	5,884,268	1,714,935
Аккредитив	18,552,240	4,167,342
Бусад	7,612,223	1,505,877
	32,048,731	7,388,154
Үүрэг		
Олгогдоогүй зээл	9,156,733	738,007
Нийт	41,205,464	8,126,161

26. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР БА ҮҮРЭГ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Болзошгүй өр төлбөр

Аккредитив, баталгаа (нээлттэй аккредитив хамаарагдана) нь тусгай үйл явдал тохиолдоход харилцагчийн өмнөөс голдуу бараа бүтээгдэхүүний импорт болон экспорттой холбоотойгоор төлбөр хийх үүргийг Банкинд ногдуулдаг байна. Баталгаа, нээлттэй аккредитив нь зээлийн эрсдэлтэй ижил эрсдэлийг агуулдаг.

Зээл олгох үүрэг хүлээсэн ч тус эрх нь хэрэгжээгүй

Зээлийн хэмжээг нэмэхээр шийдвэрлэсэн нь Банкны зүгээс зээл олгох, эргэн төлөлтийн график нь тогтмол бус хэмээх төрлийн зээл олгох гэрээт үүргүүдийг хүлээснийг илэрхийлдэг. Ихэнхдээ ийм үүргүүдийн тогтсон дуусах хугацаа эсвэл хүчин төгөлдөр байх хугацааг заасан нөхцлүүд нь тодорхой байдаг. Зээл олгох үүрэг нь хэрэгжээгүй байтал тус үүргийнх нь хугацаа нь дууссан байж болох тул гэрээнд заасан дүн нь ирээдүйн мөнгөний шаардлагыг илэрхийлдэг гэсэн ойлголт биш юм.

Зээлийн хэмжээг нэмэх шийдвэрүүд нь харилцагчийн тодорхой шалгууруудыг хангах явдлаас шууд шалтгаалдаг учраас зээлийн боломжит үнэ цэнийн бууралтын алдагдал нь нийт хэрэгжээгүй үлдсэн зээл олгох үүргүүдийн дүнгээс бага байна. Богино хугацаат зээлийн үүргээс голдуу урт хугацаат зээлийн үүрэг нь илүүтэйгээр зээлийн эрсдэлтэй байдаг тул банк нь зээлийн үүргүүдийнхээ дуусах хугацааг хянаж байдаг.

Бусад үүрэг

	2007 мян.төг	2006 мян.төг
Батлагдсан, гэрээ байгуулсан:		
Үндсэн хөрөнгө	-	317,751

Үйл ажиллагааны түрээсийн үүрэг- Түрээслэгч нь банк

Банк нь цуцлах боломжтой, үйл ажиллагааны түрээсийн гэрээний дагуу түрээслэгч болж төрөл бүрийн барилгыг үйл ажиллагаа явуулах зорилгоор түрээслэдэг. Банк эдгээр гэрээнүүдийн хугацааг дуусгавар болгох тохиолдолд мэдэгдлээ нэг сарын өмнө өгөх үүрэгтэй. Түрээсийн гэрээнд аливаа шинэчлэх, худалдан авах, сайжруулах боломжуудыг тусгаагүй ба Банкинд эдгээр түрээсийн гэрээнд тал болсноор аливаа хязгаарлалтууд тавигдаагүй болно.

27. ХӨРӨНГӨ БОЛОН ӨР ТӨЛБӨРИЙН ХУГАЦААНЫ ШИНЖИЛГЭЭ

Дараах хүснэгтэнд Банкны актив, пассивын Эргэн төлөгдөх, барагдах хугацаагаар нь харуулсан шинжилгээг харуулсан байна. Тодруулга 28.3 “Төлбөрийн чадварын эрсдэл ба эх үүсвэрийн удирдлага”-аас Банкны зүгээс барагдуулах үүргүүдийн дискаунтчилаагүй .хувилбарыг харна уу

	12 хүртэлх сар мян. төг	12 сараас дээш мян. төг	Нийт мян. төг
2007 оны 12 сарын 31			
Санхүүгийн хөрөнгө			
Бэлэн мөнгө, Монголбанк дахь хөрөнгө	74,529,087	-	74,529,087
Бусад банк санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	191,244,352	14,862,482	206,106,834
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	2,565,117	-	2,565,117
Санхүүгийн хөрөнгө оруулалт - -борлуулахад бэлэн	34,950,867	-	34,950,867
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	210,328,287	112,698,037	323,026,324
Бусад авлага	1,264,755	-	1,264,755
	514,882,465	127,560,519	642,442,984
Санхүүгийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	-	4,718,911	4,718,911
Биет бус хөрөнгө	-	1,938,152	1,938,152
Бусад актив	2,090,312	860,548	2,950,860
	2,090,312	7,517,611	9,607,923
Нийт	516,972,777	135,078,130	652,050,907
Санхүүгийн өр төлбөр			
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	36,819,404	-	36,819,404
Харилцагчдын харилцах, хадгаламж	511,261,123	1,224,024	512,485,147
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	2,565,117	125,206	2,690,323
Зээлээр авсан санхүүжилт	9,181,043	12,730,402	21,911,445
Хоёрдогч өглөг	-	15,860,015	15,860,015
Бусад пассив	23,436,369	-	23,436,369
	583,263,056	29,939,647	613,202,703
Санхүүгийн бус өр төлбөр			
Татварын өр	176,415	-	176,415
Нийт	583,439,471	29,939,647	613,379,118
Цэвэр	(66,466,693)	105,138,483	38,671,789

27. ХӨРӨНГӨ БОЛОН ӨР ТӨЛБӨРИЙН ХУГАЦААНЫ ШИНЖИЛГЭЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

	12 хүртэлх сар мян. төг	12 сараас дээш мян. төг	Нийт мян. төг
2006 оны 12 сарын 31			
Санхүүгийн хөрөнгө			
Бэлэн мөнгө, Монголбанк дахь хөрөнгө	40,130,171	-	40,130,171
Бусад банк санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	109,545,265	4,539,248	114,084,513
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	688,092	-	688,092
Санхүүгийн хөрөнгө оруулалт - борлуулахад бэлэн	14,995,837	1,000	14,996,837
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	131,231,907	43,468,323	174,700,230
Бусад авлага	1,412,767		1,412,767
	298,004,039	48,008,571	346,012,610
Санхүүгийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	-	3,470,099	3,470,099
Биет бус хөрөнгө	5,307	299,184	304,491
Бусад актив	3,374,264	-	3,374,264
	3,379,571	3,769,283	7,148,854
Нийт	301,383,610	51,777,854	353,161,464
Санхүүгийн өр төлбөр			
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	20,237,532	-	20,237,532
Харилцагчдын харилцах, хадгаламж	283,638,184	68,584	283,706,768
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	688,092	-	688,092
Зээлээр авсан санхүүжилт	2,125,589	4,751,322	6,876,911
Хоёрдогч өглөг	-	4,500,000	4,500,000
Бусад пассив	5,427,724	-	5,427,724
	312,117,121	9,319,906	321,437,027
Санхүүгийн бус өр төлбөр			
Татварын өр	430,371	-	430,371
Нийт	312,547,492	9,319,906	321,867,398
Цэвэр	(11,163,882)	42,457,948	31,294,066

28. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА
28.1 Оршил

Голомт банкны эрсдэлийн удирдлагын газар нь Гүйцэтгэх Захиралд шууд тайлагнадаг бие даасан нэгж бөгөөд банкны үйл ажиллагааны үндсэн уламжлалт эрсдэл болох зээлийн эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл, хүүгийн эрсдэл, ханшийн эрсдэл, гадаад валютын арилжааны эрсдэл, үйл ажиллагааны эрсдэлийг хянан зохицуулдаг. Эрсдэлийн удирдлагын гол зорилго нь бизнесийн сегментүүдэд тэдгээрийн уламжлалт эрсдэл/шагналын дүрслэлд зохицсон капиталыг хуваарилах ба эрсдэлийн лимит болон бусад хяналтанд байдаг эрсдэлээр тохируулагдсан капиталын өгөөжийг байнгын илрүүлэлт, хэмжилт ба хянан зохицуулалтын процессоор хамгийн их байлгахад оршдог. Тус эрсдэлийн удирдлагын процесс нь Банкны урт хугацааны ашигт ажиллагаанд чухал ач холбогдолтой бөгөөд ажилтан,

хувь хүн бүр өөрийн ажил үүрэгтэй холбоотой эрсдэлийн өртөлтийг мөн хариуцдаг. Эрсдэлийн хяналтын бие даасан процесс нь байгаль орчин, технологи, салбарын өөрчлөлт зэрэг бизнесийн эрсдэлийг хамардаггүй. Эдгээр нь Банкны стратеги төлөвлөлтөөр хянагдан зохицуулагддаг.

Эрсдэлийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт

ТУЗ нь эрсдэлийг тодорхойлж, хяналтыг хэрэгжүүлэх үндсэн үүрэгтэй. Гэсэн хэдий ч эрсдэлийг удирдаж, хянан зохицуулах чиг үүрэг бүхий бие даасан нэгжүүд байдаг.

Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ)

ТУЗ нь эрсдэлийн удирдлагын үндсэн чиг хандлагыг тодорхойлж, банкны бүх үйл ажиллагааг зорилгод чиглүүлсэн эрсдэлийн стратеги, зарчмуудыг батлах мөн шаардлагатай гэж үзсэн шинэ бодлого журмыг нэвтрүүлдэг. Эрсдэлийн стратеги болон ач холбогдол бүхий бодлогуудыг ТУЗ-аас батлаж, тодорхой давтамжтайгаар (хамгийн багадаа жилд 1 удаа) хянан хэлэлцдэг.

Аудитын хороо

Аудитын хороо нь Дотоод аудитын газрын үйл ажиллагаанд хяналт тавьж, хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, хянах чиг үүрэгтэй ба ТУЗ-д шууд тайлагнана.

Актив, пассивын хороо

Тус хороо нь эрсдэлийн стратеги боловсруулж, хүүний, ханшийн хөрвөх чадварын болон зах зээлийн эрсдэлүүдэд хязгаарлалтууд, зарчим, бүтэц, бодлогыг тодорхойлж хэрэгжүүлнэ.

Зээлийн Хороо

Зээлийн хороо нь ТУЗ-д шууд харъяалагдана. Тус хороо нь ТУЗ-аас олгосон тодорхойлон олгосон эрх хэмжээний хүрээнд зээлийн шийдвэр гаргадаг нэгж юм. Зээлийн хороо нь дараахь үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд :

- i. зээлийн бодлого, журамд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх, батлах.
- ii. зээлийн ангилал болон сан байгуулах түвшин хэмжээг батлах.
- iii. зээлийн багц дах чанар, эрсдэлтэй багцыг тогтмол хянах.
- iv. үйлдвэрлэлийн салбар болон газарзүйн бүсийн байршлын хувьд олгогдох зээлийн хэмжээг тогтоон батлах.

Эрсдэлийн Удирдлагын Газар

Эрсдэлийн удирдлагын газар нь бие даасан хяналтын системийг хэрэгжүүлэх зорилгоор эрсдэлд хамаарал бүхий бодлого журмуудыг мөрдөж, хэрэгжүүлнэ.

Тус газар нь Банкны эрсдэлийн бодлого, журмуудын хэрэгжилтийг хангана. Бизнесийн бүхий л нэгжүүд эрсдэлийг хянан зохицуулах бие даасан албатай байх болсон бөгөөд тогтоосон лимитийн эрсдэл, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний эрсдэл болон зохион байгуулалт бүхий гүйлгээний эрсдэл зэргийг багтааж хянана. Тус алба нь мөн эрсдэлийн тооцооллолт, тайлагналын систем дэх бүхий л эрсдэлийг тодорхойлж, тайлагнах чиг үүрэгтэй байна.

Дотоод Аудитын Газар

Банк дахь эрсдэлийн удирдлагыг Дотоод аудитын газар банкны зохимжтой үйл ажиллагаа болон мөрдлөг болгож буй дүрэм, журмын хэрэгжилтийг шалгах замаар хамгийн багадаа жилд нэг удаа аудит хийнэ. Дотоод аудитын газар нь шалгалтын дүнгийн талаар удирдлагатай ярилцаж, илэрсэн зүйлийг санал зөвлөмжийн хамт удирдлагын хороо болон аудитын хороонд тайлагнана.

28. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

28.1 Оршил (үргэлжлэл)

Эрсдэлийг хэмжих болон тайлагнах систем

Банк тооцоолж болохуйц болон ердийн тохиолдолд тооцож болохооргүй эрсдэл буюу статистик загварт суурилсан эцсийн эрсдэлийг аль алийг нь хэмжих аргыг ашигладаг. Загвар нь өмнөх туршлага, түүхэнд суурилсан боломжийг эдийн засгийн орчинд тохируулна. Мөн Банк тохиолдох магадлал тун багатай боловч тохиолдож болох хамгийн муу төлвүүдийг гаргадаг.

Эрсдэлийг Банкнаас тогтоосон хэмжээ хязгаарын хүрээнд хянаж, удирдана. Тус тодорхойлсон хэмжээ хязгаар нь Банкны бизнес стратеги, зах зээлийн орчинтой болон банкны зүгээс хүлээн зөвшөөрөхүйц эрсдэлийн хэмжээтэй уялдсан байх ба зарим салбарт онцгойлон анхаардаг. Банк нь бүх үйл ажиллагаанд бий эрсдэлүүдийн нийлбэр өртөлттэй холбоотойгоор эрсдэл даах чадварыг хэмжиж хянана.

Бүх бизнесийн нэгжүүдээсээ цуглуулсан мэдээллийг эрсдэлийг эртхэн тодорхойлж, хянах зорилгоор нягтлан шалгаж боловсруулалт хийдэг. Мөн энэ мэдээлэлийг ТУЗ, Актив пассивын хороо, газар бүрийн захирлуудад танилцуулдаг. Тайланд зээлийн нийт өртөлт, зээлийн хэмжээний төлөв, тогтоосон лимитийг давах онцгой тохиолдол, VaR, хөрвөх чадварын харьцаа, ба эрсдэлийн багцын өөрчлөлт зэргийг тусгана. Сар бүр үйлдвэрлэлийн салбар, харилцагчийн эрсдэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тайлагнана. Улирал бүр газар нэгжийн захирлууд зээлийн эрсдэлийн сангийн зохистой байдалд үнэлгээ өгнө. Аудитын хороо нь Банкны нийт эрсдэлийн өртөлтийг тооцож, үнэлж, хянаж болохуйц бүрэн хэмжээний тайлантай улирал бүр танилцаж үнэлгээ хийдэг.

Тусгайлан боловсруулагдсан эрсдэлийн тайланг Банкны бүх нэгжүүдэд хүргэдэг бөгөөд энэ нь бизнесийн нэгжүүдийг шинэ тугам мэдээлэлтэй байлгах зорилготой юм.

Удирдлага болон Актив пассивын хороонд VaR, хөврөх чадварын дүн шинжилгээ, зах зээлийн лимитийн ашиглалт болон бусад аливаа эрсдэл үүсгэх хүчин зүйлийн талаар танилцуулна.

Эрсдэлийг бууруулах

Хүүгийн хувь, гадаад валютын ханшны өөрчлөлт, зээлийн эрсдэл болон ирээдүйн үйл ажиллагаанаас үүдэж болох өртөлтийг мэдрэмжийн шинжилгээ болон VaR-ийг эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд ашигладаг. Банк зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор барьцаа хөрөнгө барьцаалж авдаг.

Эрсдэлийн хэт төвлөрөл

Хэд хэдэн харилцагчид ижил төрлийн бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг эсвэл улс төр эдийн засаг болон бусад аливаа өөрчлөлт гарахад тэдгээрийн гэрээний үүргээ гүйцэтгэхэд ижил маягаар нөлөөлөхөөр байвал төвлөрөл бий болдог. Төвлөрөл нь тухайн нэг салбарт нөлөөлж буй нөхцөл байдалд банк хэрхэн гүйцэтгэлээ хангах мэдрэмжийг илтгэнэ.

Эрсдэлийн хэт төвлөрлөөс зайлсхийхийн тулд Банк нь өөрийн бодлого, журамдаа олон төрлийн багцтай байх тодорхой удирдамжийг тусгасан байдаг. Зээлийн эрсдэлийн тодорхойлогдсон төвлөрлийг хянаж удирдана. Монголбанк /Төв банк/ дараах стандарт хязгаарлалтуудыг биелүүлэхийг шаарддаг. Үүнд :

1. Нэг зээлдэгч болон түүнд холбогдох хувь хүнд олгох зээлийн нийт зээлийн дүн болон зээлтэй адилтгах бусад активын хамгийн дээд хэмжээг банкны өөрийн хөрөнгийн 20%-аас хэтрүүлж болохгүй.

2. Банктай ямар нэгэн байдлаар холбогдсон этгээдэд олгосон зээлийн хэмжээ болон зээлтэй адилтгах бусад активын дүн нь банкны өөрийн хөрөнгийн 5 хувиас, тэдгээрийн нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтэрч болохгүй.

28.2 Зээлийн эрсдэл

Зээлийн эрсдэл гэдэг нь банкны харилцагч, болон хамтрагч тал гэрээний үүргээ биелүүлээгүйгээс үүдэж банк хүлээж болзошгүй эрсдэлийг хэлнэ. Банк нь тухайн нэг зээлдэгч болон газарзүй, эдийн засгийн салбарын төвлөрлийн хувьд өөрийн дааж болохуйц эрсдэлийн дүнд тохирсон хязгаар тогтоох, тийм хязгаартай холбоотой эрсдэлийн нийт хэмжээнд мониторинг хийх замаар зээлийн эрсдэлийг хянаж удирддаг.

Голомт банк нь барьцаа хөрөнгийн үнэлгээ хяналтыг хийх зэргийг багтаасан зээлдэгч талын зээл даах чадавхид гарч буй өөрчлөлтийг нэн даруй тодорхойлж байхын тулд зээлийн чанарыг хянах процессийг бий болгосон. Зээлийн эрсдэлийн зэрэглэл зээлдэгч бүрээр тогтоох зээлийн эрсдэлийн ангилалын системийг ашиглан тухайн нэг зээлдэгчийн зээл авах дээд хэмжээг тогтоодог. Эрсдэлийн зэрэглэлийг байнга хянан шинэчилж байдаг. Зээлийн зэрэглэлийг эргэн хянах процесс нь үүсч болзошгүй эрсдэлийг тодорхойлсоны үр дүнд хүлээж болзошгүй алдагдлыг тогтоох, мөн түүнээс сэргийлэх зохистой арга хэмжээг авах боломжийг Банкинд олгодог юм.

Банкны зээлийн үйл ажиллагааг удирдах, хяналт зохицуулалт хийх боломжийг бүрдүүлэх зорилгоор чанарын стандартчлагдсан формат ба тайлагналыг хэвшүүлэх, хөгжүүлж, сайжруулах нь энэхүү хяналтын нэгжийн үүрэг юм.

Зээлийн Эрсдэлийн Удирдлагын Хэлтэс нь банкин дахь зээлийн соёлын хөгжлийн нэг хэсэг гэдэг утгаараа банк доторх мэдлэг, туршлага, мэргэжлийн нөөцийг бий болгох болон Хүний нөөцийн хэлтэстэй хамтран Зээлийн Сургалтын хөтөлбөрүүдийн төлөвлөгөөг боловсруулах үүргийг хүлээнэ. Энэ нь банкны шаардлага болон тодорхойлсон чадвар, мэдлэгийн дутагдал, хүрэлцээгүй байдлыг нөхөх зорилготой тасралтгүй бөгөөд жил бүр эргэн хянагддаг үйл явц юм.

Зээлтэй холбоотой болзошгүй төлбөрийн эрсдэл:

Банк нь харилцагчийн өмнөөс төлбөр төлөх магадлал бүхий баталгаануудыг гаргах боломжийг бий болгодог. Ийм төлбөрийг аккредитивын нөхцөлд тулгуурлан харилцагчдаас эргүүлэн татдаг. Эдгээр нь банкинд зээлтэй нэгэн адил эрсдэлийг учруулах ба түүнийг мөн зээлийн үйл ажиллагааны бодлого журмаар зохицуулдаг.

Эдгээр хэрэгслүүдийн гол зорилго нь харилцагчдыг шаардлагатай эх үүсвэрээр хангахад оршино. Баталгаа ба түр аккредитивууд нь харилцагч гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэх чадваргүй болсон тохиолдолд Банк өмнөөс нь төлбөрийг нь барагдуулах цуцлашгүй үүрэг хүлээснийг илэрхийлдэг ба эдгээр хэрэгслийн эрсдэл нь зээлийн эрсдэлтэй ижил юм.

28. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

28.2 Зээлийн эрсдэл (үргэлжлэл)

Барьцаа хөрөнгө болон бусад зээлийн баталгаа, батлан даалтыг тооцохгүйгээр зээлийн учирч болзошгүй эрсдэлийн дээд хэмжээг авч үзвэл

Доорх хүснэгт нь тайлан тэнцлийн үзүүлэлт бүрийн хувьд зээлийн эрсдэлийн дээд хэмжээний өртөлтийг харуулсан байна. Дээд өртөлт нь барьцаа хөрөнгө ашиглаж эрсдэл бууруулах нөлөөний өмнөх буюу нийт дүнгээр илэрхийлэгдсэн болно.

	Тодруулга	Нийт өртөлтийн дээд хэмжээ 2007 мян.төг	Нийт өртөлтийн дээд хэмжээ 2006 мян.төг
Төв банкинд байршуулсан бэлэн мөнгө (гар дээрх бэлэн мөнгийг оруулаагүй)	10	42,491,989	20,222,530
Бусад банкинаас авах авлага	11	206,106,834	114,084,513
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	12	2,565,117	688,092
Санхүүгийн хөрөнгө оруулалт-борлуулахад бэлэн	13	34,950,867	14,996,837
Зээл ба урьдчилгаа	14	323,026,324	174,700,230
Бусад авлага	17	1,264,755	1,412,767
Нийт		610,405,886	326,104,969
Хүлээж болзошгүй үүрэг	26	32,048,731	7,388,154
Болзошгүй өр төлбөр	26	9,156,733	738,007
Нийт		41,205,464	8,126,161
Нийт зээлийн эрсдэлийн өртөлт		651,611,350	334,231,130

Бодит үнээр бүртгэгддэг санхүүгийн хэрэглүүрийн хувьд дээрх дүнгүүд нь өнөөгийн зээлийн эрсдэлийн өртөлтийг харуулсан боловч энэ нь ирээдүйд үнэ цэнэ өөрчлөгдөхөөс шалтгаалж бий болж болох эрсдэлийн дээд хэмжээ биш юм.

Санхүүгийн хэрэглүүрийн анги тус бүр дэх зээлийн эрсдэлийн өртөлтийн дээд хэмжээний талаарх илүү нарийвчилсан мэдээг тусгайлан холбогдох тодруулгуудад хаанаас харж болохыг заасан байх болно. Барьцаа хөрөнгө болон бусад эрсдэлийг бууруулах арга техникүүдийн нөлөөллийг дор харуулав.

Зээлийн эрсдэлд дээд хэмжээгээр өртөх эрсдэлийн төвлөрөл

Эрсдэлийн төвлөрлийг харилцагч тал/үйлчлүүлэгч ба эдийн засгийн салбар тус бүрээр ангилан зохицуулна. 2007 оны 12-р сарын 31-ний байдлаар аливаа харилцагч тал/үйлчлүүлэгчээс учирч болох зээлийн эрсдэлд өртөх дээд хэмжээ нь 6.582 сая төгрөг (2006 онд 3.772 сая төгрөг) байв.

Бусад банк болон санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж болон бусад хөрөнгө болох 179.597 сая төгрөг (2006 онд 99.055 сая төгрөг) –с бусад банкны бүх хөрөнгө болон өр төлбөр нь газарзүйн хувьд Монгол Улсад төвлөрч байна.

Барьцаа хөрөнгө болон бусад зээлийн сайжруулалтыг тооцохоос өмнөх Банкны санхүүгийн хөрөнгийн эдийн засгийн салбарын шинжилгээг дор үзүүлэв.

	Нийт өртөлтийн дээд хэмжээ 2007 мян.төг	Нийт өртөлтийн дээд хэмжээ 2006 мян.төг
Хөдөө аж ахуй	2,125,425	5,556,359
Барилга	46,711,874	10,275,672
Өргөн хэрэглээ	41,512,942	11,356,728
Боловсрол	1,818,714	2,943,360
Эрчим хүч, газрын тос	43,360,612	17,406,118
Санхүүгийн үйлчилгээ	249,636,938	132,904,436
Эрүүл мэнд	7,328,447	665,975
Өрхийн бизнес	562,565	807,868
Зочид буудал, зоогийн газар	8,131,126	5,346,055
Олон улсын байгууллага	159,012	152,458
Засвар үйлчилгээ	3,890,120	1,250,971
Боловсруулах үйлдвэрлэл	39,992,186	25,412,520
Уул уурхай, хайгуул	22,996,032	12,204,088
Олон нийтийн үйлчилгээ	49,922,198	20,225,369
Үл хөдлөх хөрөнгө	14,301,883	11,897,143
Нийгмийн үйлчилгээ	1,759,268	1,501,047
Аялал зуучлал	1,271,677	648,942
Тээвэр ба харилцаа холбоо	17,279,253	9,578,523
Бөөний болон жижиглэнгийн худалдаа	97,586,123	62,684,731
Бусад	1,264,955	1,412,767
	651,611,350	334,231,130

Барьцаа ба зээлийн бусад сайжруулалтууд

Барьцаа хөрөнгийн шаардагдаж буй хэмжээ ба төрлийг зээлдэгч талын зээлийн эрсдэлийн шинжилгээнд үндэслэн тогтооно. Зөвшөөрч болохуйц барьцаа хөрөнгийн төрлүүд болон үнэлгээний параметруудийг тодорхой удирдамж, журмаар зохицуулдаг.

Гол барьцаа хөрөнгийн төрлүүд:

1. Аж ахуйн нэгжийн зээл: Үл хөдлөх хөрөнгө, бараа материал, тоног төхөөрөмж ба автомашин.
2. Жижиг бизнесийн зээл: Үл хөдлөх хөрөнгө.
3. Хэрэглээний зээл: Автомашин, цахилгаан бараа, орлого
4. Орон сууцны зээл: Амьдрах зориулалттай үл хөдлөх хөрөнгө

28. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

28.2 Зээлийн эрсдэл (үргэлжлэл)

Мөн Банк нь охин компанид зээл олгохдоо толгой компаниар батлан даалт хийлгэж болдог. Гэхдээ эдгээр боломжит эрсдэлээс хамгаалсан хэмжээг дээрх хүснэгтэд тусгаагүй болно.

Барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэлгээнд удирдлагууд хяналт тавьдаг. Үндсэн гол гэрээ хэлэлцээрт зохицуулагдсанаар тухайн зээлд нэмж барьцаа хөрөнгө барьцаалахад удирдлагууд мөн хяналт тавьдагаас гадна эдгээр барьцаа хөрөнгийн зах зээлийн үнийг зээлийн үнэ цэнийн бууралтын санг зохистой эсэхийг шалгах явцдаа давхар хянадаг.

Барьцаа хөрөнгөнд тооцогдон хураагдсан эд хөрөнгийг цэгцтэй арга замаар борлуулах нь Банкны нэг бодлого юм. Олсон орлогыг төлөгдөөгүй үлдсэн зээлийн хэмжээг багасгах, барагдуулахад ашигладаг. Ерөнхийдөө Банк хураагдсан эд хөрөнгийг өөрийн бизнесийн хэрэглээнд ашигладаггүй.

Санхүүгийн хөрөнгүүдийн ангилал бүрээр харуулсан зээлийн чанар.

2007 оны 12 сарын 31-ний байдлаар	Тод-руулга	Өндөр зэрэглэл мян.төг	Стандарт зэрэглэл мян.төг	Хугацаа хэтрэлтгүй ба үнэ цэнийн бууралтгүй зээл		Нийт мян.төг
				Стандартаас доогуур зэрэглэл мян.төг	Хугацаа хэтэрсэн эсвэл дангаараа үнэ цэнийн бууралттай мян.төг	
Бусад банк санхүүгийн байгууллага						
дахь харилцах, хадгаламж	11	182,930,405	18,530,522	4,645,907	-	206,106,834
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр						
	12	2,565,117	-	-	-	2,565,117
Санхүүгийн хөрөнгө оруулалт						
- борлуулахад бэлэн	13	34,749,867	201,000	-	-	34,950,867
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа						
Бизнесийн зээл	14	159,828,270	55,228,624	35,413,240	19,487,215	269,957,349
Жижиг бизнесийн зээл	14	6,209,083	13,478,918	1,531,755	3,133,933	24,353,689
Хэрэглээний зээл	14	7,982,188	3,593,660	17,374	1,425,336	13,018,558
Орон сууцны зээл	14	14,859,759	5,412,035	7,658	1,728,526	22,007,978
Бусад	14	6,788,171	58,720	317,223	838,151	8,002,265
		195,667,471	77,771,957	37,287,250	26,613,161	337,339,839
Нийт		415,912,860	96,503,479	41,933,157	26,613,161	580,962,657

Санхүүгийн хөрөнгүүдийн ангилал бүрээр харуулсан зээлийн чанар.

2006 оны 12 сарын 31-ний байдлаар	Хугацаа хэтрэлтгүй ба үнэ цэнийн бууралтгүй зээл					Нийт мян.төг
	Тод-руулга	Өндөр зэрэглэл мян.төг	Стандарт зэрэглэл мян.төг	Стандартаас доогуур зэрэглэл мян.төг	Хугацаа хэтэрсэн эсвэл дангаараа үнэ цэнийн бууралттай мян.төг	
Бусад банк санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	11	112,054,880	117,165.00	1,912,468.00	-	114,084,513
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	12	688,092	-	-	-	688,092
Санхүүгийн хөрөнгө оруулалт – борлуулахад бэлэн	13	14,995,837	1,000	-	-	14,996,837
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа						
Бизнесийн зээл	14	101,059,093	14,464,288	10,476,460	29,455,120	155,454,961
Жижиг бизнесийн зээл	14	4,997,565	9,952,137	1,297,849	2,530,246	18,777,797
Хэрэглээний зээл	14	1,433,538	305,626	-	478,065	2,217,229
Орон сууцны зээл	14	4,472,243	2,175,095	-	827,780	7,475,118
Бусад	14	2,336,879	131,345	172,248	472,507	3,112,979
		114,299,318	27,028,491	11,946,557	33,763,718	187,038,084
Нийт		242,038,127	27,146,656	13,859,025	33,763,718	316,807,526

Хугацаа хэтэрсэн зээл ба урьдчилгаанд зөвхөн цөөн хоногийн хугацаа хэтэрсэн тохиолдлуудыг оруулдаг. Зээлүүдийн хугацаа хэтрэлтээрх шинжилгээг дор үзүүлэв. Хугацаа хэтэрсэн зээлүүдийн дийлэнх нь үнэ цэнийн бууралтгүй гэж үзсэн.

Хугацаа хэтэрсэн, гэхдээ үнэ цэнэ буураагүй санхүүгийн хөрөнгийн ангилал бүрээрх насжилтын шинжилгээ

2007 оны 12 сарын 31-ний байдлаар	30 хоногоос бага мян.төг	31-60 хоног мян.төг	61-90 хоног мян.төг	91-ээс дээш хоног мян.төг	Нийт мян.төг
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа					
Бизнесийн зээл	-	955,832	426,064	4,350,163	5,732,059
Жижиг бизнесийн зээл	137,147	669,472	420,725	1,651,342	2,878,686
Хэрэглээний зээл	718	550,960	278,918	583,233	1,413,829
Орон сууцны зээл	-	623,447	269,716	835,363	1,728,526
Бусад	563,472	32,837	44,410	197,493	838,212
	701,337	2,832,548	1,439,833	7,617,594	12,591,312

28. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

28.2 Зээлийн эрсдэл (үргэлжлэл)

Хугацаа хэтэрсэн, гэхдээ үнэ цэнэ буураагүй санхүүгийн хөрөнгийн ангилал бүрээрх насжилтын шинжилгээ (үргэлжлэл)

2006 оны 12 сарын 31-ний байдлаар	30 хоногоос			91-ээс	Нийт
	бага	31-60 хоног	61-90 хоног	дээш хоног	
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа					
Бизнесийн зээл	102,571	3,124,986	1,172,771	3,559,838	7,960,166
Жижиг бизнесийн зээл	75,575	348,114	359,676	1,480,754	2,264,119
Хэрэглээний зээл	8,027	36,887	83,284	313,894	442,092
Орон сууцны зээл	-	251,564	94,544	460,292	806,400
Бусад	390,287	15,794	14,636	120,892	541,609
	576,460	3,777,345	1,724,911	5,935,670	12,014,386

Хугацаа хэтэрсэн гэхдээ, үнэ цэнэ буураагүй нийт зээл ба урьдчилгааны барьцаа хөрөнгийн бодит үнэлгээ 2007 оны 12 сарын 31-ний байдлаар 204.82 тэрбум төгрөг (2006: 79.37 тэрбум төгрөг) байв. Барьцаалсан барьцаа хөрөнгийн төрлүүдийн дэлгэрэнгүй мэдээллийг “Тодруулга 28” буюу “Барьцаа ба зээлийн бусад сайжруулалтууд” –с үзнэ үү.

Хугацааны хувьд сунгагдсан санхүүгийн хөрөнгийн ангилал бүрийн бүртгэлийн дүн

Доорх хүснэгтэд гэрээнд өөрчлөлт орсон санхүүгийн хөрөнгийн бүртгэлийн дүнг ангилал бүрээр үзүүлэв.

	2007	2006
	мян.төг	мян.төг
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа		
Бизнесийн зээл	39,104,777	15,639,561
Жижиг дунд бизнесийн зээл	428,557	415,587
Хэрэглээний зээл	17,374	-
Орон сууцны зээл	14,033	-
Бусад	317,223	172,247
	39,881,964	16,227,395

Үнэ цэнийн бууралтын шинжилгээ

Зээлийн үндсэн ба хүүгийн графикт төлбөр 90-с дээш өдрөөр хугацаа хэтэрч байгаа, эсхүл зээлдэгчийн мөнгөн урсгалд хүндрэл гарсан нь мэдэгдэж буй, зээлийн үнэлгээ доогуур гарсан, зээлийн гэрээний эх нөхцлүүд зөрчигдсөн тохиолдлуудыг үнэ цэнийн бууралтын шинжилгээ хийх явцад авч үздэг. Банк нь үнэ цэнийн бууралтын шинжилгээг дараах хоёр байдлаар ялган хийдэг: бүлгээр үнэлэгдсэн сан ба дангаар (тусгай) үнэлэгдсэн сан.

Тусгай үнэлгээгээр үнэлэгдсэн зээлийн эрсдэлийн сан

Банк нь дангаараа чухал зээлүүдийг ялган авч нэг бүрчлэн эрсдэлийн тохирох санг байгуулдаг. Үнэ цэнэ бууралтын хэмжээг тодорхойлоход зээлдэгчийн бизнес төлөвлөгөөний тогтвортой байдал, түүний санхүүгийн бий болсон хүндрэлийг арилгах чадавхи, төсөөлсөн орлого, дампуурал гарсан тохиолдолд дагаж гарч болзошгүй холбогдох ногдол ашгийн болон бусад төлбөрүүд, бусад санхүүгийн дэмжлэгийн боломж ба барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнэ болон төлөвлөж буй мөнгөн урсгалын орж ирэх хугацаа зэргийг нэг бүрчлэн авч үздэг.

Гэнэтийн үйл явдлын улмаас илүү нухацтайгаар анхаарахыг шаардсанаас бусад тохиолдолд үнэ цэнэ бууралтын алдагдал нь жил бүрийн тайлагналын өдрөөр үнэлэгдэн тооцогддог.

Бүлгийн үнэлгээгээр үнэлэгдсэн зээлийн эрсдэлийн сан

Дангаараа чухал бус бүх зээл ба урьдчилгаа (зээлийн карт, орон сууцны зээл, болон бусад бүх хэрэглээний зээлийг оролцуулаад), мөн дангаараа чухал боловч тусгай үнэлгээгээр үнэ цэнэ буурах нотолгоо байгаагүй зээл ба урьдчилгааны хувьд бүлгээр нэгтгэн ангилаж, бүлэг тус бүрт эрсдэлийн алдагдлыг тооцно. Бүлгийн үнэлгээг жил бүрийн тайлагналын өдрөөр бүлэг тус бүрт ялгаатай шинжилгээнд үндэслэн хийнэ.

Бүлгийн үнэлгээнд тусгай үнэлгээгээр үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байхгүй боловч тэдгээрийг оруулсан багцийн түвшинд оршин байх магадлалтай үнэ цэнийн бууралтыг тооцдог. Үнэ цэнийн бууралтын алдагдалыг дараах мэдээлэлд үндэслэн тооцдог: бүлгийн алдагдлын түүхэн мэдээ, өнөөгийн эдийн засгийн байдал, алдагдал гарсан гэж таамаглаж буй үе болон тус алдагдлыг танин илрүүлсэн үе хоорондын ойролцоолсон хугацаа мөн үнэ цэнийн бууралттай гэж тогтоогдсоны дараа хүлээгдэж буй эргэн төлөлт, орлого. Бүлгийн үнэлгээ нь нэг жилийн давтамжтайгаар хийгдэх ба Банкны удирдлага энэхүү давтамжийг өөрчлөх эсэхийг шийднэ. Үнэ цэнийн бууралтын санг Банкны нийт бодлоготой нийцэж байгаа эсэхийг хянуулах үүднээс Зээлийн удирдлагаар шалгуулдаг.

Санхүүгийн баталгаа болон аккредитивыг үнэлж санг нь зээлийнхтэй ижил хэлбэрээр байгуулдаг.

28.3 Төлбөрийн чадварын эрсдэл

Санхүүгийн хэвийн болон хүндрэлийн үед Банк харилцагчийн өмнө хүлээсэн төлбөрийн үүргээ гүйцэтгэж чадахгүй байх эрсдэлийг Төлбөрийн чадварын эрсдэл гэдэг. Ирээдүйн мөнгөн урсгал, өдөр тутмын төлбөрийн чадварт мониторинг хийх, шаардлагатай түвшинд хөрвөх актив барих, тогтвортой эх үүсвэр татах замаар банк энэхүү эрсдэлийг удирддаг. Төлбөрийн чадварын эрсдэлийн удирдлагад хүлээгдэж буй мөнгөн урсгалын үнэлэлт, шаардлагатай тохиолдолд нэмэлт эх үүсвэр татахад ашиглагдах өндөр зэрэглэлтэй барьцааг мөн хамруулдаг.

Банк бэлэн мөнгөний хүлээгдээгүй хүндрэлд орох үед зах зээлд маш хялбарханаар борлогдох төрөл бүрийн активуудаас бүрдэх багцыг барьж байдаг. Банк мөн төлбөрийн чадварын хүндрэлд орох үед ашиглах зорилгоор зээлийн шугамын эрх авсан байдаг. Үүнээс гадна харилцагчаас татсан хадгаламжийн 5%-тай тэнцүү дүнтэй бэлэн мөнгийг хууль ёсны дагуу Монголбанкинд (Төв банк) байршуулдаг. Төлбөрийн чадварыг зах зээлийн болон банктай холбоотой стресс хүчин зүйлсийг тооцсон янз бүрийн нөхцөл байдалд үнэлж удирддаг. Эдгээр төлбөрийн чадварын удирдлагуудаас зах зээлийн нөхцөл байдлын нөлөөг тусгасан цэвэр хөрвөх активыг харилцагчаас татсан эх үүсвэрт харьцуулсан харьцаанд лимит тавих нь банкны зүгээс хамгийн чухал удирдлага болдог. Бэлэн мөнгө, богино хугацаагаар банкинд байршуулсан харилцах, хадгаламж, түргэн борлогдох үнэт цааснаас нэг сарын дотор төлөгдөх ёстой бусад банкнаас татсан хадгаламж, зээлийг хасч цэвэр хөрвөх активыг гаргадаг. Энэ харьцаа 2006, 2007 оны хувьд дараах байдалтай байв:

	2007	2006
	мян.төг	мян.төг
	%	%
12 сарын 31	49.3%	53.2%
Тухайн жилийн дундаж	53.0%	47.3%
Тухайн жилийн хамгийн их	59.3%	53.2%
Тухайн жилийн хамгийн бага	49.3%	43.2%

28. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

28.3 Төлбөрийн чадварын эрсдэл (үргэлжлэл)

Дараах хүснэгтэнд 2007 оны 12 сарын 31-ний байдлаарх банкны санхүүгийн дискаунтлаагүй өр төлбөрийн эргэн төлөгдөх хугацааг дүрсэлсэн. Эдгээр өр төлбөрийн хүлээгдэж буй эргэн төлөгдөх хугацааг “актив пассивын эргэн төлөгдөх хугацааны шинжилгээ” гэсэн Тодруулга 27-с харна уу. Урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр төлөгдөх ёстой өр төлбөрийг мэдэгдэл нь ирсэн гэж тооцов. Хэдий тийм боловч, Банк харилцагчдын дийлэнх нь гэрээт хугацаанаасаа өмнө зарлагын гүйлгээ гаргахгүй гэж үзэж буй ба Банк хадгаламжийн түүхэн үлдэцээр тодорхойлогдон хүлээгдэж буй мөнгөн урсгалын нөлөөг хүснэгтэнд тусгаагүй болно.

Санхүүгийн өр төлбөр	Хугацаагүй мян.төг	6 хүртэлх сар			1-5 жил мян.төг	5 жилээс дээш мян.төг	Дискаунт -лаагүй санхүүгийн нийт өр төлбөр мян.төг
		6 хүртэлх сар мян.төг	6-12 сар мян.төг	6-12 сар мян.төг			
2007 оны 12 сарын 31							
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	34,478,000	2,539,714	-	-	-	-	37,017,714
Харилцагчдын харилцах, хадгаламж	412,574,021	64,458,177	42,274,867	1,224,023	-	-	520,531,088
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	2,565,117	-	-	125,206	-	-	2,690,323
Зээлээр авсан санхүүжилт	879,455	3,714,707	7,708,883	15,748,179	1,348,767	-	29,399,991
Хоёрдогч өглөг	237,945	195,000	713,835	20,985,699	-	-	22,132,479
Бусад пассив	23,105,886	33,666	296,818	-	-	-	23,436,370
Нийт	473,840,424	70,941,264	50,994,403	38,083,107	1,348,767	635,207,966	
2006 оны 12 сарын 31							
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	19,206,572	1,000,000	30,960	-	-	-	20,237,532
Харилцагчдын харилцах, хадгаламж	219,820,748	35,546,140	33,740,270	68,584	-	-	289,175,742
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	688,092	-	-	-	-	-	688,092
Зээлээр авсан санхүүжилт	510,302	883,488	2,008,212	4,544,704	2,559,448	-	10,506,154
Хоёрдогч өглөг	97,500	195,000	292,500	6,840,000	-	-	7,425,000
Бусад пассив	5,290,459	125,464	11,801	-	-	-	5,427,724
Нийт	245,613,673	37,750,092	36,083,743	11,453,288	2,559,448	333,460,244	

Доорх хүснэгтэнд Банкны хүлээж болзошгүй өр төлбөр болон үүргүүдийг гэрээт эргэн төлөгдөх хугацаагаар нь харуулав.

	Хугацаагүй мян.төг	3 хүртэлх сар мян.төг	3-12 сар мян.төг	1-5 жил мян.төг	5 жилээс дээш мян.төг	Нийт мян.төг
2007 оны 12 сарын 31						
Болзошгүй өр төлбөр	32,048,731	-	-	-	-	32,048,731
Үүрэг	-	687,322	5,919,766	2,409,810	139,835	9,156,733
Нийт	32,048,731	687,322	5,919,766	2,409,810	139,835	41,205,464
2006 оны 12 сарын 31						
Болзошгүй өр төлбөр	7,388,154	-	-	-	-	7,388,154
Үүрэг	-	13,790	197,778	525,039	1,400	738,007
Нийт	7,388,154	13,790	197,778	525,039	1,400	8,126,161

28.4 Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн эрсдэл гэдэг нь хүү болон ханшийн зэрэг зах зээлийн хувьсагчуудад орсон өөрчлөлтөөс болж санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ болон ирээдүйн мөнгөн урсгал өөрчлөгдөх эрсдэлийг хэлнэ. Банк нь энэ төрлийн эрсдэлийг VaR болон мэдрэмжийн шинжилгээ хийх замаар хянаж, удирддаг. Гадаад валютын төвлөрөлөөс бусдаар зах зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц төвлөрөл байхгүй байна.

Хүүгийн эрсдэл

Хүүгийн аливаа хөдөлгөөн нь санхүүгийн хэрэглүүрийн үнэ цэнэ болон ирээдүйн мөнгөн урсгалд нөлөө үзүүлж болохоос хүүгийн эрсдэл үүсдэг. Тодорхой хугацаанд байж болох хүүгийн зөрүүгийн хязгаарлалтыг ТУЗ-аас тогтоож өгдөг. Хүүгийн нээлттэй позицуудыг өдөр тутам хянадаг бөгөөд тогтоосон хязгаарт байлгахын тулд хэджинг буюу хамгаалалтын арга хэмжээ авч хэрэгжүүлдэг.

Доорх хүснэгт нь бусад бүх нөхцөл байдал өөрчлөгдөөгүй байхад хүүгийн боломжит хөдөлгөөн банкны орлого, үр дүнгийн тайланд хэрхэн нөлөөлж байгааг харуулж байна.

Орлого, үр дүнгийн тайлангийн мэдрэмтгий байдал гэдэг нь 2007 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх банкны хөвөгч хүүтэй санхүүгийн актив пассивт үндэслэн нэг жилийн хүүгийн цэвэр орлогод үзүүлэх хүүгийн таамагласан хөдөлгөөний нөлөө юм.

Валютын нэгж	Суурь цэгийн өөрчлөлт	Хүүгийн цэвэр орлогын мэдрэмж мян.төг
2007 оны 12 сарын 31		
Доллар	+90	(170.81)
Төгрөг	+90	(567.81)
Доллар	-120	170.81
Төгрөг	-120	567.81
2006 оны 12 сарын 31		
Доллар	+120	(198.86)
Төгрөг	+150	(424.23)
Доллар	-120	198.86
Төгрөг	-150	424.23

28. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

28.4 Зах зээлийн эрсдэл (үргэлжлэл)

Ханшийн эрсдэл

Гадаад валютын ханшийн хөдөлгөөн нь банкны санхүүгийн төлөв байдал, мөнгөн урсгалд нөлөөлж болох эрсдэлд Банк өртдөг. Банкны удирдлагаас өдөртөө байж болох болон хоног дамжиж болох нээлттэй позицийн хязгаарлалтыг нэг валют (ихэвчлэн америк доллараар) болон нийт валютын нийлбэр дүнгээр тогтоон өдөр болгон хянаж явдаг байна.

ТУЗ-өөс гадаад валютын багцын тухайд хүлээж болох эрсдэлийн хязгаарлалтуудыг тогтоож өгсөн. 99 хувийн магадлалтайгаар банкны нээлттэй позицгийг үнэлэх, Монголбанкны ханшийн өөрчлөлтийг хэд хэдэн үзүүлэлт болон төсөөлөлтэйгөөр авч үзэн, үүнээс учирч болох эдийн засгийн алдагдлыг тооцоолох VaR аргыг Банк хэрэглэж байна. VaR нь тодорхой цаг хугацааны хүрээнд, тодорхой магадлалтайгаар Банкны гадаад валютын багцын ашиггүй хөдөлгөөн, өөрчлөлтийг тооцох замаар банкинд учирч болох санхүүгийн эрсдэлийг тодорхойлох аргачлал юм.

VaR аргын зорилго, сул талууд

Өнгөрсөн нэг жилийн мэдээлэл дээр суурилан гадаад валютын багцын боломжит өөрчлөлтийг тооцоолох зорилгоор банк VaR-ын Delta Normal, Monte Carlo, Historical Simulation аргуудыг хэрэглэж байна. VaR аргачлал нь зах зээлийн ердийн нөхцөл байдалд гадаад валютын эрсдэлийг тооцоход зориулагдсан. Delta Normal, Monte Carlo Simulation аргуудад хэвийн зах зээлийн орчинд нөлөөлөгч эрсдэлийн хүчин зүйлсийн аливаа өөрчлөлт нь хэвийн тархалттай гэж үздэг. Эдгээр хоёр VaR арга нь тодорхой дутагдалтай талуудтай учир нь эдгээр аргууд нь гадаад валютын түүхэн корреляци, хэлбэлзэлд үндэслэдэг ба ирээдүйн валютын ханшийн өөрчлөлт хэвийн тархалттай гэж таамагладаг.

VaR арга нь түүхэн өгөгдөлд үндэслэдэг болохоор эрсдэлийн хүчин зүйлсийн ирээдүйн өөрчлөлтийг сайн тусгаж чадахгүй байх талтай бөгөөд хэвийн тархалтын таамаглалд эрсдэлийн хүчин зүйлсийн өөрчлөлт нь нийцээгүй тохиолдолд гадаад валютын ханшийн их хэмжээний өөрчлөлтийг дутуу үнэлж болох талтай. VaR нь эрсдэлийн хүчин зүйлсийн хоорондын хамаарал, эрсдэлийн хүчин зүйлсүүдэд тавьсан таамаглалаас шалтгаалж эрсдэлийг дутуугаар эсвэл илүүгээр үнэлэх боломжтой. Гадаад валютын позици өдрийн турш өөрчлөгддөг боловч VaR нь зөвхөн өдрийн төгсгөлд хаагдсан багцын эрсдэлийг хэмждэг ба 99% итгэх завсраас хэтэрч алдаж болзошгүй алдагдлын дүнг тооцож чадахгүй.

Практикт гадаад валютын бодит үр дүнгүүд VaR тооцооллоос зөрдөг. Тухайлбал, хэвийн бус зах зээлийн нөхцөлд тооцоолол бодит ашиг алдагдалтай уялдаж чаддаггүй. VaR загварын бодит байдалтай нийцэж буйг тодорхойлохын тулд бодит үр дүнгүүдийг тодорхой хугацааны /гурван сар/ давтамжтайгаар VaR тооцоололтой харьцуулж үзэн Backtesting хийдэг. Зах зээлийн онцгой хүндрэлийн нөлөөг Банк даван туулж чадах эсэхэд баталгаатай байх үүднээс банк гадаад валютын багцдаа тогтмол стресс тест хийдэг.

VaR таамаглалууд

Банк 99%-ийн итгэх завсар ашиглан VaR тооцдог тул гадаад валютын нээлттэй позиц нэг өдрийн турш өөрчлөгдөхгүй гэж үзвэл боломжит алдагдлын хэмжээ VaR-аас их байх бараг боломжгүй. Нэг өдрийн хугацаанд 99%-ийн итгэх завсартай VaR гэдэг нь аливаа 100 өдрийн бодит ашиг алдагдлын дүн тооцоолж гаргасан VaR-с дунджаар нэг удаа их байхыг илтгэнэ.

VaR нь банкны гадаад валютын эрсдэлийн салшгүй хэсэг тул гадаад валютын нээлттэй позицуудад VaR лимит тогтоосон бөгөөд эдгээр лимитүүдтэй нээлттэй позиц дүнг өдөр тутам харьцуулж хянаж байдаг. Загварт Монголбанкны гадаад валютын ханшийн эрсдэлийг VaR аргаар хэмжих аргачлалын таамаглалуудаас нэгтгэж өгсөн байдаг.

	Дэлта хэвийн мян.төг	Монтэ Карло мян.төг	Уламжлалт загвар мян.төг
2007 - 12 сарын 31	34,857	37,904	48,513
2007 - Дундаж	45,827	50,755	61,309
2007 - Хамгийн их	76,531	84,367	89,327
2007 - Хамгийн бага	23,317	25,762	31,324
2006 - 12 сарын 31	40,635	43,751	50,600
2006 - Дундаж	41,698	40,832	43,561
2006 - Хамгийн их	89,485	96,974	98,780
2006 - Хамгийн бага	11,885	12,230	11,643

Урьдчилж төлөлтийн эрсдэл

Урьдчилж төлөлтийн эрсдэл нь харилцагч эсвэл гэрээнд оролцогч тал төлбөрөө урьдчилж төлөх, эсвэл төлбөрөө урдчилан хугацаанаас өмнө хийхийг хүссэнээс банк алдагдалд орох эрсдэлийг хэлнэ. Тухайлбал, тогтмол хүүтэй орон сууцны зээлийн хувьд хүү буурах үед зээлдэгчид зээлээ урьдчилж төлснөөс энэ хэлбэрийн эрсдэл үүсдэг.

Банк өөрийн дотооддоо боловсруулсан загвар ашиглан хүүгийн цэвэр орлогодоо урьдчилан төлөлтийн янз бүрийн нөлөөллийг тооцоолдог.

Өнгөрсөн жилийн урьдчилан төлөлтийн түвшинг суурь болгон авч бусад бүх хувьсагчид тогтмол гэж үзэн жилийн эхэнд төлөгдөхөөр тооцон үзэхэд татварын өмнөх жилийн ашигт дараах хэлбэрийн нөлөөлөл гарч байна.

	Хүүгийн цэвэр орлогод үзүүлэх нөлөөлөл 2007 мян.төг	Хүүгийн цэвэр орлогод үзүүлэх нөлөөлөл 2006 мян.төг
Харилцагчаас авах зээл ба урьдчилгаа		
Байгууллагын	(270)	(147)
Жижиг дунд бизнесийн	(58)	(51)
Хэрэглээний	(22)	(5)
Орон сууцны	(17)	(5)
Бусад	(7)	(2)
	(374)	(210)

Үйл ажиллагааны эрсдэл

Үйл ажиллагааны эрсдэл гэдэг нь системийн доголдол, хүний алдаа, залилан болон бусад гадаад хүчин зүйлээс банкинд учирч болох алдагдалын эрсдэлийг хэлнэ. Хяналт сул үед үйл ажиллагааны эрсдэл нь банкны нэр хүндэд хохирол учруулах, хууль зохицуулалтын асуудалд оруулах, улмаар санхүүгийн алдагдалд хүргэх болно. Банк хэдийгээр үйл ажиллагааны эрсдэлийг бүрэн арилгах бололцоогүй ч хяналт, мониторинг сайжруулах замаар энэ төрлийн эрсдэлийг удирдаж болно. Эрхийн хэм хэмжээг зөв тогтоох, боловсон хүчний сургалт, боловсрол, дотоод хяналт зэрэг нь хяналтын арга хэмжээнд орно.

29 ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ТОДРУУЛГА

Бодь Интернэшнл ХХК нь Банкны дүрмийн санг 100% эзэмшдэг.

Бизнесийн ердийн үйл ажиллагааны явцад зээл олгох, хадгаламж байршуулах, гадаад валютын гуйвуулгын гүйлгээ хийх зэрэг холбоотой талуудтай хэд хэдэн гүйлгээ хийсэн байна. Эдгээр ажил гүйлгээг арилжааны нөхцлөөр зах зээлийн ханшаар гүйцэтгэсэн.

Банкинд томоохон санхүүгийн сонирхол бүхий холбоотой талуудтай тухайн жилд хийсэн гүйлгээний хэмжээг 12-р сарын 31-нээрх үлдэгдлээр дор үзүүлэв:

	2007	2006
	мян.төг	мян.төг
а) Зээл ба урьдчилгааг салбараар:	2,051,587	215,285
Бодь Электроникс ХХК	802,683	176,148
Бодь Пропертиз ХХК	1,169,970	-
Бодь Интернэшнл ХХК	39,797	-
Эм Пи Си ХХК	39,137	39,137
	2,051,587	215,285

Холбоотой талуудад олгосон зээл нь барьцаатай, жилийн 10.68%-18.0% (2006 онд 14.4% -18.0%) хүү тооцдог ба нэг жилийн дотор эргэн төлөгдөх хугацаатай. Тайлант жилд тус зээлүүдээс хүлээн авсан хүүгийн орлого нь 71.52 сая төгрөг (2006 онд 2.11 сая төгрөг) байна.

	2007	2006
	мян.төг	мян.төг
б) Холбоотой талуудаас хүлээн авсан харилцах, хадгаламж:		
Толгой компани	5,443	164,076
Холбоотой компаниуд	2,937,906	1,736,941
	2,943,349	1,901,017

Дээрх холбоотой талуудын байршуулсан харилцах, хадгаламж нь жилийн 3.00% -13.20% (2006 онд 3.00% -13.20%) хүү тооцдог. Тайлант жилд эдгээр холбоотой талуудад төлсөн хүүгийн зардал 149.29 сая төгрөг (2006 онд 72.74 сая) байсан.

	2007	2006
	мян.төг	мян.төг
в) Холбоотой талуудаас худалдан авсан компьютер, програм хангамж	399,480	206,003
г) Гаражийн түрээс	-	1,672

	2007	2006
	мян.төг	мян.төг
д) Гол удирдах албан тушаалтнуудад олгосон нөхөн олговор		
Цалин	61,685	59,907
Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	11,720	11,382
	73,405	71,289

е) Бодь Интернэшнл ХХК-тай байгуулсан түрээсийн гэрээ

2002 оны 11 дүгээр сард Банк нь Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатарын талбайн 3-т байршилтай өөрийн шинэ ажлын байранд нүүн орсон. Энэ барилгыг Банкны толгой компани болох Бодь Интернэшнл ХХК эзэмшдэг.

Банк нь 2008 он хүртэл 6 жилийн хугацаатай түрээсийн гэрээ байгуулсан. Банк нь 3.2 тэрбум төгрөгийн түрээсийн төлбөрийг 2003 онд урьдчилж төлсөн. 2007 оны 12-р сарын 31-ний байдлаар урьдчилсан төлбөрийн дүн нь 570.64 сая (2005: 1,094 сая) төгрөг байна. Тус түрээстэй холбоотой мэдээллийг Тодруулга 28-д тусгасан болно.

30 ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА

Банк бизнесийн салшгүй эрсдэлийг өөрийн хөрөнгөдөө тулгуурлан үр ашигтай удирддаг. Бусад арга хэмжээнүүдээс гадна Монголбанкнаас тогтоосон дүрэм, харьцаануудыг ашиглах замаар банкны өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хянадаг.

Өнгөрсөн жилийн турш Банк нь өөрийн хөрөнгөд хөндлөнгөөс тавьдаг бүх шалгууруудыг бүрэн хангаж ажилласан.

Капиталын удирдлага

Банкны капиталын удирдлагын үндсэн зорилго нь хөндлөнгөөс тавигдсан зохистой харьцааны шалгууруудыг биелүүлэх ба бизнесээ дэмжиж хувь нийлүүлэгчдийн үнэлэмжийг ихэсгэхийн тулд зээлийн эрсдэлийн чансааг хадгалахад оршдог.

Банк өөрийн хөрөнгийн бүтцийг удирдаж, эдийн засгийн нөхцөл байдал болон үйл ажиллагааных нь эрсдэлийн шинж чанарт орсон өөрчлөлтүүдийг харгалзан капиталын бүтэцдээ залруулга хийдэг байна. Банк капиталынхаа бүтэцээ хадгалах эсвэл тохируулахын тулд хувь нийлүүлэгчдэд төлөх ногдол ашгийн хэмжээг тохируулах, хувь нийлүүлэгчид хөрөнгийг нь эргүүлэн төлөх, шинээр өөрийн хөрөнгийн хэрэглүүр гаргах, эсвэл өөрийн хөрөнгөд уялдсан үнэт цаас гаргах зэрэг арга замуудыг ашигладаг байна.

Зохицуулалттай капитал

Монголбанкнаас арилжааны банкуудын өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хамгийн багадаа 5%, өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцааг 10%-иас доошгүй байхаар тогтоосон байдаг бөгөөд эдгээр харьцаа нь эрсдэлийн уг шинж чанараар нь тохируулсан актив болон нийт капиталыг авч тооцоологдсон байдаг. Банкны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх өөрийн хөрөнгийн зохистой харьцааг үзүүлбэл:

	2007	2006
Өөрийн хөрөнгийн харьцаа	10.14%	14.58%
Эрсдэлээр жигнэсэн хөрөнгийн харьцаа	14.39%	16.68%

30 ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Зохицуулалттай капитал (үргэлжлэл)

	2007 мян.төг	2006 мян.төг
I зэрэглэлийн хөрөнгө		
Дүрмийн сан	21,934,142	21,934,142
Хуримтлагдсан ашиг	16,737,647	9,359,924
Нийт I зэрэглэлийн хөрөнгийн дүн	38,671,789	31,294,066
II зэрэглэлийн хөрөнгө		
Хоёрдогч өглөг	16,199,700	4,500,000
Нийт капитал/капиталын суурь	54,871,489	35,794,066

12 сарын 31-ний байдлаар эрсдэлээр нь жигнэсэн активуудыг эрсдэлийн ангилал тус бүрээр үзүүлбэл:

%	2007		2006	
	Актив мян.төг	Эрсдэлээр жигнэсэн мян.төг	Актив мян.төг	Эрсдэлээр жигнэсэн мян.төг
0	104,052,020	-	54,346,543	-
10	-	-	-	-
20	178,266,014	35,653,203	111,911,673	22,382,335
50	40,905,598	20,452,799	1,623,042	811,521
100	325,223,806	325,223,806	191,441,790	191,441,790
Нийт	648,447,438	381,329,808	359,323,048	214,635,646

31 ХАРЬЦУУЛСАН ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт 7-г хэрэгжүүлэхийн тулд доор үзүүлсэний дагуу ангилсан 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх зарим харьцуулсан тоон үзүүлэлтүүдийг үзүүлснийг эс тооцвол тайлант жилийн санхүүгийн тайлангуудын толилуулга ба ангилал нь өмнөх тайлант жилийнхтэй адил байна.

	Өмнө илэрхийлснээр мян.төг	Залруулга мян.төг	Дахин илэрхийлснээр мян.төг
Орлого, үр дүнгийн тайлан			
Шимтгэл хураамжийн зардал	-	1,015,137	1,015,137
Бусад үйл ажиллагааны зардал	7,194,547	(1,015,137)	6,179,410

32 МОНГОЛ ХЭЛ ДЭЭРХ ОРЧУУЛГА

Эдгээр санхүүгийн тайлангуудыг мөн Англи хэл дээр бэлтгэсэн болно. Монгол, Англи хувиудын хооронд зөрүү ялгаа гарах тохиолдолд Англи хувийг дагах болно.

